

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2015 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САР

# Лиахона



**Аврагчийн  
ариун золиослолыг  
ойлгох нь, 34-р хуудас**

**Сул дорой байх нь яагаад нүгэл  
биш вэ? 20-р хуудас**

**Гэр бүлийн үдшээ хэрхэн амжилттай  
хийх вэ? 10, 80-р хуудас**





*“Та нарын дундаас хэн чинь зуун хоньтой байтал нэг нь алдагдахад ерэн есөн хонио бэлчээрт орхин алдагдсан хонины араас явж, түүнийг олтлоо хайдаггүй вэ?  
“Тэгээд хонио олбол, тэр баяртайгаар мөрөндөө тэгнэнэ.”*

Лук 15:4–5





## ЗАХИАСУУД

- 4 Тэргүүн Зөвлөлийн захиас  
бичиг: Ерөнхийлөгч Монсон  
зоригтой байхад уриалав  
Ерөнхийлөгч Томас С.Монсон
- 7 Айлчлагч багшийн захиас  
бичиг: Есүс Христийн зан  
чанарууд—Заль мэхгүй,  
хоёр нүүргүй

## ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

- 14 Эмэгтэйчүүдийн сүнслэг  
нөлөө  
Старла Авэркамп Батлэр  
*Эмэгтэйчүүд та нарын  
нөлөө нь харж чадахаас  
ч илүү байдаг.*
- 20 Сул дорой байх нь нүгэл биш  
Вэнди Улрич  
*Нүгэл ба сул дорой байдлыг  
ялгахад, мөн сул дорой байдлаа  
хэрхэн хүчирхэг болгоход  
сурам.*


- 26 Цэвэр ариун сүсэг бишрэл  
Ахлагч В.Кристофер Ваддэлл  
*Аминч бус үйлчлэлийн эдгээр  
гурван алхмыг унш.*
- 30 “Та надад үргэлж хэрэгтэй”  
Жонатан Х.Вэстовэр  
*Сүмийн дуулал дуулсан нь  
Солонгосын сонирхогч гэр бүлд  
бүхий л өөрчлөлтийг авчрав.*
- 34 Аврагчийн аминч бус  
хийгээд ариун золиослол  
Ерөнхийлөгч Бойд К.Пакэр  
*Бид Аврагчийн Цагаатгалаар  
дамжуулан нүгэл ба гэм  
буруугийнхаа сүнслэг  
тооцоог төлж чадна.*
- 80 Гэр бүлийн үдшийн  
100 жилийн ой  
*1915 онд ерөнхийлөгч Жозеф  
Ф.Смит болон түүний зөв-  
лөхүүд гишүүдэд гэр бүлийн  
үдшийн бүтэц, зорилго, адисла-  
луудыг тайлбарлаж, тэднийг  
гэр бүлийн үдэш хийхэд урив.*

## АЛБАД

- 8 Бид Христийн тухай ярьдаг:  
Итгэлийн хүч  
Амбэр Баров Даал
- 10 Бидний гэр орон, гэр бүл:  
Гэр бүлийн үдэш—Та нар  
үүнийг хийж чадна!
- 12 Сайн мэдээний сонгодог  
бүтээл: Тэр амилсан  
Ерөнхийлөгч Дэвид О.Маккэй
- 40 Хожмын үеийн гэгээнтнүү-  
дийн дуу хоолой

### ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн талд: *Эммаус хүрэх замд*, Лиз Лимон  
Свиндэл, хуулбарлаж болохгүй. Нүүрний  
дотор талын гэрэл зургийг Жим Жэффери.  
Дотор талын хавтсанд: Коди Бэллийн авсан  
гэрэл зураг.



44

#### 44 Итгэлтэй урагшил

Ахлагч Антони Д.Пэркинс  
Чухал шийдвэрүүд гаргах үедээ  
юу хийх хэрэгтэй талаар  
Нифайгаас суралц.



Энэ дугаарт  
нуусан  
Лиахонаг  
олоорой.  
Санамж:  
Чи лааг  
хаана асааж  
чадах вэ?



54

#### 49 Зурагт хуудас: Түүнийг эрэлхийл

#### 50 Иосефийн ачаар

Тэд Барнэс  
Бошиглогч Иосеф Смитийн  
ачаар таны амьдрал өөр бай-  
гаа доод тал нь зургаан арга  
зам байдаг.

#### 53 Амьд бошиглогч

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон

#### 54 Аврагчийн дуулгавартай байдлын үлгэр жишээ

Есүс Христийн бидэнд дага-  
хад зориулсан 9 арга зам

#### 58 Бидний орон зай

#### 60 Хэрхэн мэргэн ухаантай байх вэ

Ахлагч Нийл Л.Андэрсэн  
Дэлхийн мэргэн ухаан,  
Бурханы мэргэн ухаан  
хоёрын ялгаа нь юу вэ?


#### 61 Нүдээ олсон хариулт

#### 62 Хоньчин ба хонин сүрэг

Хоньчны ажлыг илүү сайн  
ойлгох нь биднийг Аврагчтай  
илүү ойртуулж чадна.

#### 64 Асуулт, хариулууд

Би өөрийн асуудал ба санаа  
зовоосон зүйлийнхээ талаар  
бишоптойгоо ярилцахын тулд  
хэрхэн тайван байж чадах вэ?



75

#### 66 Чиний баатар хэн бэ?

Чарлотт Мэй Шэппард  
Элли өөрийнхөө жинхэнэ  
баатрыг хэн болохыг ангийн-  
хандаа хэлэхээс айж байв.

#### 68 Залбирал ба дуган сүм

Макэлли Жорж  
Дани Английн нэгэн дуган сүмд  
айлчлан очихдоо залбирлын  
талаар нэгэн чухал хичээл  
сурчээ.

#### 70 Онцгой гэрч: Дуулгавартай байх нь яагаад тийм чухал байдаг вэ?

Ахлагч Рассэлл М.Нэлсон

#### 71 Өөдрөг санаа

#### 72 Судрын цаг: Есүс уяман өвчтөнг эдгээв

Эрин Сандэрсон

#### 74 Судрын онцлох сэдвүүд: Есүс өвчтэй хүмүүсийг эдгээв

#### 75 Зөв зам

Ахлагч Клаудио Д.Зивик  
Зөв замыг дагах нь бүхнийг  
өөрчилдөг.

#### 76 Бага насны хүүхдүүдэд зориулав: Есүс надад хайртайг би мэднэ

Жэйн Макбрайд Чөүт



## 2015 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРЫН ДУГААР, 16, №2 ЛИАХОНА 12564 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн  
Сүмийн олон улсын сэтгүүл

**Тэргүүн Зөвлөл:** Томас С.Монсон, Хэнри Б.Айринг,  
Дийтр Ф.Угдорф

**Арванхоёр Төлөөлөгчийн чуулга:** Боид К.Пакэр,  
Л.Том Пэрри, Рассэл М.Нэлсон, Даллин Х.Өүкс,  
Л.Рассэл Баллард, Ричард Г.Скотт, Робэрт Д.Хэйлс,  
Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күк,  
Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн

**Эрхлэгч:** Крэйг А.Кардон

**Зөвлөхүүд:** Мэрвин Б.Арнолд, Кристоффэл Гоулдэн,  
Ларри Р.Лоурэнс, Жэймс Б.Мартини, Иосеф В.Ситати

**Удирдах захирал:** Дэвид Т.Варнэр

**Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:**  
Винсент А.Ваун

**Сүмийн сэтгүүлийн захирал:** Алан Р.Лоиборг

**Бизнесийн менежер:** Гарфф Каннон

**Гүйцэтгэх редактор:** Р.Вал Жонсон

**Гүйцэтгэх захирлын туслах:** Раян Карр

**Хэвлэлийн туслах:** Лиза Кэролин Лопэз

**Редакцийн баг:** Бриттани Бийти, Дэвид Диксон,  
Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фүллэр,  
Гаррэт Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Минди Аннэ  
Лийвигт, Майкл Р.Моррис, Салли Жонсон Оджерк,  
Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороу, Ричард М.Ромни,  
Пол Вандэнбэрг, Марисса Виддисон

**Зураглал чимэглэлийн удирдагч менежер:**

Ж.Скотт Кнудсэн

**Зураглал чимэглэлийн удирдагч:** Тадд Р.Петрсон

**Уран бүтээлийн ажилтнууд:** Жанэтт Эндрьюс, Фэй  
П.Андрус, Мэндэл М.Бэнгли, С.Кимбалл Ботт, Том Чайлд,  
Нэйт Гайнс, Коллийн Хинкли, Эрик П.Жонсн, Сюзан  
Лодфрэн, Скотт М.Моой, Марк В.Робисон, Брад Тиэри,  
П.Никол Вокэнорст

**Оюуны өмчийн зохицуулагч:** Жэйн Анн Пэтэрс

**Хэвлэлийн захирал:** Жэйн Анн Пэтэрс

**Хэвлэх баг:** Конни Вауторп Бриж, Жоли Бардэтт, Кэти  
Данкан, Брайн В.Гайги, Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон,  
Гэйл Тэйт Раффэрти

**Хэвлэлийн захирал:** Крэйг К.Сэдвик

**Хуваарилалт хариуцсан захирал:** Эван Ларсэн, Нэгдсэн  
Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн  
талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог,  
салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

**Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт**  
liahona.lds.org; шуудангаар Liahona, Rm. 2420,  
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA  
хаяагаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаяагаар  
ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол “луужин”  
буюу “залагч”) албани, англи, армен, бислам, болгар,  
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,  
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,  
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,  
свахили, самоа, себуано, солонгос, тагало, тай, тахити,  
тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват,  
хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр  
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр  
байна.)

© 2015 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.  
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой  
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт  
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг  
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиан олшруулж  
болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual  
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,  
UT 84150, USA хаяагаар; эсвэл электрон шуудангийн:  
cor-intellectualproperty@ldschurch.org хаяагаар ирүүлнэ үү.

**For Readers in the United States and Canada:**

April 2015 Vol. 16 No. 2. LIAHONA (USPS 311-480) Mongolian  
(ISSN 1525-7584) is published six times a year (January, April,  
June, July, October, and December) by The Church of Jesus  
Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City,  
UT 84150. USA subscription price is \$5.00 per year; Canada,  
\$6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake  
City, Utah. Sixty days' notice required for change of address.  
Include address label from a recent issue; old and new address  
must be included. Send USA and Canadian subscriptions to Salt  
Lake Distribution Center at address below. Subscription help  
line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard,  
American Express) may be taken by phone. (Canada Poste  
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 707.4.12.5).  
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes  
to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,  
Salt Lake City, UT 84126-0368, USA.

# Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглаж болох өгүүлэл, үйл ажиллагаануудыг  
оруулсан. Доор хоёр жишээ өгөгдсөн болно.



## “Та надад үргэлж хэрэгтэй” 30-р

хуудас: “Та надад үргэлж хэрэгтэй” дуул-  
лын үгс Пак Ми-Жүнгт баптисм хүртэх  
шийдвэр гаргахад тусалсан шиг сүмийн  
дуулууд нь бидний амьдралд хүчирхэг  
нөлөө үзүүлж чадна. Дууллын үгс таны  
амьдралыг адисалсан тэр үеийг бодож,  
гэр бүлийнхэнтэйгээ туршлагаасаа  
хуваалцах талаар бод. Гэр бүлийн гишүүн  
бүрийг дуртай дууллаа сонгож, энэ нь  
түүний амьдралыг хэрхэн адисалсан  
талаар хуваалцахад урь. Дараа нь дуулал  
бүрийг гэр бүлийнхэнтэйгээ хамт дуул.  
(Та энэ үйл ажиллагааг хоёр долоо хоног  
хийж болох юм.)

## “Залбирал ба дуган сүм” 68-р хуудас:

Та энэ түүхийг уншсаныхаа дараа танай  
хотод байдаг өөр сүмүүдийн зургийг  
үзүүлж, эсвэл дурдаж болох юм. Бас би-  
дэнд болон бусад шашинд байдаг зарим  
ижил төстэй зүйлийн талаар гэр бүлийн-  
хэнтэйгээ ярилцаж болно: Тэнгэрлэг Эцэг  
бүх хүүхдийнхээ талаар юу гэж боддог вэ?  
Бид өөр итгэл үнэмшил бүхий хүмүүстэй  
хэрхэн харьцах ёстой вэ? Эдгээр асуултад  
хариулахад туслахын тулд Арванхоёр  
Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин  
Х.Өүксийн “Balancing Truth and Tolerance”  
өгүүллийг ашиглах талаар бодож үзнэ үү  
(Лиахона, 2013 оны 2-р сар, 28–35).

## ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиахона болон Сүмийн бусад материалыг олон хэлээр [languages.lds.org](http://languages.lds.org) хаяагаар  
орж үзэж болно.

## ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг заана.

**Амилалт, 12, 49**

**Ариун Сүнс, 30, 41, 42,  
43, 44, 50, 58**

**Ариун сүмийн ажил,  
30, 43**

**Бошиглогчид, 53**

**Бурханлаг шинж  
чанар, 58**

**Гэмшил, 20, 34**

**Гэр бүл, 10, 50**

**Гэр бүлийн үдэш, 10, 80**

**Дуулгавартай байдал,  
44, 54, 58**

**Дуу хөгжим, 30, 40**

**Есүс Христ, 7, 8, 12, 20,  
26, 34, 49, 54, 62, 66, 72,  
74, 76**

**Залбирал, 68**

**Зарлигууд, 70, 75**

**Зориг, 4**

**Иосеф Смит, 12, 50**

**Итгэл, 8, 20, 44**

**Мацаг барих нь, 30**

**Наманчлал, 34, 64**

**Номлогчийн ажил, 30, 40**

**Нүгэл, 20, 34**

**Өршөөл, 20, 34**

**Порнограф, 34**

**Санваар, 50**

**Сатан, 34, 61**

**Сонгох эрх, 4, 20, 44**

**Сэргээлт, 50**

**Сүмийн удирдагчид,  
53, 64**

**Уй гашуу, 30, 41**

**Үйлчлэл, 26, 42**

**Үлгэр жишээ, 14, 66**

**Үхэл, 30, 41**

**Хайр, 76**

**Хөрвөлт, 30**

**Цагаатгал, 20, 34, 49**

**Шийдвэрүүд, 44, 60, 75**

**Шинэ Гэрээ, 54, 62, 72, 74**

**Эдгээлт, 8, 72, 74**

**Эмэгтэйчүүд, 14**





Ерөнхийлөгч  
Томас С.Монсон


# Ерөнхийлөгч Монсон ЗОРИГТОЙ БАЙХАД уриалав

*Ямар нэгэн сонголт хийлгүй өнгөрөх цаг хором гэж бараг үгүй билээ хэмээн ерөнхийлөгч Томас С.Монсон хэлжээ.*

*Ухаалаг сонголт хийхийн тулд “Үгүй гэж, мөн тийм гэж хэлэх зориг хэрэгтэй болдог гэж тэрээр зөвлөсөн. Сонголтууд бидний хувь тавиланг тодорхойлдог.”<sup>1</sup>*

*Ерөнхийлөгч Монсон дараах эшлэлүүдээрээ хожмын үеийн гэгээнтнүүдэд хандан, мөнхийн үнэ цэнэтэй зүйлүүд ба зарчмуудыг эсэргүүцэж буй дэлхийтэй тэмцэх, үнэн ба зөв шударгын төлөө зогсож, итгэдэг зүйлээ хамгаалах зориг хэрэгтэйг анхааруулдаг.*

*“Зоригтой байх уриа нь бидний хүн нэг бүрд байнга ирдэг” гэж тэр хэлжээ. “Энэ нь хэзээд ийм байсаар ирсэн бөгөөд ямагт ийм байх болно.”<sup>2</sup>*





### Зориг нь Бурханы сайшаалыг авчирдаг

“Бид бүгд айдас, доог тохуурхал, эсэргүүцэлтэй тулгарах болно. Бүгдээрээ, мөн хүн бүр нийтэд дэлгэрсэн зүйлийг дагах биш, харин зөв зарчмын төлөө зогсох зоригтой байцгаая. Бууж өгөх нь бус, харин урам зориг нь биднийг Бурханы сайшаалаар адисалдаг. Зориг нь зөвхөн баатарлагаар амь үрэгдэхэд бэлэн байхад бус, зөв амьдрах шийдвэр төгс байх үед амьд бөгөөд сэтгэл татам чанар болдог. Бид урагш тэмүүлж, зохих зарчмуудын дагуу амьдрах гэж хичээснээр Их Эзэнээс тусламж хүлээн авч, Түүний үгсээс тайтгарлыг олж чадах нь гарцаагүй.”<sup>3</sup>

### Зоригтой сөрөн зогс

“Тэвчих гэдэг нь юу гэсэн үг вэ? Би *зоригтой сөрөн зогс* хэмээх энэхүү тодорхойлолтод дуртай: Та нарын хувьд итгэлтэй байхад зориг шаардлагатай байж болох ба дуулгавартай байхад ч заримдаа зориг шаардагдана. Та нарыг энэ мөнх бус амьдралаа орхих тэр өдрийг хүртэл эцсээ хүртэл тэвчихэд зориг шаардагдах нь тодорхой.”<sup>4</sup>

### Үнэний төлөө зогсох зоригтой бай

“Та нар үнэн ба зөв шударгын төлөө тууштай зогсох зоригтой байх болтугай. Өнөөгийн нийгмийн чиг хандлага Их Эзэний бидэнд өгсөн эрхэмлэх зүйл, зарчмуудаас холдсон учраас бид итгэдэг зүйлээ хамгаалахаар дуудагдах нь үндсэндээ тодорхой юм. Та нарын гэрчлэлийн үндэс бат бөх суулгагдаагүй л бол итгэлийг тань сорих хүмүүсийн доог тохууг сөрөн зогсоход та нарт хэцүү байх болно. Энэ нь бат бөх суулгагдсан үед Тэнгэрлэг Эцэг, Аврагч болон сайн мэдээний талаарх та нарын гэрчлэл амьдралынхаа турш хийх бүх зүйлд тань нөлөөлнө.”<sup>5</sup>

### Бидэнд сүнслэг бөгөөд ёс суртахууны зориг хэрэгтэй

“[Өнөөдөр] телевиз, кино болон бусад мэдээллийн хэрэгслээр үзүүлж буй мэдээллүүд нь бидний хүүхдүүдээ хүлээн авч, эрхэмлэн нандигнаасай гэж хүсдэг тэдгээр зүйлийн эсрэг байх нь олонтоо тохиолддог. Тэдэнд зөвхөн сүнслэг зүйлүүд ба сургаалыг заах төдийгүй, тохиолдож болох гадны хүчнүүдээс үл хамааран уг зам дээрээ хэрхэн үлдэхийг заах нь бидний үүрэг билээ. Өөрийн хийвэл зохих зүйлсийг хийхэд их цаг хугацаа, хүчин чармайлт шаардах болно. Бид бусдад туслахын тулд хаана ч байлаа гэсэн нүгэл хилэнцийг эсэргүүцэх сүнслэг болоод ёс суртахууны зоригтой байх хэрэгтэй.”<sup>6</sup>

### Бид ямагт эр зоригтой байх болтугай

“Биднийг амьдарч байгаа үед бидний итгэл соригдох нь бараг л зайлшгүй юм. Бид заримдаа аль нь зөв, аль нь буруу эсэх талаарх үзэлд цөөнх байж, тэр ч байтугай өөрсдийн үзэл бодолд ганцаараа зогсох тийм үе ирнэ. . . .

“Бид өөрсдийнхөө итгэдэг зүйлсийн төлөө зогсох зоригтой, мөн бэлтгэлтэй байх болтугай. Хэрэв бид ганцаар зогсох хэрэгтэй болсон үед, би Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт байхад хэзээ ч ганцаардахгүй гэсэн бодит мэдлэгээр хүчирхэгжин, үүнийг зоригтой хийх болтугай.”<sup>7</sup> ■

### ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Та зааж байгаа хүмүүсээсээ ирэх долоо хоногт гэр орон, ажил, сургууль дээрээ, эсвэл сүм дээр тэднээс зориг гарган үйлдэхийг шаардах ямар нэгэн нөхцөл байдлын талаар бодож олохыг хүс. Тэд айдастай тулгарч, ямар нэгэн хэцүү зүйлийг тэвчин, итгэл үнэмшлийнхээ төлөө зогсохыг, эсвэл сайн мэдээний аливаа зарчимд илүү бүрэн дүүрэн дуулгавартай байхыг сонгож болох юм. Тэднийг бодлоо хуваалцаж, бичиж тэмдэглэхэд урь.

### ЭШЛЭЛҮҮД

1. Томас С.Монсон, “Турван сонголт,” *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 67, 68.
2. Томас С.Монсон, “Зоригтой байх дуудлага,” *Лиакхона*, 2004 оны 5-р сар, 55.
3. Томас С.Монсон, “Хүчтэй бөгөөд зоригтой бай,” *Лиакхона*, 2014 оны 5-р сар, 69.
4. Томас С.Монсон “Итгэ, дуулгавартай бай, тэвч,” *Лиакхона*, 2012 оны 5-р сар, 129.
5. Томас С.Монсон, “Та нар зоригтой байж болохын тулд,” *Лиакхона*, 2009 оны 5-р сар, 126.
6. Томас С.Монсон, “Таныг удирдах гурван зорилго,” *Лиакхона*, 2007 оны 11-р сар, 118–119.
7. Томас С.Монсон, “Ганцаар зогсох зоригтой бай,” *Лиакхона*, 2011 оны 11-р сар, 60, 67.

## Өөр хэн нэгний Сара

Маккэнзи Миллэр

“Чи яагаад кофе уудаггүй юм бэ?” гэх мэт энгийн асуултад хариулахдаа өөрийнхөө итгэлийг ашиглах надад хэцүү байдаг байв. Өмнө нь би “Дэндүү гашуун байдаг юм,” эсвэл “Би амтанд нь дургүй” гэх мэт шалтгууд хэлдэг байлаа.

Би яагаад ичдэг байсан юм бол? Би яагаад итгэдэг зүйлээ хамгаалахаас айдаг байсан юм бол? Өнгөрснөө эргээд харахад, би яг юунаас айдаг байснаа ойлгодоггүй юм. Гэхдээ би яг хэзээ шалтаг хэлэхээ больсноо санадаг.

Нэг өдөр ахлах сургуулийнхаа англи хэлний хичээл дээр сууж байтал багш бидэнд ТВ-ийн цуврал шоу нэвтрүүлэг үзүүлэх гэж байгаагаа хэлэв. Би үүнийг үзэж болохгүй гэдгээ мэдэж байлаа. Бусад сурагчийг баярлалдан хөөрөлдөж байхад манай ангийн Сара гараа өргөн, би гарч болох уу гэж асуув.

Багшийг яагаад гэж асуухад Сара “Би мормон учраас

хараалын үгтэй шоу нэвтрүүлэг үздэггүй” гэж тодорхой хариулсан юм.

Ангийнхныхаа өмнө гаргасан түүний зориг гайхалтай байв. Сарагийн ачаар би ч бас босоод, ямар нэгэн гэмших шалтгаангүйгээр шоу нэвтрүүлэг дуусахыг гадаа гарч хүлээлээ.

Би бүрмөсөн өөрчлөгдсөн юм. Би асуудлаас зайлсхийхийн оронд итгэл үнэмшлээ тайлбарладаг болсон. Үүний үр дүнд би өөртөө итгэлтэй болж, Сүмийн болон сургуулийн үйл ажиллагаануудад илүү идэвхтэй оролцдог болов.

Сарагийн үлгэр жишээ миний хувьд ямар их утга учиртай зүйл байсныг би түүнд хэзээ ч хэлж байгаагүй боловч түүний итгэлтэй байдлын үлгэр жишээг үргэлж дуурайхыг хичээдэг. Бурханы гайхалтай, ариун Сүмийн гишүүн байх нь ичих зүйл үнэхээр биш гэдгийг би одоо ойлгосон. Би үлгэр дуурайлаараа хэн нэгний хувьд Сара шиг үлгэр жишээ нь байж чадна гэдэгтээ итгэдэг.

*Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.*

## ХҮҮХДҮҮДЭД

### Судрууд дахь зориг

Ерөнхийлөгч Монсон бидэнд зоригтой байж, итгэдэг зүйлийнхээ төлөө бат зогс хэмээн заадаг. Зоригтой байсан хүмүүсийн үлгэр жишээнүүд судрууд дээр олон байдаг. Нэр бүрийн дэргэд байгаа судрыг унш. Энэ хүмүүс хэрхэн зоригтой байж, зөв гэж мэддэг зүйлийнхээ төлөө зогссон бэ?

Хариултуудаа бичихдээ, эсвэл зурахдаа зайнуудыг ашигла.

Иосеф Смит (Иосеф Смит—Түүх 1:11–17)

Даниел (Даниел 6:7, 10–23)

Лемен үндэстэн Самуел (Хиламан 13:2–4; 16:1–7)

Естер (Естер 4:5–14; 5:1–8; 7:1–6)



Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхийг эрэлхийл. Аврагчийн амьдрал ба үүргийг ойлгох нь хэрхэн Түүнд итгэх итгэлийг тань нэмэгдүүлж, айлчлагч багшийн ажлаар дамжуулан харж ханддаг хүмүүсийн тань амьдралыг адислах вэ? Нэмэлт мэдээлэл авах бол [reliefsociety.lds.org](http://reliefsociety.lds.org) хаягаар орж үзнэ үү.

## Есүс Христийн зан чанарууд: Заль мэхгүй буюу хоёр нүүргүй

Энэ бол Аврагчийн онцлог зан чанаруудын талаарх Айлчлагч багшийн цуврал захиасуудын нэг хэсэг болно.

Есүс Христ бол заль мэхгүй бөгөөд хоёр нүүргүй гэдгийг ойлгох нь Түүний үлгэр жишээг дагахаар итгэлтэйгээр хичээхэд бидэнд тусална. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жозеф Б.Вертлин (1917–2008): “Мэхлэх гэж хуурах эсвэл төөрөгдүүлэхийг хэлдэг. . . . Заль мэхгүй хүн нь гэм зэмгүй, үнэнч шударга санаа бодолтой, цэвэр ариун эрмэлзэлтэй хүн бөгөөд түүний амьдрал өдөр тутмын үйлдлүүдээ зөв шударга ёсны зарчмуудтай нийцүүлж буй энгийн үйл хэргийг харуулдаг. . . . Сүмийн гишүүдийн хувьд заль мэхгүй байх нь хэзээ хэзээнээс илүү тулгамдаад байгаа асуудал гэдэгт би итгэдэг. Учир нь дэлхий дээр маш олон хүн энэ ариун журмын ач холбогдлыг ойлгодоггүй нь илэрхий байна” гэж хэлжээ.<sup>1</sup>

Хоёр нүүртний талаар Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Дийтр Ф.Угдорф: “Бид Христтэй адил байх



хэрэгтэй гэдгээ мэддэг ч хэн маань ч хараахан адил биш юм. Гэвч бид өөрсдийн алдааг болон нүгэл үйлдэх хандлагаа орхихыг чин сэтгэлээсээ хүсдэг. Бид Есүс Христийн Цагаатгалын тусламжтай илүү сайн хүмүүс болохыг бие махбод ба зүрх сэтгэлээсээ эрмэлздэг”<sup>2</sup> гэж хэлжээ.

“Бид өөрсдийн үйлдлүүд, зүрх сэтгэлийн хүслүүд болон ямархуу маягийн хүмүүс болох ёстой, түүгээрээ шүүгдэх болно”<sup>3</sup> гэдгийг бид мэднэ. Бид наманчлахаар хичээхийн хэрээр илүү цэвэр ариун болох бөгөөд “зүрхэн дотроо цэвэр ариун байгч хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд Бурханыг харах болно” (Матай 5:8).

### Нэмэлт судрууд

Дуулал 32:2; Иаков 3:17;  
1 Петр 2:1–2, 22.

#### ЭШЛЭЛҮҮД

1. Жозеф Б.Вертлин, “Personal Integrity,” *Ensign*, 1988 оны 5-р сар, 80, 81.
2. Дийтр Ф.Угдорф, “Ирж, бидэнтэй нэгд,” *Лиакхона*, 2013 оны 11-р сар, 23.
3. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 1.2.1.



Итгэл, гэр бүл,  
халамж

### Судруудаас

Бяцхан хүүхдүүд заль мэхгүй байдаг. Есүс Христ: “Хүүхдүүдийг над руу ирэхийг зөвшөөр, Тэднийг бүү хорь. Учир нь Бурханы хаанчлал бол тэдэн шиг хүмүүсийнх юм” гэжээ. “. . . Есүс [хүүхдүүдийг] тэвэрч, тэдэн дээр мутраа тавиад ерөөв” (Марк 10:14, 16).

Христ мөн цовдлогдсоныхоо дараа Америк дахь хүүхдүүдэд тохинуулав. Тэрээр “хүмүүсийг бяцхан хүүхдүүдээ Түүн дээр авчирч мөн тэднийг түүний эргэн тойронд газарт доош тавихыг” зарлиглав; мөн Есүс тэдний дунд зогсов; . . .

“. . . [Мөн] тэрээр уйлж, мөн олон түмэн үүнийг гэрчлэв, мөн тэрээр тэдний бяцхан хүүхдүүдийг нэг нэгээр нь авч, мөн тэднийг адислав, мөн тэдний төлөө Эцэгт хандан залбирав. . . .

“Мөн тэд болгоохоор харахдаа харцаа тэнгэрийн зүг хандуулж, мөн . . . тэд тэнгэр элчүүд тэнгэрээс галын дунд байгаа мэт доошлон ирэхийг үзэв; мөн тэд доош ирж, багачуудыг эргэн тойрон хүрээлж, . . . мөн тэнгэр элчүүд тэдэнд тохинуулав” (3 Нифай 17:12, 21, 24).

### Үүнийг эргэцүүлэн бод

Заль мэхгүй байх талаар бяцхан хүүхдүүдээс бид юу сурч болох вэ? (Судруудын удирдамжаас “Заль мэх” хэсгийг үзнэ үү.)

# ИТГЭЛИЙН ХҮЧ

Амбэр Балов Даал

*Тэнгэрлэг Эцэг биднийг гуйсан болохоор л сорилт бэрхшээлүүдээс маань шууд чөлөөлчихсөн байсан бол бидний авралд зайлшгүй шаардлагатай тэрхүү туршлагуудаас биднийг холдуулах байсан.*

Коллежид сурч байсан нэг жил намайг шалгалт өгч байтал хүзүү маань өвдөж эхэлсэн юм. Шалгалт дууссан ч өвдөлт намдахгүй байв. Би эмч нартай болон физик эмчилгээний эмч нартай зөвлөлдөж, олон төрлийн эмчилгээ хийлгэсэн ч өвдсөөр л байлаа. Дараа жил нь би энэ өвчнөө эдгээх гэж тэмцэлдэхийн зэрэгцээ итгэлээ нэмэгдүүлэхээр хичээж байлаа. Би олон удаа залбирч, судруудыг судлан, санваарын адислалууд авсан. Хэрэв би хангалттай итгэлтэй л байвал эдгэрнэ гэж бодож байлаа.

Есүс Христ өвчтэй, сохор, доглон, уяман өвчтэй хүмүүсийг “[тэдний] итгэлийн дагуу” (Матай 9:29) эдгээж байсан. Тэрээр мөнх бус амьдралынхаа турш маш олон хүнийг эдгээсний нэгэн адил намайг эдгээх хүчтэй гэдгийг би мэдэж байсан юм. Бага итгэлтэй байгаа минь намайг эдгээхгүй байна гэж үзсэн учраас би илүү их хичээж эхлэв. Би физик эмчилгээ хийлгэж байхдаа залбирч, мацаг барин, сургаалаас судалж, бас итгэж байлаа. Гэсэн ч миний өвчин хэвээрээ л байв.

Бид итгэлээр дамжуулан гайхамшиг үйлдэж чадна хэмээн судрууд заадаг ч (Матай 17:20) би энэ өчүүхэн зөвлонгоосоо чөлөөлөгдөж чадахгүй л байлаа. Миний итгэлийн хүч хаана байсан юм бол? Би эцэст нь нөхцөл байдлыг даруухнаар хүлээн авч, ая тухгүй байдлаа даван туулах арга замуудыг олж, хэзээ нэг өдөр итгэл ба эдгээлтийн талаар

бүрэн ойлголттой болно гэдгээ ухаарсан юм.

Түүнээс хойш хэдэн жилийн дараа, би нэг найзтайгаа ярилцаж байлаа. Анх жирэмсэн байх үедээ тэрээр маш их хордлого өгч, үүнээсээ болж олон удаа эмнэлэгт очих шаардлагатай болж байж. Эрин дахин хүүхэдтэй болохыг хүсэж байсан ч эхний удаа жирэмсэн болоход түүнд тохиолдсон тавгүй мэдрэмжийг дахин тэсвэрлэхээс айж байв. Тэр мацаг барьж, залбирч байгаагаа, мөн Тэнгэрлэг Эцэг үүнийг хоёрдахь удаагаа түүнээс хүсэхгүй гэдэгт үнэхээр итгэлтэй байгаагаа надад хэлсэн юм.

Биднийг ярилцаж байхад: “Тэмцэлдэхээ больж, намайг Бурхан гэдгийг мэд” (Дуулал 46:10) гэсэн нэг судрын эшлэл санаанд орж ирж билээ. Би зовлон бэрхшээл дунд тэмцэлдэхээ болиход суралцаж буй өөрийн туршлагын талаар бодлоо. Тэгээд Эринд үргэлжлүүлэн итгэлтэй байж, дараагийн удаа жирэмслэхдээ хордлоготой тэмцсэн ч итгэлтэй хэвээр байхыг ятгав.

Би итгэлийн зарчмыг үргэлжлүүлэн судалж байхдаа “хэрэв та нар итгэлтэй аваас та нар үнэн хийгээд үл харагдах зүйлүүдэд найдах болно” (Алма 32:21) хэмээн заасан Алмагийн үгийг олж уншсан юм.



## ЗОВЛОН БЭРХШЭЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ НЬ

“Бидний даван туулах зовлон бэрхшээл, амжилттай гүйцэтгэх үүрэг хариуцлага, бидний булчинг чангалах ажил хөдөлмөр, мөн бидний бодгалийг сорих уй гашуу зэргийг бидэнд өгсөн нь Тэнгэрлэг Эцэгийн мэргэн ухаан биш гэж үү? Бидний хүч чадлыг сорихын тулд уруу таталтууд, биднийг тэвчээртэй байдалд сургахын тулд өвчин эмгэг, мөн бид мөнхөрч улмаар алдаршуулагдахын тулд үхэл бидэнд тохиолддог бус гэж үү?”

“Хэрэв бидний эдгээсэй гэж залбирдаг өвчтэй хүмүүс эдгэрч, зөв шударга бүх хүн хамгаалагдаж, ёс бусчууд устгагдвал Эцэгийн төлөвлөгөө бүхэлдээ ашиггүй болж, сайн мэдээний үндсэн зарчим болох чөлөөт сонголт нь төгсгөл болно. Хэн ч итгэлээрээ амьдрах шаардлагагүй болох байсан.”

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985), *Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* (2006), 15.





Энэ судрыг тунгаан бодох үед итгэл нь миний бодсон тэр зүйл биш байсныг би олж мэдэв. Алмагийн бидэнд заасан итгэл нь үнэн зарчмууд дахь найдвар байв. Итгэлтэй байна гэдэг нь Тэнгэрлэг Эцэг маань бидний асуусан цагт хүссэн зүйлийг маань үргэлж өгнө гэсэн үг биш юм. Христ миний хүзүүг эдгээх болно, эсвэл Тэр Эриний жирэмслэлтийг хордлогогүй байлгах болно гэдэгт итгэх нь үнэн зарчмуудад итгэлтэй байгаа хэрэг биш билээ. Гэсэн хэдий ч, бид Христ эдгээх хүчтэй, Тэр бидэнд санаа тавьдаг, мөн Тэр биднийг хүчирхэгжүүлэх бөгөөд хэрэв бид үүнийг дажгүй давбал бид мөнх амьдралыг хүлээн авахуйц зохистой болно гэдэгт итгэлтэй байж болно.

“Чи Христийн нэрээр хүлээн авах болно хэмээн найдаж итгэлтэйгээр гуйсан юуг ч болов, чи хүлээн авах

болно” (Инос 1:15) хэмээн Их Эзэн амласан. Энэ амлалттай холбоотой хүчийг “Христийн нэрэнд” итгэх зөвлөгөөгөөр олж авдагт би итгэдэг. Библийн толь бичигт залбирлын талаар бидэнд: “Бидний оюун санаа Христийн оюун санаа байж, бидний хүсэл Христийн хүсэл байхад—Түүний үгс бидний дотор байхад бид Христийн нэрээр залбирдаг (Иохан 15:7) гэж заажээ. Дараа нь бид Бурханы өгөх боломжтой зүйлсийг гуйдаг. Христийн нэрэн дээр биш учраас олон залбирал хариулагдахгүй үлддэг. Тэдгээр нь Түүний оюун санааг огт төлөөлдөггүй бөгөөд хүмүүний зүрхний аминч байдлыг илэрхийлдэг.”

Биднийг Бурханы хүслийн дагуу ямар нэгэн зүйлийг итгэлтэйгээр гуйх үед Тэр бидэнд хүслийн маань дагуу зөвшөөрөх болно. Тэнгэрлэг

Эцэг биднийг мэддэг, хайрладаг бөгөөд Түүний дэргэд эргэн ирэхэд шаардлагатай бүх зүйлийг хүсдэг билээ. Энэ нь заримдаа зовлон зүдгүүр, гай зовлон, сорилт бэрхшээлтэй байдаг (1 Петр 1:7-г үзнэ үү). Тэнгэрлэг Эцэг биднийг гуйсан болохоор л сорилт бэрхшээлүүдээс маань шууд чөлөөлчихсөн байсан бол бидний авралд зайлшгүй шаардлагатай тэрхүү туршлагуудаас биднийг холдуулах байсан. Бид Бурханы бидэнд зориулсан төлөвлөгөөнд итгэж, Түүнд өөрсдийнхөө хүслийг захируулж сурах ёстой. Бид өөрсдийн хүслийг Түүний хүсэлтэй нийцүүлэн, Түүнээс бүрэн хамааралтай гэдгээ хүлээн зөвшөөрөх үед “итгэлийнхээ үр дүнд сэтгэлийн авралыг” (1 Петр 1:9) олж авахуйц зохистой байх болно. ■

*Зохиогч нь АНУ-ын Орегонд амьдардаг.*

# ГЭР БҮЛИЙН ҮДЭШ— ТА НАР ҮҮНИЙГ ХИЙЖ ЧАДНА!

*Танай гэр бүл ямар байгаагаас үл хамааран гэр бүлийн үдэш нь та нарыг адисалж, хүчирхэгжүүлж чадна.*

Ажлын урт өдрийн дараа аав нь гэртээ ядарч ирээд, гэрийнхэн нь бас түүнтэй адил цухалдуу мэдрэмжтэй байгааг олж мэдэв. Өнөөдөр даваа гаргийн үдэш бөгөөд гэр бүлийн үдэш хийх боломжгүй санагдаж байлаа. Тусламж хүсэн залбирсны дараа эцэг эх нь үүнийг тун энгийн хийхээр шийдэв. Тэд гэр бүлийнхнээ бүгдийг дуудаж, Сүмийн дуулал дуулж, хамтдаа залбирав. Эцэг эх нь саяхан сүнслэгээр нөлөөлсөн ямар нэгэн зүйлээ тэдэнд хэлэх үедээ хүн бүрд асаах жижиг лаанууд өгчээ. Харанхуй өрөөнд лаануудын гэрэл нь сүнслэг удирдамжийг төлөөлж, хүүхдүүдийн анхаарлыг татав. Тэднийг гэрчлэлүүдээ хуваалцах үед гэрт амар амгалангийн болон хайрын гайхалтай мэдрэмж мэдрэгдэж байв. Тэд гэр бүлийн үдшээ хийсэндээ талархаж, гэр оройг өндөрлөсөн юм.

Гэр бүлийн үдэш 100 жилийн турш Сүмийн нэгэн хөтөлбөр болж хэрэгжиж байгааг та нар мэдэх үү? 1915 оны 4-р сард Тэргүүн Зөвлөл гишүүдийг долоо хоног бүрийн нэг оройг гэр бүлийн залбирал, хөгжим, сайн мэдээнээс суралцах, мөн түүх, үйл ажиллагаа зэрэгт зориулах удирдамж өгчээ. (Тэргүүн Зөвлөлийн захиас бичгээс хэсэгчлэн авсан хэсгийг 80-р хуудсаас үзнэ үү.) Бошиглогчид гэр бүлийн үдшийн чухал ач холбогдлын талаар бидэнд

анхааруулсаар байна. Ерөнхийлөгч Томас С.Монсон “Бид тэнгэрээс сүнслэг удирдамжаар ирсэн энэ хөтөлбөрийг үл тоомсорлож болохгүй” гэжээ. “Энэ нь хаа сайгүй байгаа тэрхүү уруу таталтуудыг сөрөн зогсоход гэр бүлийн гишүүдэд туслан, сүнслэг өсөлтийг хүн бүрд авчирч чадна.”<sup>1</sup>

Та нар гэр бүлийн үдшийг долоо хоногийнхоо нэг хэсэг болгосноор санаж байх ёстой зарим хандлага байдаг.

*Энэ нь надад ч хэрэгждэг.* “Гэр бүлийн үдэш нь хүн бүрд зориулагдсан зүйл юм”. Бид бүгд—гэрлэсэн, гэрлээгүй, хүүхдүүдтэй эсвэл хүүхэдгүй байлаа ч гэр бүлээ хүчирхэгжүүлж, сайн мэдээнээс суралцахад цаг заваа зориулж чадна гэж Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Л.Том Пэрри хэлсэн.<sup>2</sup>

*Би цаг гаргаж чадна.* Сүм даваа гаргийн орой ямар ч үйл ажиллагаа хийхгүй байснаар үлгэр жишээ үзүүлдэг. Та нар хамгийн чухал зүйлийнхээ төлөө цаг гаргах хүсэлтэй байгаагаа Их Эзэнд болон гэр бүлийнхэндээ харуулж чадна.

*Би гэр бүлдээ тохирох арга замыг олж чадна.* Хэрэв гэр бүлийнхэн чинь өөр өөр газар байгаа бол гэр бүлийн гишүүдтэйгээ онлайнаар эсвэл утсаар ярьж, “гэр бүлийн онлайн үдэш” ч хийж болно. Хэн нэгэн нь орой болтол ажиллах шаардлагатай байдаг уу? Завсарлагаанаар

нь ажлын байрных нь ойролцоо очиж, “гэр бүлийн цэцэрлэгт үдэш” хий. Салсан нэгэн эцэг хол амьдардаг хүүхдүүдээ захидал бичин, даваа гараг бүр “гэр бүлийн захидалтай үдэш” хийдэг байв.<sup>3</sup> Илүү агуу зүйлийг бүтээхэд саад бэрхшээлүүдийг хурдасгуур болгон ашигла.

*Би энэ долоо хоногт эхэлж чадна.* Гэр бүлийн үдшийг гэрийнхээ хэрэгцээ, нөхцөл байдлын дагуу зохион байгуулж болно. Зарим нийтлэг санал гэвэл:

- Залбирлаар эхэлж, залбирлаар төгсгө.
- Сүмийн дуулал болон хүүхдийн дуунууд зэрэг дуу хөгжим ашигла.
- Судруудаас болон амьд бошиглогчдоос суралц.
- Долоо хоног бүр олон төрлийн чөлөөт үйл ажиллагаа, үйлчлэл хийх төслүүдийг болон сайн мэдээнд төвлөрсөн үйл ажиллагаануудыг багтаа.
- Хөгжилтэй бай! Тоглоом тогло, эсвэл хөнгөн зууш хий.
- Тууштай бай. Хэрэв та нар үүнийг даваа гарагт хийж чадахгүй бол тохиромжтой өөр нэг өдрийг сонго.

*Би адислал авахыг хүсээж байна.* Хэрэв бид гэр бүлийн үдэшт оролцох юм бол агуу адислалууд ирэх болно: Гэр орон дахь хайр болон





дуулгавартай байдал өсөн нэмэгдэх болно гэж бошиглогчид амласан. Өсвөр үеийнхний зүрх сэтгэлд итгэл өсөн нэмэгдэнэ. Гэр бүлүүд “тэднийг тойрон хүрээлдэг нөлөө, уруу таталтуудтай тэмцэх хүчийг олж авах болно.”<sup>4</sup>

Гэр бүлийн тань үдэш үргэлж төгс болж чадахгүй байлаа ч та нарын гаргаж буй хичээл зүтгэлүүдээр дамжуулан гэр бүл тань хүчирхэгжиж, бас адислагдах болно. “Гэр бүлийн үдэш бүр нь бидний бодгалийн зотон даавуун дээр бийрээр зурахтай адил юм” гэж Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар заажээ. “Ямар ч үйл ажиллагаа ийм гүнзгий сэтгэгдэл

төрүүлсэн буюу дурсамжтай байх аргагүй юм. Гэвч . . . будгийн зураас бүр нийлж, сэтгэл татам урлагийн бүтээлийг бий болгодог шиг жижиг мэт санагдах зүйлсийг байнга хийснээр сүнслэг байдлын чухал үр дүнд хүргэж чадна.”<sup>5</sup> ■  
**ЭШЛЭЛ**

1. Томас С.Монсон, “Цаг үеийн өөрчлөлтөд хувирдаггүй үнэнүүд,” *Лиакхона*, 2005 оны 5-р сар, 19.
2. А.Том Пэрри, “Therefore I Was Taught,” *Ensign*, 1994 оны 5-р сар, 38.
3. “Family Home Evening: Any Size, Any Situation,” *Ensign*, 2001 оны 12-р сар, 42.
4. Тэргүүн Зөвлөл, Жэймс Р.Кларкийн эмхтгэл, *Messages of the First Presidency of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, 6 боть, (1965–75), 4:339.
5. Дэвид А.Бэднар, “Гэр орондоо илүү хичээнгүй байж, анхаарал тавь,” *Лиакхона*, 2009 оны 11-р сар, 19.

## ХАМГИЙН ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛ ӨГ

“Бид гэр бүлийн залбирал, гэр бүлийн үдэш, сайн мэдээг судлах болон заавар зөвлөгөө, гэр бүлийн үр өгөөжтэй үйл ажиллагаануудад хамгийн чухал ач холбогдол өгч байхыг эцэг эх, хүүхдүүдэд зөвлөж байна. Бусад зохистой бас тохиромжтой хэрэгцээ эсвэл үйл ажиллагаанууд байж болох ч, тэдгээр нь гагцхүү эцэг эхчүүд, гэр бүлийн гүйцэтгэж чадах бурханлаг үүргийг орлох ёсгүй.”

Тэргүүн Зөвлөлийн захидал, 1999 оны 2-р сарын 11.

# ТЭР АМИЛСАН

Христэд итгэх гуйвшгүй итгэл нь өнөөгийн дэлхийн хамгийн чухал хэрэгцээ болоод байна.



Сүмийн ес дэх ерөнхийлөгч  
**Ерөнхийлөгч Дэвид О.Маккэй (1873–1970)**

Дэвид О.Маккэй 1873 оны 9-р сарын 8-нд төрсөн. Тэрээр 1906

оны 4-р сарын 9-нд 32 настай байхдаа төлөөлөгчөөр томилогдсон бөгөөд 1951 оны 4-р сарын 9-нд Сүмийн ес дэх ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдсан. Дараах хэсгийг 1966 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн түүний үгээс эш татав. Бүрэн эхээр нь үзэх бол 1966 оны 4-р сарын Conference Report, 55–59-р хуудсыг үзнэ үү.

**Х**эрэв гайхамшиг нь хүмүүний Хязгаарлагдмал мэргэн ухаанаас хэтэрсэн ер бусын үйл явдал юм бол Есүс Христийн амилаалт нь бүх цаг үеийн хамгийн гайхалтай гайхамшиг юм. Бурханы бүхнийг чадагч хүч болон хүмүүний үхэшгүй байдал нь үүгээр илэрхийлэгддэг.

Гэсэн хэдий ч амилаалт нь зөвхөн хүний ойлголт ба ухаарлаас хэтэрсэн зүйл гэдэг утгаараа нэгэн гайхамшиг болдог. Үүнийг бодитоор хүлээн авдаг бүх хүнд энэ нь амьдралынхаа турш дагах хууль нь болдог. . . .

Христ үнэхээр өөрийн биеийг хүлээн авч, алдар суундаа амилан үзэгдсэн гэдэг нь баримтаар нотлогдвол та нар “Хэрэв хүн үхвэл, тэрээр амилах уу?” хэмээх асуултад хэзээ ч хариулах боломжтой болох юм (Иов 14:14).

## Амилалтын гэрчүүд

Булшнаас амилсан Христийн амилаалт нь Түүнийг тодорхой мэддэг байсан дагалдагчдынх нь хувьд бодит зүйл байсан юм. Тэдний оюун бодолд ямар ч эргэлзээ байсангүй. Тэд үйл явдлын гэрчүүд байв; тэд нүдээрээ харж, чихээрээ сонсож, амилсан Гэтэлгэгчийн биеийг гараараа барьж үзсэн учраас мэдэж байв.

Арваннэгэн дагалдагч Искаротын Иудасын оронд нэг хүнийг сонгож авахаар уулзаж байсан тэр үед тэргүүн төлөөлөгч Петр “Иймээс эрчүүдийн нэг нь . . . түүний амиалалтын гэрчлэгч болох хэрэгтэй байна” (Үйлс 1:21–22) гэж хэлжээ. . . .

Өөр нэг удаа Петр дайснуудынхаа өмнө, бүр Есүсийг загалмай дээр үхэхэд хүргэсэн тэр хүмүүсийн өмнө “Израиль эрчүүд ээ, эдгээр үгсийг сонсоцгоо; . . . Энэ Есүсийг Бурхан амилуулсан бөгөөд бид бүгдээр үүний гэрч нар мөн” хэмээн тунхагласан (Үйлс 2:22, 32). . . .

зөвхөн үнэн гэж хүлээн аваад зогсохгүй Христийн газар дэлхий дээрх тэнгэрлэг зорилгыг бүрэн дүүрнээр хүлээн авсан Петр, Паул, Иаков болон эртний бусад төлөөлөгчийн хамт гэрчилдэг билээ.

Есүсийг загалмай дээр нас барснаас 1800 жилийн дараа бошиглогч Иосеф Смит түүнд үзэгдсэн, амилсан Их Эзэнийг тунхаглан, “Тялалзсан өнгө хийгээд алдар сууг нь дүрслэхийн аргагүй хоёр Хүн миний дээр агаарт зогсож байхыг би харав. Тэдний нэг нь надтай ярьж, намайг нэрээр минь дуудан, мөн нөгөөх уруугаа зааж хэлэв—*Энэ бол Миний Хайртай Хүү. Түүнийг сонс!*” гэжээ (Иосеф Смит—Түүх 1:17). . . .

Хэрэв Иосеф Смитийн гэрчлэл дангаараа байсан бол, Христ Өөрийнхөө талаар ярихдаа Өөрийн гэрчлэлийг хуваалцдаг байсан шиг энэ нь ашиггүй байх байсан. Гэвч Есүсийг Бурхан болон төлөөлөгчид гэрчилдэг. Бас Иосеф Смитэд [түүний] гэрчлэлийн үнэнийг баталсан өөр гэрчүүд байдаг. Үүний үнэн болохыг тэнгэр элч Моронай тэдэнд үзүүлсэн учраас тэд үнэн гэдгийг нь мэддэг болсон байв. . . .

. . . Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм [бас] бошиглогч Иосеф Смитийн алдар суут үзэгдлийн үнэн байдлыг тунхагладаг.

“Түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол Түүний талаар бидний өгөх хамгийн сүүлчийн гэрчлэл юм: Тэр амьд бөлгөө.” (С ба Г 76:22). . . .

## АМЬД ХРИСТ

**2000** оны 4-р сарын *Лиакхона*, 2–3-р хуудсан дээрх өнөө үеийн төлөөлөгч, бошиглогчдоор өгөгдсөн Есүс Христийн талаарх гэрчлэлийг унш.

## Нэмэлт гэрчүүд

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь амиалалтыг





гэдгийг бүх дэлхийд тунхагладаг. Түүнийг зөвхөн агуу шинэчлэгч, үлгэр дуурайл авах багш, эсвэл зөвхөн төгс хүн мэтээр хүлээн авах бол ямар ч үнэнч дагалдагч байсан Түүнийг хүлээн зөвшөөрөхгүй. Галилын хүн—уран зүйрлэлгүйгээр, гэхдээ *жсинхэнэ утгаараа* амьд Бурханы Хүү юм. . . .

### Үнэхээр дахин төрсөн

Хэн ч өөрийн бие дээрх өөрчлөлтийг мэдрэхгүйгээр Назарын Есүсийн сургаалуудыг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэхээр чин сэтгэлээсээ шийдвэр гаргаж чадахгүй. “Дахин төрөх” хэмээх энэ хэллэг нь олон хүний үзэж байгаагаас ч илүү гүн гүнзгий ач холбогдолтой. . . . Аврагчтай ойр байснаар, мөн амьд Христтэй ойр дотно харилцаатай байснаар ирдэг өсөлт хөгжил ба өөрчлөгч хүчийг үнэхээрийн мэдэрсэн тэр хүн бол аз жаргалтай хүн юм. Христ миний Гэтэлгэгч гэдгийг мэддэгтээ би талархалтай байдаг. . . .

Амилалтын захиас нь . . . хүн төрөлхтөнд хэзээ ч өгөгдөж байгаагүй хамгийн их тайтгаруулагч, хамгийн алдар суут зүйл юм. Учир нь үхэл биднээс хайртай хүнийг маань авч одох үед “*Тэр энд байхгүй; тэр амилсан!*” хэмээх энэ үгэнд илэрхийлэгддэг найдвар, тэнгэрлэг баталгаагаар бидний гашуудсан зүрх тайвширдаг [Матай 28:6; Марк 16:6-г үзнэ үү].

Би бодгалийнхаа бүхий л эрч хүчээр Есүс Христ үхлийг ялсан бөгөөд бидний Гэтэлгэгч амьд учраас бид бас ялах болно гэдгийг мэднэ. ■

*Дэд гарчгууд өөрчлөгдсөн бөгөөд том жижиг үсэг, цэг таслалыг стандартад оруулав.*

Эртний төлөөлөгчдөөр өгөгдсөн ийм маргашгүй гэрчлэлүүд байхад, мөн амилуулалтаас хэдхэн жилийн дараа бичигдсэн гэрчлэлүүд байхад, түүнчлэн энэ эрин үед амьд Христийн талаарх хамгийн гайхамшигтай илчлэлт байхад хүмүүс одоо ч гэсэн Түүнээс татгалзсаар байгааг, бас хүмүүний үхэшгүй байдалд хэрхэн эргэлзэж чадаж байгааг ойлгоход үнэхээр хэцүү.

### Өнөөдөр бидэнд юу хэрэгтэй байна вэ?

Христэд итгэх гуйвшгүй итгэл нь өнөөгийн дэлхийн хамгийн чухал

хэрэгцээ болоод байна. Гуйвшгүй итгэл нь мэдрэмжээс хавьгүй илүү чухал юм. Энэ нь үйлдэл рүү хөтөлдөг хүч бөгөөд хүн төрөлхтний амьдрал дахь хөдөлгөгч хүчнүүдийн үндэс суурь болох ёстой. . . .

Хүмүүс харанхуй, найдваргүй булш руу итгэлгүйхэн харахын оронд “Түүний хүслийг” гүйцэлдүүлсэн бол тэд тэнгэрлэг үнэнд анхаарлаа хандуулж, Христ амилсныг олж мэдэх байсан. . . .

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм Христ бол Бурханы Хүү, дэлхийн Гэтэлгэгч

# ЭМЭГТ

*“Бид Сүмийн эмэгтэйчүүдийг зөв шударгын төлөө хамтдаа зогсоход уриалж байна. . . . Би үүнийг дэлхий дээр тод гэрэлтэж байгаа найдвар болгон харж байна.” —Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008)*





# ЭЙЧҮҮДИЙН СҮНСЛЭГ НӨЛӨӨ



БУРХАНЫ ОХИД, ЧЭРИЙН ПЭТЭРСОНЫ ЗУРАГ, ХУУЛГАРЛАЖ БОЛХОГҮЙ

*Бид сүнслэг хүч чадлынхаа хүчийг мэддэг үү?*

**Старла Авэркамп Батлер**

Сүмд гайхалтай, даруухан олон эмэгтэй сүнслэг хүч чадлын өв, материаллаг үйлчлэлийн үлгэр жишээнүүдээрээ амьдралдаа олон хүнд нөлөөлж байгаагаа мэдэлгүй бүхнээ зориулан үйлчилдэг. Ийм нэгэн эмэгтэй бол миний эмээ Чэри Пэтэрсон юм. Тэр амьдралынхаа турш үл анзаарагдам дуудлагуудад тун итгэлтэй үйлчилсэн юм. Хэрэв та нар түүнээс асуусан бол тэр дэлхийд санал болгох олон авьяас өөрт нь байхгүй гэж хэлэх байсан. Гэсэн хэдий ч би түүний амьдралын талаар судалж эхлэхэд, түүний сүнслэг хүч чадал миний амьдралд хэрхэн нөлөөлснийг олж мэдсэн билээ.

Чэригийн эцэг эх нь сүмд явахад больж, түүнийг бага байхад салсан байна. Тиймээс, тэр байнга ажил хийдэг байсан эх Флорэнс дээрээ өссөн юм. Флорэнс хүүхэд байхдаа бүр их орхигддог байв. Тэр сургуулийнхаа дотуур байранд амьдарч байхад ээж Жоржиа нь дэлхийн амьдралаар амьдардаг байв. Өсөж торних үед нь түүнд тохиолддог байсан сорилт бэрхшээлүүдээс үл хамааран Чэри сайн мэдээнд идэвхтэй үлдэж, эмэг эх Элизабетийн гэр бүлийнхэнтэй юм уу найзуудтайгаа Сүмдээ итгэлтэй явдаг байжээ. Тэр тэдний гэр бүлүүдээс өөрийнхөө амьдралд хүсдэг байсан тэр зүйлүүдийг олж хардаг байв. Тэрээр гэр бүл ямар байх ёстойг мэддэггүй байсан ч, үүнийг ямар байх ёсгүйг мэддэг байжээ. Тэр бас өөрийнхөө ирээдүйн гэр бүлийг өөр байлгахад шийдсэн юм.

Чэригийн нөхөр болох миний өвөө Дэлл “гэрчлэлтэй байхын тулд чи үүнийг хүсэх ёстой. Чэри үргэлж гэрчлэлтэй байхыг хүсдэг байсан” гэж надад нэг удаа хэлж билээ. Тэдний гэрлэсэн эхний хэдэн жил зовлон бэрхшээлүүдээр дүүрэн байсан ч тэд гэр бүлээрээ хүчтэй байхаар шийдсэн юм. Дэллийн ажлын хуваариас болоод тэд гэрлэсэн эхний жилдээ идэвх султай байв. Гэвч Хүүхдийн хэсэгт үйлчлэх дуудлага нь Чэриг Сүмдээ явж эхлэхэд, мөн Дэллийг диконы чуулгын зөвлөхөөр Сүмдээ үйлчлэн, түүнтэй нэгдэхэд нөлөөлсөн байна. Тэр цагаас хойш тэдний аль аль нь Сүмдээ идэвхтэй бөгөөд хүчтэй хэвээр үлджээ. Чэригийн үйлчлэх хүсэл болон хүчирхэг гэр бүлийг өсгөн хүмүүжүүлэх шийдвэр ээжид маань түүн шиг

хүчтэй эмэгтэй болоход тусалсан бөгөөд ээжийн маань үлгэр жишээ надад амьдралаа тодорхойлоход, ялангуяа одоо өөрийнхөө энэ амьдралыг эхлэхэд тус болсон юм.

Эмэгтэйчүүд бидний хувьд эргэн тойрныхоо хүмүүсийн амьдралд гүн гүнзгий сүнслэг нөлөө үзүүлж чадна. Үнэндээ, Иосеф Смит заахдаа бидний үүрэг бол “зөвхөн ядуусыг халамжлах бус харин бодгалиудыг аврах явдал юм”<sup>1</sup> гэжээ. Есүс Христ Өөрийн Сүмийн эмэгтэйчүүдийг түүний шавь нар байж, сүнслэг байдлаараа хүчтэй байхад дуудсан. Бидний сүнслэг хүч чадал, нөлөө нь авралын ажлын өсөлтөд зайлшгүй чухал бөгөөд бид эргэн тойрондоо байгаа хүмүүсийг сүнслэгээр хүчирхэгжүүлэх боломжуудыг эрэлхийлэх ёстой. Үүнийг хийснээр бидний итгэл ба зөв шударгын нөлөө нь бидний харж чадахаас ч илүү удаан үргэлжлэх болно.

### Шавь байх дуудлага

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэймс Э.Талмэж (1862–1933) “Эмэгтэй хүмүүсийн дэлхий дээрх хамгийн агуу хамгаалагч нь Есүс Христ юм”<sup>2</sup> гэж бичсэн байдаг. Тухайлбал, Тэр Шинэ Гэрээн дээрх хоёр эмэгтэй шавь болох Мариа, Марта хоёрт юу заасан талаар бодож үз. *Daughters in My Kingdom* ном нь Лук 10-р бүлэг дэх Марта Есүсийг гэртээ хүлээн авсан түүхийг өгүүлдэг хэмээн тайлбарласан байдаг. Марта Их Эзэний материаллаг хэрэгцээнд анхаарал тавьснаараа Түүнд үйлчилсэн бөгөөд Мариа Эзэний хөлд суугаад, үгийг нь сонсож байлаа.

“Эмэгтэйчүүдээс зөвхөн материаллаг үйлчлэл хийхийг нийтээр хүсдэг байсан тэр үед Аврагч Марта, Мариа хоёрт эмэгтэйчүүд Өөрийнх нь ажилд сүнслэгээр оролцож болохыг бас заасан юм. Тэрээр тэднийг Өөрийнхөө шавь болж, авралаас хүртэж, мөн тэднээс хэзээ ч зайлуулалдашгүй ‘сайныг л’ сонгон авахад урьсан юм.”<sup>3</sup>

Бид заримдаа Марта шиг, эмэгтэй хүний чухал үүрэг бол хоол хийх, хувцас оёх, бусдын өмнөөс цэвэрлэх гэх мэт материаллаг үйлчлэл гэж бодож алдаа гаргадаг. Энэ үйлчлэл нь үнэ цэнэтэй бөгөөд талархууштай золиослол юм. Гэсэн хэдий ч Их Эзэнд оёж, хоол хийж чаддаг эгч нараас илүүтэй Түүнд итгэл, зөв шударга байдал болон энэрэл нь амьдралынх нь турш гэрэлтдэг сүнслэг байдлаараа хүчтэй эмэгтэйчүүд хэрэгтэй байна. Тэрээр бид

бүгдэд Түүнд санал болгох маш их зүйлс байгааг мэддэг. Есүс Христ бид *бүгдийг* Түүний ажлыг урагшлахад туслах илчлэлт хүлээн авч, үүнийхээ дагуу үйлдэх сүнслэг



Дөрвөн үе: Зүүн талд Элизабет ач охин Флорэнсээ тэвэрч байгаа нь. Элизабетын ээж Анна (голд нь байгаа) эцэг эхийнхээ хамт Ютад байгаа нь. (Баруун талд байгаа) Жоржиа нь Элизабетын охин бөгөөд Жоржиа болон түүний охин Флорэнсэ нар Сүмийг орхисон юм. Энэ бол элэнц ач охин Чэри ба Чэригийн үр удмыг сайн мэдээнд үлдэхэд тусалсан итгэлтэй эмэгтэй Элизабет.

хүч чадал, чадвараа хөгжүүлэхэд урьдаг. Халамжийн Нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Линда К.Бертон эгч нарт хандан хэлэхдээ “Та нар хэн болох, мөн юу хийхээр бэлтгэгдсэнээсээ шалтгаалан энэ эрин үед дэлхий рүү илгээгдсэн билээ! Биднийг хэн болох талаар Сатан юу ч гэж бодуулахыг ятгаж байлаа ч гэсэн, үнэндээ бид чинь Есүс Христийн дагалдагчид шүү дээ!”<sup>4</sup> гэжээ.

Их Эзэн биднийг болон бидний нөхцөл байдлуудыг мэддэг бөгөөд энэ дэлхий дээр бидний хүн нэг бүрээр хийлгэх ажил Түүнд байгаа. Нэгээхэн ч эгч сайн сайхан зүйлд сүнслэг хүч нөлөө болж, мөн бусдыг Христэд авчрахад дэндүү багыг мэддэггүй, эсвэл дэндүү цөөхөн авьяастай байдаггүй юм. Бид энэхүү тэнгэрлэг боломжоороо дамжуулан

гэр орондоо болон нийгэмдээ сүнслэг удирдагчид болох үүрэг хариуцлагатай байдаг. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М.Рассэлл Баллард “Их Эзэнтэй гэрээнүүд хийсэн энэ Сүмийн эгч бүр бодгалиудыг аврах, дэлхийн эмэгтэйчүүдийг удирдах, Сионы гэр бүлүүдийг бэхжүүлэх, Бурханы хаант улсыг байгуулахад туслах, заавал биелүүлэх бурханлаг үүрэгтэй юм”<sup>5</sup> хэмээн тунхагласан.

Бидний хамгийн чухал үүрэг—эргэн тойрондоо байгаа хүмүүсийг Есүс Христэд илүү ойртоход тэднийг удирдах сонголтуудыг хийхэд тэдэнд туслахын тулд бид заавал өндөр албан тушаал дээр байх юм уу ер бусын зүйлүүд хийх шаардлагагүй юм. Нэг юм уу хоёр хүний амьдралд, эсвэл бүр өөрийн гэр бүлд бидний хийдэг хамгийн том болон хамгийн жижиг зүйлсийн аль аль нь гүн гүнзгий нөлөө үзүүлж чадна.

### Авралын ажил дахь эмэгтэйчүүд

Миний нэгэн дуртай дуулалд “Тэнгэр элчийн үйл хэрэг эмэгтэйчүүдэд өгөгдсөн байдаг; Энэ нь эгч нар бидэнд оногдсон бэлэг юм”<sup>6</sup> хэмээн өгүүлдэг. Бидэнд хайртай хүмүүсийнхээ амьдралд зориулах зүйлс их байдаг. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скотт хоёр эмэгтэйн сүнслэг хүч чадал түүний амьдралд хэрхэн нөлөөлсөн талаар хуваалцсан юм.





“Намайг бага байхад аав минь Сүмийн гишүүн биш, харин ээж идэвх султай болсон байлаа. . . . Миний найман насны төрсөн өдрөөс хэдхэн сарын дараа миний нагац эмээ Виттл бидэнтэй уулзахаар ирлээ. Эмээ маань ах бид хоёрыг баптисм хүртээгүй байсанд санаа нь зовниж байв. Эмээ энэ асуудлын талаар аав, ээж хоёртой юу ярьсныг би мэдээгүй ч, нэг өглөө тэрээр ах бид хоёрыг цэцэрлэгт хүрээлэн рүү дагуулж очин, Сүмийн цуглаанд тогтмол оролцох болон баптисм хүртэх нь хэчнээн чухал болох талаар бодол санаагаа бидэнтэй хуваалцсаныг би сайн санадаг. Би эмээгийнхээ хэлсэн зүйлийг тодорхой санадаггүй ч, түүний үгс зүрх сэтгэлд минь гүнзгий нөлөөлсөн учир, ах бид хоёр удалгүй баптисм хүртсэн юм. . . .

“Эмээ Сүмийн цуглаануудад биднийг машинаараа хүргэж өгөх нь

*“Аврагч Марта,  
Мариа хоёрт  
эмэгтэйчүүд  
Өөрийнх нь  
ажилд сүнслэгээр  
оролцохыг заа-  
сан. Тэр тэднийг  
Өөрийнх нь шавь  
болж, авралаас  
хүртэхэд уриw.”*

хэчнээн чухал болохыг аавд ойлгуулахад туслахын тулд тодорхой хэмжээгээр хүндэтгэлтэй хандаж, зоригтой байсан юм. Эмээ бидний амьдралд сургаал хэрэгтэйг мэдрүүлэх тохиромжтой арга бүрээр бидэнд тусалдаг байлаа.”<sup>7</sup>

Сүнслэг хүч чадлын хоёр дахь эх сурвалж нь ахлагч Скоттын эхнэр Жийнэн байсан юм. Тэд болзож байхдаа ирээдүйнхээ талаар ярилцдаг байв. Хүчирхэг номлогчийн гэр бүлд өссөн Жийнэн, буцаж ирсэн номлогчтой ариун сүмд гэрлэхийг хүсэж байгаагаа илэрхийлжээ. Өмнө нь номлолд үйлчлэх талаар огт бодож байгаагүй ахлагч Скоттод энэ нь маш хүчтэй нөлөөлсөн байна. “Би гэртээ хариад өөр юуны ч тухай бодож чадахгүй, шөнөжингөө нойр хулжин, сэрүүн байлаа. . . . Би олон удаа залбирсныхаа дараа бишоптой уулзаж, номлолын



БАЛЧИР ХҮҮХЭД ЗУРГИЙГ КЭТЛИЙН ПЭГЭРСОН, ХУУЛБАРЛАЖ БОЛОХГҮЙ

өргөдлөө бөглөж явуулахаар шийдэв.<sup>8</sup> Хэдийгээр Жийнэн түүнд хэрэгтэй байсан удирдамж ба сүнслэг өдөөлтийг өгсөн ч ахлагч Скотт “Жийнэн зөвхөн өөрийнхөө хүслийг биелүүлэхийн төлөө номлолд үйлчлэхийг надаас хэзээ ч хүсээгүй юм. Тэр надад хайр сэтгэлтэй байсан учраас итгэл үнэмшлээ надтай хуваалцдаг байсан бөгөөд надад амьдралынхаа замыг сонгох боломж олгосон юм. Бид хоёулаа номлолд үйлчилж, дараа нь ариун сүмд лацдан холбогдсон билээ. Жийнэн шашныхаа итгэл үнэмшлийн дагуу амьдрах зоригтой бөгөөд шийдвэр төгс байсан нь бидний хамтын амьдрал дахь хамгийн чухал хүчин зүйлсийн нэг болсон юм. Их Эзэнд үйлчлэх зарчмыг эн тэргүүнд анхаарах зүйлээ болгох ёстой гэсэн түүний хүчирхэг итгэлгүйгээр бид аз жаргалыг олохгүй байх байсан гэдэгт би итгэлтэй байна. Тэр бол зөв шударга байдлын гайхамшигтай үлгэр жишээ!”<sup>9</sup>

*Миний нэгэн  
дуртай дуулалд  
“Тэнгэр элчийн  
үйл хэрэг эмэгтэй-  
чүүдэд өгөгдсөн  
байдаг; Энэ нь эгч  
нар бидэнд оногд-  
сон бэлэг юм”  
хэмээн өгүүлдэг.  
Бидэнд хайртай  
хүмүүсийнхээ  
амьдралд зориу-  
лах зүйлс их бий.*

Энэ бол зөвхөн нэг залуу эрэгтэй— ахлагч Скоттод амьдралынхаа хамгийн чухал шийдвэрүүд болох баптисм хүртэх, номлолд үйлчлэх, ариун сүмд гэрлэх гэх мэт зарим шийдвэрийг гаргахад нь тусалсан түүний амьдрал дахь тэнгэр элч болсон эмэгтэйчүүдийн сүнслэг нөлөө байв.

Бид өөрсдийн үлгэр жишээ, үйлдэл, үг яриа болон хувийн зөв шударга байдлаараа дамжуулан бусдад сайн сонголт хийхэд нь тусалж чадна. Халамжийн Нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Кэрол М.Стивэнс эгч “Бид Их Эзэний хаант улсын гэрээгээ сахигч охид нь бөгөөд бидэнд Түүний мутар дахь зэмсэг болох боломж байдаг билээ. . . . Бид өдөр бүр энгийн жижиг аргаар буюу хамгаалж, хүчирхэгжүүлж, нэг нэгэндээ зааснаар авралын ажилд оролцдог”<sup>10</sup> хэмээн тунхагласан. Бид Сүнсэнд найдаж, Христэд илүү



ойртоход нь эргэн тойрныхоо хүмүүст туслахын тулд чин сэтгэлээсээ, даруухан бөгөөд хичээл зүтгэлтэйгээр урагшлах үед хийж чадах зүйлийнхээ талаар удирдамж авч, бас үүнийг хийх хүч чадлыг хүлээн авах болно. Мөн бид Их Эзэний хүүхдүүдийг Түүнд авчирч байгаадаа баяртай байх болно.

### Сүнслэгээр нөлөөлөх нь

Сүнслэгээр нөлөөлөхийн тулд бид үүргээ мэдэж аван, эртний шавь нарын адилаар “Бид одоо яах вэ?” (Үйлс 2:37) гэж асууж болох юм. Саяхны нэгэн Ерөнхий чуулган дээр Бертон эгч авралын ажилтай холбоотой “хэрэгтэй байна” гэж үзэх зарим сүнслэг тэмдгийг өөртэй нь хамт төсөөлөн бодохыг эгч нараас хүсжээ:

- Гэрэлд болон үнэнд хүүхдүүдээ хүмүүжүүлэх эцэг, эхчүүдийн тусламж хэрэгтэй байна
- . . . охид, эгч нарын тусламж хэрэгтэй байна. . . . зааж сурган, үйлчилж, гэрээнийхээ зам дээр байхад нь тусламжийн гараа сунгах авга, нагац, үеэлүүд, мөн өвөө эмээ болон үнэнч найз нөхдийн тусламж хэрэгтэй байна
- Ариун Сүнсний өдөөлтүүдийг сонсон, тэдгээрээс төрсөн мэдрэмжийнхээ дагуу үйлдэх хүмүүсийн тусламж хэрэгтэй байна
- Сайн мэдээний дагуу жижиг бөгөөд энгийн арга замуудаар амьдардаг тийм хүмүүсийн тусламж хэрэгтэй байна
- Гэр бүлүүдийг мөнхөд холбох гэр бүлийн түүхийн болон ариун сүмийн ажилтнуудын тусламж хэрэгтэй байна
- Есүс Христийн сайн мэдээ ба сайн сайхан мэдээг түгээх номлогчдын болон гишүүдийн тусламж хэрэгтэй байна
- Замаасаа төөрсөн хүмүүсийг олох аврагчдын тусламж хэрэгтэй байна
- Үнэн ба зөв шударгын төлөө бат зогсон, гэрээгээ сахигчдын тусламж хэрэгтэй байна
- Их Эзэн Есүс Христийн үнэнч дагалдагчдын тусламж хэрэгтэй байна.”<sup>11</sup>

Эдгээр нь шинэ зүйл биш ч, бид авралын ажилд оролцох боломжуудыг эрэлхийлэх үедээ эргэн тойрондоо байгаа хүмүүст туслах чадвараа хөгжүүлэх юм. Ахлагч Баллард “Зөв шударга эмэгтэйн үзүүлэх нөлөөтэй зүйрлэхүйц хүмүүжүүлэх, амьдралыг өөрчлөх тийм хүчтэй зүйл энэ дэлхийд ер байхгүй”<sup>12</sup> гэж хэлжээ. Хувиараа залбирч, судраас судлан, тууштай дуулгавартай байснаар, мөн гэрээнүүдээ итгэлтэй сахиснаар өөрсдийн сүнслэг хүчийг нэмэгдүүлэх үед бид тэрхүү нөлөө нь болно.

### Бидний харж чадахаас ч илүү

Ерөнхийлөгч Бригам Янг (1801–1877) “Та нар Израиль дахь ээжүүд болон охидын хийх боломжтой сайн зүйлсийг хэмжиж, надад хэлж чадах уу” гэжээ. Энэ бол боломжгүй зүйл! Тэдний хийж байгаа сайн сайхан зүйлүүд тэднийг үүрд мөнхөд дагах болно.”<sup>13</sup>

Эмээгийн маань зөв шударга сонголтууд түүний залуудаа харж чадахаас ч илүүгээр үр удамд нь нөлөөлсөн юм. Гэсэн хэдий ч, миний амьдралд байсан эмэгтэйчүүдийн сүнслэг нөлөө өмнөх үеүдтэй нь холбоотой билээ. Чэри элэнц эмэг эх (гурав дахь үеийн эмэг эх) Элизабетыг ажигласнаар өөрийнхөө сүнслэг хүч чадлыг олж авсан. Элизабетын итгэл, гэрчлэлийн үлгэр жишээ хоёр идэвхгүй удмыг нь дамжин, элэнц ач охин Чэрид нь сарнисан гэр бүлээ авч үлдэж, Сүмдээ эргэн ирэхэд нь туслахын тулд хүрсэн билээ.

Бид эргэн тойрондоо байгаа тэдэндээ сүнслэг хүчээр нөлөөлөх үед бидний нөлөө бидний харж чадахаас ч илүү үргэлжлэх болно. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) “Бид Сүмийн эмэгтэйчүүдийг зөв шударгын төлөө хамтдаа зогсоход уриалж байна. Тэд үүнийг гэрээсээ эхлэх ёстой. Мөн тэд ангиуддаа зааж болно. Тэд байгаа газар, орон нутагтаа зөв шударгын дуу хоолой байж чадна” гэж хэлжээ. . . .

“Энэ нь өөрийгөө сүйрүүлэх замаар замнаж буй энэ дэлхийд найдварын оч болон гэрэлтэж байгааг би харж байна.”<sup>14</sup>

Бид энэ зарлигийг биелүүлэх үед Их Эзэний ажил бидний эргэн тойронд байгаа хүмүүст болон хамгийн чухал нь бидний гэр бүлүүдэд, мөн бидний хайртай хүмүүсийн амьдралд аль алинд нь яаравчлан ирэх болно. ■

*Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.*

### ЭШЛЭЛҮҮД

1. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 453.
2. Жэймс Э.Талмэж, *Jesus the Christ*, 3 дахь хэвлэл (1916), 475.
3. *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 3–4.
4. Линда К.Бертон, “Ажлыг яаравчлуулах гар болон зүрх сэтгэлтэй хүмүүс хэрэгтэй байна,” *Лиакхона*, 2014 оны 5-р сар, 122–123.
5. М.Рассэлл Баллард, “Women of Righteousness,” *Лиакхона*, 2002 оны 12-р сар, 70.
6. “Сионы эгч нар” *Hymns*, дугаар 309.
7. Ричард Г.Скотт, “Би та нарт жишээ үзүүлсэн юм,” *Лиакхона*, 2014 оны 5-р сар, 32.
8. Ричард Г.Скотт, “Би та нарт жишээ үзүүлсэн юм,” 33.
9. Ричард Г.Скотт, “Би та нарт жишээ үзүүлсэн юм,” *Лиакхона*, 2014 оны 5-р сар.
10. Кэрролл М.Стивэнс, “Бидэнд баярлах агуу шалтгаан бий,” *Лиакхона*, 2013 оны 11-р сар, 117.
11. Линда К.Бертон, “Ажлыг яаравчлуулах гар болон зүрх сэтгэлтэй хүмүүс хэрэгтэй байна,” 124.
12. М.Рассэлл Баллард, “Эхчүүд болон охид,” *Лиакхона*, 2010 оны 5-р сар, 18.
13. *Discourses of Brigham Young*, эмхэтгэсэн Жон А.Видцөү (1954), 216
14. Гордон Б.Хинкли, “Standing Strong and Immovable,” *Дэлхий даяарх удирдагчдын сургалт*, 2004 оны 1-р сарын 20.

# СУЛ ДОРОЙ БАЙДАЛ НЬ НҮГЭЛ БИШ

Вэнди Улрич

**Б**и үнэхээр Бурханы өргөөнд орохуйц зохистой байна уу? Хэрэв би төгс биш бол яаж үүнд зохистой байж чадах вэ?

“Бурхан үнэхээр миний сул дорой байдлыг хүчтэй тал болгож чадах уу? Би энэ асуудлыг өөрөөсөө авч хаяхын тулд олон удаа мацаг барьж, залбирсан ч юу ч өөрчлөгдөхгүй юм шиг санагдаж байв.”

“Би номлолын талбарт байхдаа хэзээ хэзээнээс илүү сайн мэдээний дагуу илүү тогтвортой амьдардаг байсан ч дутагдлуудынхаа талаар огт мэддэггүй байв. Би яагаад, мөн хэзээ ийм сайн байсан юм бол, бас яагаад надад заримдаа муу мэдрэмж төрдөг юм бол?”

Энэ асуулыг тунгаан бодох үед нүгэл нь биднийг өөрийн эрхгүй Бурханаас холдуулдаг бол сул дорой байдал нь эсрэгээрээ биднийг Түүн рүү удирдаж чадна.

## Нүгэл ба сул дорой байдлыг ялган таних нь

Бид ихэнхдээ нүгэл ба сул дорой байдал нь хүн бүрд өөр өөр бөгөөд гэм нүглийн аюул ч бас өөр өөр гэж боддог. Гэвч судрууд нүгэл ба сул дорой байдал нь анхнаасаа өөр байдаг бөгөөд өөр өөр эмчилгээ шаардаж, өөр өөр үр дүн бий болгох боломжтой гэж хэлдэг.

Бидний ихэнх нь нүглийн талаар мэддэг ч, үүнийг дахин нэг авч үзэцгээе. Нүгэл бол Бурханы зарлигуудад дуулгаваргүй байх, эсвэл өөрсдийнхөө

дотор байгаа Христийн гэрлийг үгүйсгэх сонголт юм. Нүгэл нь өөрсдийгөө Эцэгийн эсрэг дайсан болгож, Сатанд Бурханаас илүү найдах сонголт юм. Биднээс ялгаатай нь Есүс Христ ямар ч гэм нүгэлгүй байсан бөгөөд бидний гэм нүглийн төлөө Цагаатгал хийж чадах байв. Бид чин сэтгэлээсээ наманчлах үед оюун бодол, зүрх сэтгэл болон

*Хязгаарлагдмал болон  
хангалтгүй байдал нь нүгэл  
биш бөгөөд биднийг цэвэр  
байж, Сүнсийг хүлээж авахуйц  
зохистой байхад саад болдоггүй.*







Энэ асуултыг тунгаан бодох үед нүгэл нь биднийг өөрийн эрхгүй Бурханаас холдуулдаг бол сул дорой байдал нь эсрэгээрээ биднийг Түүн рүү удирдаж чадна.



зан чанараа өөрчлөн; зохих ёсоор уучлал гуйж, эсвэл гэм буруугаа хүлээн; боломжтой бол нөхөн төлж; ирээдүйд тэр нүглээ давтахгүй байснаар Есүс Христийн Цагаатгалыг хүлээн авч, Бурханаар өршөөгдөн, дахин цэвэр ариун болж чадна.

Цэвэр бус нэгээхэн ч зүйл Бурханы оршихуйд оршиж чадахгүй учир цэвэр болох нь нэн шаардлагатай юм. Гэвч хэрэв бидний туйлын зорилго нь Бурханы оршихуйг орхихдоо гэм зэмгүй байсан шиг тийм гэнэн байсан бол бид амьдралынхаа үлдсэн хугацаанд хүүхдийн орон дээрээ тухтай гэгч хэвтэж байх нь бидэнд илүү сайн байх байсан биз ээ. Үүний оронд бид муугаас сайныг ялган таньж, мэргэн ухааныг болон чадваруудаа хөгжүүлэн, өөрсдийнхөө эрхэмлэн үздэг зүйлсийн дагуу амьдарч, бурханлаг шинж чанаруудыг буюу бид аюулгүй өлгийн дотор байхдаа хэзээ ч өөрсдөө олж авч чадахгүй байсан тэр өсөлт хөгжлийг өөрсдийн туршлагаас суралцахаар дэлхийд ирсэн юм.

Хүн төрөлхтний сул дорой байдал нь мөнх бус амьдралын энэ чухал зорилгуудад чухал





## ЦАГААТ- ГАЛЫН АМЛАЛТ

“Таны сэргээж чадахгүй зүйлийг сэргээж, эдгээж чадахгүй шархыг тань эдгээж, таны эвдэлсэн бөгөөд засаж чадахгүй зүйлийг засах нь Христийн Цагаатгалын туйлын зорилго юм.” . . .

“Мөхөл рүү хальтирдаг хэдхэн хүнийг эс тооцвол бүрэн уучлалын амлалтаас ангид муу зуршил, донтолт, эсэргүүцэл, урвалт болон гэмт хэрэг гэж үгүй гэдгийг би давтан хэлье. Энэ бол Христийн Цагаатгалын амлалт юм.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч Бонд К.Пакэр “The Brilliant Morning of Forgiveness,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 19–20

үүрэг гүйцэтгэдэг. Моронай өөрийнх нь бичгийн сул дорой байдал Харийнханд ариун нандин зүйлүүдээр тохуурхахад хүргэх вий хэмээн санаа зовох үед Их Эзэн эдгээр үгээр түүнийг тайвшруулсан юм:

“Мөн хэрэв хүмүүс надад ирэх аваас би тэдэнд өөрсдийнх нь сул доройг үзүүлэх болно. Тэд даруу байж болохын тулд би хүмүүст сул доройг өгдөг; мөн миний өмнө өөрсдийгөө даруусгадаг бүх хүмүүст миний ач ивээл хангалттай; учир нь хэрэв тэд миний өмнө өөрсдийгөө даруусгаж, мөн надад итгэлтэй байх аваас, тэгвэл би тэдэнд сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг

болгож өгнө” (Ифер 12:27; мөн 1 Коринт 15:42–44; 2 Коринт 12:7–10; 2 Нифай 3:21; болон Иаков 4:7-г үзнэ үү).

Бидний мэдэх энэ судрын далд утга нь гүн гүнзгий бөгөөд биднийг сул дорой байдлаас (энд

тодорхойлсноор Бурханаас бидэнд “өгөгддөг”) нүглийг (Сатаны дэмждэг) ялган танихад урьсан байдаг.

Сул дорой байдлыг бид мөнх бус дэлхийд бидэнтэй хамт ирдэг мэргэн ухаан, хүч чадал, ариун байдлын хязгаарлагдмал байдал гэж тодорхойлж болох юм. Эгэл хүмүүсийн хувьд бид бие махбодын олон төрлийн өө сэвтэй, өртөмтгий, бусдаас хамааралтай төрдөг. Бид сул дорой эгэл хүмүүсээр өсгүүлж, тэдний дунд байдаг бөгөөд тэдний сургаал, үлгэр жишээ бидэнд хандаж буй хандлага нь буруу байж, заримдаа биднийг сүйтгэдэг. Бид сул дорой, эгэл чанартаа бие махбодын болон сэтгэл санааны өвчинд өртөж, өлсөж, ядардаг. Бид уур бухимдал, га шуудал, айдас зэрэг хүмүүст байдаг сэтгэлийн хөдөлгөөнүүдтэй нүүр тулгардаг. Бидэнд мэргэн ухаан, ур чадвар, тэсвэр тэвчээр болон хүч чадал дутагддаг. Бид олон арга замаар уруу таталтуудад өртдөг.

Хэдийгээр Есүс нүгэлгүй байсан ч Тэрээр мөнх бус сул дорой байдалд бидэнтэй бүрэн нэгдсэн юм (2 Коринт 13:4). Тэрээр мөнх бус





## НҮГЭЛ БА СУЛ ДОРОЙ БАЙДЛЫГ ЯЛГАН ТАНИХ НЬ

|                                  | Нүгэл                                                            | Сул дорой байдал                                                                                                                                   |
|----------------------------------|------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Тодорхойлолт                     | Бурханд зориудаар дуулгаваргүй байх                              | Хүмүүний хязгаарлагдмал ба сул дорой байдал                                                                                                        |
| Эх сурвалж                       | Сатанаар дэмжигддэг                                              | Мөнх бус чанарын нэг хэсэг                                                                                                                         |
| Жишээнүүд                        | Бурханы зарлигуудыг санаатай зөрчиж, Бурханаас илүү Сатанд итгэх | Уруу таталт, сэтгэлийн хөдөлгөөн, ядрах, бие махбодын болон сэтгэл санааны өвчин, хэнэггүй ба өртөмтгий байдал, гэмтэл, үхэл зэргийг мэдрэх чадвар |
| Есүст эдгээр мэдрэмж байсан эсэх | Үгүй                                                             | Тийм                                                                                                                                               |
| Бидний зөв хариу үйлдэл          | Наманчлал                                                        | Даруу байдал, Христэд итгэх итгэл, ялан дийлэх хүч чармайлтууд                                                                                     |
| Бурханы бидэнд өгөх хариулт      | Өршөөл                                                           | Ач ивээл бол боломжтой болгогч хүч                                                                                                                 |
| Үр дүн нь юу болох               | Нүглээсээ цэвэршигдсэн                                           | Ариун байдал ба хүч чадлыг олж авна                                                                                                                |

биеэр бусдын тусламжийг хүсэн, нярай хүүхэд болон мэндэлж, төгс бус хүмүүсээр өсгүүлсэн билээ. Тэр хэрхэн алхаж, ярьж, ажиллахыг, бас бусадтай сайн харьцаатай байхыг сурах ёстой байв. Тэр өлсөж, ядарч, бусдын адил сэтгэл хөдлөлийг мэдэрч, өвдөж, зовж шаналан, цусаа урсган, нас барсан юм. Тэр гэм нүгэлгүй байсан ч Тэрээр бидний сул дорой мэдрэмжүүдийг Өөр дээрээ мэдэрч, *бидний* сул дорой байдлуудад биднийг дэмжиж болохын тул Тэрээр бидний нэгэн адилаар бүхий л төрлийн уруу таталтуудад автагдсан юм” (Еврей 4:15; мөн Алма 7:11–12-ыг үзнэ үү).

Бид сул дорой байдалаа зүгээр наманчилж чадахгүй бөгөөд сул дорой байдал ч биднийг бохирлож чадахгүй. Бид *нүглээс* татгалзахгүй л бол сүнслэгээр өсөж чадахгүй, мөн бид хүн төрөлхтний сул дорой байдлыг *хүлээн авахгүй* л бол бас сүнслэгээр өсөж хөгжин, Бурханд итгэх сул дорой байдлаараа дамжуулан суралцаагүй. Моронайг бичгийн сул дорой байдалдаа санаа зовох үед Бурхан түүнд наманчил гэж хэлээгүй. Оронд нь Их Эзэн түүнд даруу байж, Христэд итгэлтэй байхыг заасан юм. Биднийг даруу, итгэлтэй байх үед Бурхан өршөөлийг бус, ач ивээлийг сул дорой байдлаа даван туулах арга зам болгон өгдөг. Библийн толь бичигт нигүүлсэл бол өөрсдийнхөө хүчээр (Библийн толь бичиг, “Нигүүлсэл”—ийг үзнэ үү) хийж чадахгүй зүйлүүдээ Бурханы боломжтой болгогч хүчээр—“сул дорой зүйлүүдийг хүчтэй болгож” чадах Түүний бурханаг тусламжаар хийх явдал юм гэж тодорхойлсон байдаг.

### Даруу байдал ба итгэлийг хөгжүүлэх нь

Сүм байгуулагдсан үеэс эхлэн бид наманчлалын чухал элементүүдийг заалгаж байгаа ч даруу байдал

ба итгэлээ хэрхэн өсгөн нэмэгдүүлдэг вэ? Дараах зүйлсийг хийх талаар бодож үз:

- **Тунгаан бодож, залбир.** Бид сул дорой учраас *нүгэл* (оюун бодол, зүрх сэтгэл болон зан чанараа даруйхан, гүн гүнзгий өөрчлөх дуудлага) эсвэл *сул дорой* (даруу, тогтвортой хүчин чармайлт, суралцах болон өсөж сайжрах дуудлага) байдалтай тэмцэж байгаа эсэхээ ялгахгүй байж болох юм. Эдгээрийг хэрхэн харж байгаагаас бидний өсөлт болон бие даах байдлын маань түвшин тодорхойлогдох болно. Нэг зан чанарт нүгэл ба сул дорой байдлуудын шинжүүд аль аль нь байж болно. Нүгэл бол үнэхээр сул дорой байдал гэж хэлэх нь наманчлахын оронд зөвтгөж буй хэрэг болдог. Сул дорой байдал нь нүгэл гэж хэлэх нь ичгүүр, буруутгал, цөхрөлийн болон Бурханы амлаалуудад бууж өгөх үндэс болж болно. Тунгаан бодож, мөн залбирах нь эдгээрийг ялган танихад бидэнд тусалдаг.
- **Чухал зүйлээ тодорхойл.** Бид сул дорой учраас нэг удаад хэрэгтэй бүх өөрчлөлтийг хийж чадахгүй. Бид даруухан, мөн итгэлтэй байж, хүмүүний сул талуудаа даван туулахаар багаар багаар хичээх үед мунхаг зан чанараа мөн бага багаар багасгаж, эдгээр хэв маягийг сайн хэвшил болгож, биеийн болон сэтгэл санааны эрүүл мэнд, тамир тэнхээгээ сайжруулж, Их Эзэнд итгэх итгэлээ өсөн нэмэгдүүлж чадна. Бурхан бидэнд хаанаас эхлэхээ мэдэхэд тусалж чадна.
- **Төлөвлөгөө гарга.** Бид сул дорой учраас хүчтэй болох нь зөв шударга хүсэлтэй болон хувийн

сахилга баттай байхаас илүү олон зүйлийг шаардах болно. Бид бас төлөвлөж, алдаануудаасаа суралцан, илүү үр дүнтэй төлөвлөгөөнүүд боловсруулж, төлөвлөгөөгөө засварлах, мөн дахин хийх хэрэгтэй. Бидэнд судар, холбогдох номнуудын болон бусад хүний тусламж хэрэгтэй. Бид жижиг зүйлээс эхэлж, гаргаж буй өсөлтдөө баярлаж, эрсдлүүдийг хүлээн авдаг (хэдийгээр тэдгээр нь биднийг эмзэглүүлж, сул дорой болгодог ч). Бид ядарч эсвэл сэтгэлээр унаж, мөн хальтрах үедээ зам дээрээ эргэн очихоор төлөвлөж байхад ч гэсэн сайн сонголтууд хийхэд бидэнд тусламж дэмжлэг хэрэгтэй байдаг.

- **Тэвчээрийг хөгжүүл.** Бид сул дорой учраас өөрчлөлт нь цаг хугацаа шаардаж болох юм. Бид зөвхөн нүгэлд бууж өгдөг арга замаараа сул дорой байдлуудад бууж өгдөггүй. Даруухан шавь нар шаардлагатай зүйлсийг өөрсдийн хүслээр хийж, уян хатан суралцаж, үргэлжлүүлэн хичээж, бууж өгдөггүй. Даруу байдал нь өөрсдөдөө болон бидэн шиг сул дорой бусад хүнд тэвчээртэй байхад тусалдаг. Тэвчээр нь бидний Их Эзэнд итгэх итгэл, бидэнд итгэж буй Түүний итгэлд талархах талархлын, мөн Түүний амлалтуудад итгэх бидний итгэлийн илрэл билээ.

Бид гэм нүглүүдээ чин сэтгэлээсээ наманчилж, өршөөгдөн, дахин цэвэр болсон ч сул дорой хэвээр үлддэг. Бид өвчин, сэтгэлийн хөдөлгөөн, мунхаглал, өртөмтгий байдал, тахал болон уруу таталтуудад харьяалагддаг хэвээр үлдэх болно. *Хязгаарлагдмал болон хангалтгүй байдал нь нүгэл биш бөгөөд биднийг цэвэр байж, Сүнсийг хүлээж авахуйц зохистой байхад саад болдоггүй.*

### **Сул дорой байдлаас хүчирхэгжих нь**

Сатан бидний сул дорой байдлыг биднээр нүгэл үйлдүүлж, уруу татахын тулд ашиглах хүсэлтэй байдаг бол Бурхан бидний сул дорой байдлыг бидэнд зааж, биднийг хүчирхэгжүүлж бас адислахын тулд ашигладаг.





**АШИГГҮЙ ХУУРАМЧ ИЧГҮҮРЭЭС ҮР ДҮНТЭЙ ГЭМШИЛ (БУРХАНЛАГ ХАРУУСАЛ)  
БОЛОН ДАРУУ БАЙДЛЫГ ЯЛГАН ТАНИХ НЬ**

| Үр дүнтэй гэмшил бол нүглийнхээ төлөө бурханлагаар харуусах                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | Итгэл болон даруу байдал нь сул дорой байдалд Христийнхтэй адил хүлцэнгүй даруу байх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | Хор хөнөөлтэй ичгүүр бол ашиггүй хуурамч зүйл                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p align="center"><b>Бид:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Ёс суртахууны хэм хэмжээг зөрчсөндөө харамсах</li> <li>• Оюун бодол, зүрх сэтгэл, зан чанараа өөрчлөн, наманчлах</li> <li>• Нээлттэй байж, буруугаа хүлээн, алдаагаа засах</li> <li>• Өсөж хөгжин, суралцах</li> <li>• Өөрсдийнхөө төрөлхийн сайн, үнэ цэнэтэй зүйлсийг олж харах</li> <li>• Өөрсдийнхөө зан аашийг эерэг зан чанаруудтайгаа нийцүүлэх</li> <li>• Христийн Цагаатгалын гэтэлгэгч хүчинд бүрэн дүүрэн итгэх хүсэл эрмэлзэлтэй байх хандлагатай.</li> </ul> | <p align="center"><b>Бид:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Биеийнхээ төгс бус байдлыг тайвнаар хүлээн авч, өөрийгөө байгаагаар нь хүлээн зөвшөөрөх</li> <li>• Өсөж хөгжих, хувь нэмрээ оруулах эрсдлүүдийг хүлээн авах</li> <li>• Алдаанууддаа үүрэг хариуцлага хүлээж, өсөж хөгжихийг хүсэх</li> <li>• Алдаанаасаа суралцаж, дахин хичээх</li> <li>• Хошин мэдрэмжүүдээ хөгжүүлж, амьдралд болон бусдад таатай хандах</li> <li>• Бусдыг ойлгож сурснаар өөрсдийнхөө сул доройг олж харах</li> <li>• Бусдын сул тал, дутагдлуудад тэвчээртэй хандах</li> <li>• Бурханы хайр болон тусламжинд итгэх итгэлээ нэмэгдүүлэх хандлагатай байдаг.</li> </ul> | <p align="center"><b>Бид:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Үнэ цэнэгүй, цөхөрсөн мэдрэмжтэй байх</li> <li>• Бусдаас сул талуудаа нуухыг хичээх</li> <li>• Айдсаа ил гаргах</li> <li>• Асуудлынх нь төлөө бусдыг буруутгах</li> <li>• Эрсдлээс айж, бүтэлгүйтлийг элэг доог болно гэж үзэх</li> <li>• Бусадтай өрсөлдөж, өөрсдийгөө бусадтай харьцуулах</li> <li>• Өөрийгөө зөвтгөсөн, зөрүүд, шийдвэр гаргах чадваргүй болох</li> <li>• Егөөдөх эсвэл хэт нухацтай байх</li> <li>• Алдаа дутагдлууд эсвэл давуу талууд дээрээ төвлөрөх</li> <li>• Бурханд хүлээн зөвшөөрөгдөхгүй эсвэл дургүй байхаас айх хандлагатай байдаг.</li> </ul> |

Бидний найдаж байгаагийн эсрэгээр нь, Бурхан үргэлж бидний сул дорой байдлыг багасгаснаар “сул дорой зүйлүүдийг хүчирхэг” болгодоггүй. Төлөөлөгч Паул Сатан түүнийг зовоож “махан биед нь өгөгдсөн өргөсийг” салган авахыг Бурханаас олон удаа залбиран гуйжээ. Бурхан Паулд хандан “Миний нигүүлсэл чамд хангалттай: Учир нь мөхөс байдал дотор миний хүч бүрэн төгс болно” (2 Коринт 12:7, 9) гэжээ.

Их Эзэнд “сул дорой зүйлүүдийг хүчирхэг” болгодог олон арга зам байдаг. Тэрээр бидний найдаж байгаачлан, эрс өөрчлөх замаар бидний сул дорой байдлыг багасгаж болох ч миний хувийн туршлагаар бол энэ нь маш ховор тохиолддог. Жишээ нь, Ифер 12-р бүлэг дээрх хүн бүрийн мэддэг шүлгийн дараа Бурхан Моронайн сул дорой байдлыг багасгасан ямар нэгэн нотолгоог бид олж хардаггүй. Бурхан биднийг сул дорой байдалтайгаа ажиллахад, тэдний талаар зохих мэдрэмж эсвэл ойлголтуудыг олж аван, мөн цаг хугацаа өнгөрөх тусам тэдгээр сул дорой байдал дээрээ өсөж хөгжихөд тусалснаар сул дорой зүйлүүдийг хүчирхэг болгож болох юм. Түүнчлэн, хүчтэй болон сул талууд нь ихэнхдээ холбоотой байдаг (шаргуу хичээнгүй байдал нь хүчтэй тал ба гэжүүд байдал нь сул тал) бөгөөд бид хүчтэй талаа үнэлж, үүнтэй хамт явдаг сул талаа багасгаж сурах хэрэгтэй.

Бурхан бидэнд сул дорой зүйлүүдийг хүчирхэг болгож өгдөг өөр нэгэн хүчирхэг арга зам байдаг. Их Эзэн Моронайд хандан Ифер 12:37-р шүлэгт “Чи өөрийн сул доройг харсны учир чи, миний Эцэгийн эзэмшилд миний бэлтгэсэн байранд суух хүртэл хүчирхэг болгогдох болно” хэмээн хэлсэн байдаг.

Энд Бурхан Моронайн сул талыг өөрчлөхийг бус, харин Моронайг өөрчлөхийг хүссэн тухай гарч байна. Хүмүүний сул тал болох сорилтыг даван туулснаар, Моронай болон бид энэрэл, нигүүлсэл, даруу байдал, тэвчээр, зориг, удаан тэсвэрлэх, мэргэн ухаан, тэсвэр хатуужил, уучлал, уян хатан байдал, талархал, бүтээлч байдал болон биднийг Тэнгэрлэг Эцэгтэй илүү адил болгодог бусад олон эрхэмлэх чанараас суралцаж чадна. Эдгээр нь бидний дэлхий дээр хөгжүүлэхээр ирсэн зан чанарууд бөгөөд дээр орших харшид биднийг бэлтгэдэг Христийнхтэй адил зан чанарууд юм.

Түүний чадвараар дамжуулан бидний сул талтайгаа тэмцэж буй тэмцэл нь Түүнтэй илүү адил болгодог хэмжээлшгүй бурханлаг ариун журам хийгээд хүчтэй талууд болон хувирахаас илүү Бурханы хайр, мэргэн ухаан болон гэтэлгэлийн хүч хаана ч байхгүй нь тодорхой юм. ■

*Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.*









Далын  
ахлагч  
В.Кристофер  
Ваддэлл

# ЦЭВЭР АРИУН СҮСЭГ бишрэл

*Аминч бус үйлчлэл буюу өөрсдийгөө мартаж, бусдын хэрэгцээнд хариулж, амьдралаа бусдад үйлчлэхэд зориулах нь үргэлж Есүс Христийн дагалдагчдын зан чанар байсаар ирсэн.*

**М**атай 11-р бүлэг дээр Аврагч Иохан баптис-тын шавь нарын асуусан асуултад хариулах гүй байснаар бидэнд нэгэн чухал хичээлийг заасан юм.

“Иохан шоронд байхдаа Христийн үйлсийг сонсоод хоёр шавиар үг дайж,

“Түүнээс “Та ирэх ёстой нэгэн мөн үү, эсвэл бид өөр нэгнийг хүлээх ёстой юм уу” гэж асуулгав.

“Есүс хариуд нь тэдэнд явж, үзсэн дуулснаа Иоханд хэл:

“Сохор нь хараа орж, суунги нь алхаж, уяман өвчтөнүүд нь цэвэршиж, дүлий нь сонсож, үхэгсэд нь амилж, ядууст сайн мэдээ тунхаглагдаж байна” (Матай 11:2–5) гэв.

Аврагч Өөрийгөө “ирэх ёстой Тэр нь” хэмээн тодорхойлж, сургаалын богинохон тайлбар өгөхөөсөө илүүтэй Өөрийн хийсэн зүйлүүд болох Өөрийн үйлчлэлийн үлгэр жишээгээр хариулсан юм.

2014 оны Ерөнхий чуулган дээр Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скотт бидэнд сануулснаар: “Бид бусдад үйлчилж, тэдэнд сайнаар нөлөөлснөөр Тэнгэр дэх Эцэгтээ хамгийн сайн үйлчилдэг. Энэ дэлхий дээр оршиж байсан хамгийн агуу үлгэр жишээ бол бидний Аврагч Есүс Христ юм.”<sup>1</sup>

Аминч бус үйлчлэл буюу өөрсдийгөө мартаж, бусдын хэрэгцээнд хариулах болон амьдралаа бусдад үйлчлэхэд зориулах нь үргэлж Есүс Христийн дагалдагчдын зан

чанар байсаар ирсэн. Аврагчийн төрөлтөөс 100 гаруй жилийн өмнө хаан Бэнжамин заахдаа: “Та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа” (Mosiah 2:17) хэрэг юм гэжээ.

Биднийг “зовж зүдрэх цагт нь өнчин хүмүүс, бэлэвсэн эхнэрүүдийг эргэж тойрох үед” бусдад үйлчлэх үйлчлэлийн маань “цэвэр ариун сүсэглэлийн” мөн чанар харагддаг гэж (Иаков 1:27) Иаков бидэнд сануулдаг. “Цэвэр ариун сүсэглэл” нь итгэлээ тунхаглахаас ч илүү чухал юм; Энэ нь итгэлээ харуулах явдал юм.

## Хамт аялж буй хүмүүсээ хайрла

1984 оны 7-р сарын дундуур эхнэр Кэрол бид хоёр Калифорнийн Лос Анжелес ариун сүмд гэрлэснээс хэдхэн долоо хоногийн дараа Юта руу явахаар замдаа гарсан байлаа. Тэнд би ажлын гараагаа эхэлж, Кэрол коллежоо төгсөх байв. Бид өөр өөр машин жоолодож явсан юм. Хоёр машинаараа бид бүх зүйлээ тээвэрлэсэн байлаа.

Хүрэх газрынхаа бараг талд нь орж байтал Кэрол миний машиныг гүйцэн ирж, анхаарлыг маань таах үйлдэл хийж эхлэв. Энэ нь гар утас, ухаалаг гар утас, мессэж болон твиттэр гарахаас өмнөх үе байв. Машиных нь цонхоор царайг нь хараад, түүнийг сайн биш байгааг хэлж болохоор байв. Тэр үргэлжлүүлэн

жолоодож чадна гэдгээ дохиогоор хэлсэн ч би шинэхэн сүйт бүсгүйдээ санаа зовж байлаа.

Биднийг Ютагийн Бийвр гэдэг жижигхэн тосгонд дөхөж ирэх үед тэр дахин намайг гүйцэн ирэхэд нь би түүнийг цааш үргэлжлүүлэх боломжгүй байгааг анзаарсан юм. Тэр өвдсөн байсан бөгөөд цааш явж чадахааргүй байв. Бидэнд хоёр машин дүүрэн хувцас болон хуримын бэлгүүд байсан ч харамсалтай нь мөнгө бага байсан юм. Зочид буудлын өрөөний үнэ бидний төсвөөс хэтэрсэн байв. Би юу хийхээ мэдэхгүй байлаа.

Бидний хэн нь ч өмнө нь Бийврт очиж үзээгүй байсан бөгөөд юу хайж байгаагаа ч мэдэлгүй, хэдэн минут машинаараа явж байгаад, нэгэн цэцэрлэгт хүрээлэнг олж харлаа. Бид зогсоол дээр зогсож, нэгэн сүүдэртэй мод олов. Модны сүүдэрт Кэролыг амрахаар би тэнд хөнжил дэвсэв.

Хэдхэн минутын дараа хоосон зогсоолын ойролцоо өөр нэгэн машин ирж, манай хоёр машины хажууд зогслоо. Ээжтэй минь ойролцоо насны нэгэн эмэгтэй машинаасаа бууж ирэн, ямар нэг зүйл тохиолдсон эсэхийг, мөн түүний тусламж хэрэгтэй эсэхийг асуув. Тэр бидний хажуугаар өнгөрөхдөө биднийг анзаарсан байсан бөгөөд түүнд зогсох хэрэгтэй гэсэн мэдрэмж төрснийг хэлэв. Биднийг нөхцөл байдлаа тайлбарлахад тэр биднийг тэр даруй гэртээ дагаж очиход уриад, тэнд хүссэнээрээ удаан амарч болно гэлээ.

Бид удалгүй түүний гэрийн доод давхрын гайхалтай унтлагын өрөөний тав тухтай орон дээр хэвтсэн байлаа. Биднийг ая тухаа олмогц, энэ гайхалтай эгч хийх ажил их байгаа бөгөөд хэдэн цаг биднийг хоёуланг нь үлдээж явах хэрэгтэйгээ хэлэв. Хэрэв биднийг өлсвөл гал тогооноос хүссэн зүйлээ идэж болох бөгөөд түүнийг эргэж ирэхээс өмнө явахаар бол урд хаалгаа хаагаарай гэлээ.

Шаардлагатай нойроо авсны дараа Кэролын бие сайжирч, бид гал тогоонд оролгүйгээр аяллаа үргэлжлүүлсэн юм. Биднийг явах үед сайхан сэтгэлт эмэгтэй гэртээ хараахан ирээгүй байв. Бид ичсэнээсээ болоод хаягийг нь ч тэмдэглэж аваагүй бөгөөд зам дээр зогсож, хэрэгтэй үед нь танихгүй хүмүүсийг гэртээ оруулсан өөрсдийн сайн санаат самари хүнд талархлаа хэзээ ч зохих ёсоор илэрхийлээгүй юм.

Намайг энэ үйл явдлыг тунгаан бодох үед Аврагчийн “Явж, үүний дагуу үйлдэгтүн” (Лук 10:37-г үзнэ үү) хэмээх зөвлөгөөг агуулдаг ерөнхийлөгч Томас С.Монсоны “Хэрэв бид энэхүү мөнх бус амьдралын аянд хамт аялж буй хүмүүсээ хайрлахгүй юм бол Бурханыг чин үнэнээсээ хайрлаж чадахгүй”<sup>2</sup> хэмээх үгс санаанд ордог.

Бид гэртээ харих замдаа, сургуулийнхаа тоглоомын

талбай дээр, ажлын байран дээрээ, эсвэл сүм дээр “хамт яваа аялагчидтай” таарах бүрдээ эрэлхийлж, харж бас үйлдэх юм бол замын дагуу адисалж бас үйлчлэн, Аврагчтай илүү адил болох болно.

## Эрэлхийл

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл А.Максвэлл (1926–2004) заахдаа:

“Эрхэм Аврагчаасаа ялгаатай нь, бид мэдээж хүн төрөлхтний гэм нүглийг цагаатгаж чадахгүй” гэсэн юм. Үүнээс гадна, бид мэдээж хэрэг бүх төрлийн өвчин, сул дорой чанарууд болон шаналлыг тэвчиж чадахгүй (Алма 7:11–12-ыг үзнэ үү).

“Гэсэн хэдий ч, бидний хийж чадах хэсэг нь Есүсийн урьснаар бид бүр [Түүнтэй адил] (3 Нифай 27:27).”<sup>3</sup> болохоор хичээж чадна.

Бид “хамт яваа аялагчдаа” адислах чин хүсэлтэйгээр, бүр Түүнтэй адил болохыг эрэлхийлснээр өөрсдийгөө мартаж, бусдыг өргөх боломжуудаар хангагдах болно. Эдгээр боломж нь ихэнхдээ тохиромжгүй байж болох ч хамгийн агуу үйлчлэл болох Төгсгөлгүй Цагаатгалыг хийсэн тэр Эзэнтэй илүү адил болох бидний жинхэнэ хүслийг сорих нь ямар ч байсан боломжтой зүйл юм. “Гэсэн хэдий ч, алдар суу нь Эцэгт байх болтугай, мөн бибээр хүртэж мөн хүмүүний үрсийн төлөө өөрийн бэлтгэлүүдийг дуусгасан билээ” (С ба Г 19:19) гэж Тэр айлдав.

Аврагчтай илүү адил байхын тулд чин сэтгэлээсээ эрэлхийлэх нь бид өөр ямар байж болохгүйгээ харах боломжийг олгодог. Бидний сайн самари хүн сүнслэг өдөөлтөд хариулахдаа болон танихгүй хүнийг тусламж хэрэгтэй үед нь олж очихуйцаар Сүнсэнд хангалттай ойр амьдарч байв.

## Хар

Сүнслэг нүдээр харах нь аливаа зүйлийг яг жинхэнэ байдлаар нь харахыг, мөн бидний анзаараагүй байж болох хэрэгцээнүүдийг ялган танихыг хэлдэг. Хонь, ямааны сургаалт зүйрлэлд “адислагдсан” хүмүүс нь ч, бас “зүхэгдсэн” хүмүүс нь ч өлссөн, цангасан, нүцгэрсэн эсвэл шоронд байсан тэр хүмүүс дотор байсан Аврагчийг таньсангүй. Тэд шагналаа авахдаа “Бид Таныг хэзээ харсан билээ?” хэмээн хариулав (Матай 25:34–44-ийг үзнэ үү).

Сүнслэг нүдээр харсан, мөн тусламж хэрэгтэй байгаа хүмүүсийг таньсан тэдгээр хүн үйлдэл хийж, зовсон хүмүүсийг адисалсан юм. Бидний сайн самари хүн сүнслэг нүдээрээ харах үедээ тусламж хэрэгтэй нэгнийг таньжээ.



## Үйлд

Бид эргэн тойрныхоо тусламж хэрэгтэй хүмүүсийг харсан ч бидний хийж чадах зүйл хангалтгүй гэж үзэн, тэдэнд туслах хангалттай мэдрэмж төрөхгүй байж болно. Бид Их Эзэнтэй адил болохыг эрэлхийлж, сүнслэг нүдээр хамт яваа аялагчдынхаа хэрэгцээнүүдийг олж харах үед Тэрээр биднээр дамжуулан ажиллаж чадна гэдэгт итгээд, дараа нь үйлдэл хийх ёстой.

Ариун сүмд орохдоо Петр, Иохан нар “төрөлхийн хазгар нэгэн хүн тэднээс гуйлга гуйж” (Үйлс 3:1–3-ыг үзнэ үү) байгааг харав. Петрийн хариулт бид бүгдэд жишээ үзүүлж, нэгэн урилгыг өгсөн юм:

“Надад алт мөнгө байхгүй. Харин өөрт байгаагаа л би чамд өгье гээд, Назарын Есүс Христийн нэрээр босоод явагтун хэмээн хэлээд,

“Баруун гараас нь барьж, түүнийг өндийлгөв” (Үйлс 3:6–7).

Бид өөрсдийн цаг зав, авьяас чадвар, урмын үгийг, эсвэл хөдөлмөрөө зориулснаар бас үйлдэж болно. Бид эрэлхийлж, бас харах үедээ үйлдэж бас адисалж болох нөхцөл байдалтэй тулгарах болно. Сайн самари хүн үйлдсэн. Тэр биднийг гэртээ аваачин, өөрт байсан зүйлүүдээр биднийг хангасан билээ. Үндсэндээ тэр “өөрт байгаагаа л чамд өгье” гэж хэлсэн юм. Энэ бол чухамдаа бидэнд хэрэгтэй байсан тэр л зүйл байлаа.

Ерөнхийлөгч Монсон эдгээр адил зарчмыг заасан юм: Мөнх бус аялалдаа бид бүгд Иерихо орох өөрийн замаар аялах болно. Та нарын туршлага ямар байх бол? Минийх ямар байх бол? Хулгайч нарын дунд хэвтэж буй хэн нэгэнд миний тусламж хэрэгтэй байвал би анзаарахгүй байх уу? Та яах вэ?

“Гэмтсэн нэгнийг хараад, гуйлтыг нь сонссон атлаа туслахаас татгалзах нэгэн нь би байх уу? Та яах вэ?

“Эсвэл би хардаг, сонсдог, зогсдог, тусалдаг нэгэн болох уу?” Та яах вэ?

“Есүс биднийг “Явж мөн үүний нэгэн адил үйлд” хэмээн урьсан билээ. Бид энэхүү тунхагт дуулгавартай байснаар зарим үед тэнцүүхэн байдаг, хэзээ ч хэтэрдэггүй мөнхийн баяр баясгалангийн ойлголт нээгддэг.”<sup>4</sup>

Бид эрэлхийлж, харж, үйлдсэнээр Аврагчтай илүү адил болох үед хаан Бенжамины хэлсэн үгийн үнэнийг мэдэх болно: “Та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу” (Мозая 2:17). ■

## ЭШЛЭЛҮҮД

1. Ричард Г. Скотт, “Би та нарт жишээ үзүүлсэн юм,” *Лиакхона*, 2014 оны 5-р сар, 35.
2. Томас С. Монсон, “Хайр бол сайн мэдээний үндсэн зарчим,” *Лиакхона*, 2014

- оны 5-р сар, 91.
3. Нийл А. Максвэлл, “Apply the Atoning Blood of Christ,” *Ensign*, 1997 оны 11-р сар, 22.
4. Томас С. Монсон, “Your Jericho Road,” *Ensign*, 1977 оны 9-р сар, 71.

ЧИН СЭТГЭЛЭЭСЭЭ ЭРЭЛХИЙЛ

СҮНСЛЭГ НҮДЭЭР ХАР

ҮЙЛДЭЖ, АДИСАЛ









# “Та надад үргэлж ХЭРЭГТЭЙ”

*Биднийг өөр юу заахаа мэдэхгүй байх үед,  
хамтрагч маань энэ дуулыг дуулахыг  
санал болгов.*

**Жонатан Х.Вэстовэр**

**С**олонгосын Балсан хотод номлолоо хийж байсан тэр сайхан ням гаргийн үдээс хойш хамтрагч бид хоёр Сүм тарсны дараа гишүүдэд баяртай гэж хэлээд, тойргийн номлолын удирдагчийн бидэнд танилцуулсан 12 настай хүү Кон Сүн-Гянд сайн мэдээ заахаар төлөвлөж байлаа. Тэр хүү тэр өдөр Сүмд ирсэн байсан ба сайн мэдээний талаар илүү ихийг суралцахыг хүссэн юм.

Бид мэдээж түүнд заах боломжтой байсандаа баяртай байсан ч, ийм бага насны хүүд зааж болох эсэхэд санаа зовж байлаа. Бид түүний эцэг эхийн зөвшөөрлийг авахаар шийдсэн учраас Кон Сүн-Гяны гэр рүү утасдаж, түүний ээж Пак Ми-Жүнтэй товчхон ярих. Түүний хүү Сүмд явахаар сонирхож байгаад нь, мөн хүүдээ биднээр хичээл заалгуулахдаа баяртай байгаагаа хэлэхэд би ихэд баярлаж билээ.

## **Гэнэтийн сонирхогчид**

Маргааш орой нь бид хүүд заахаар гэрт нь очсон юм. Пак Ми-Жүн бас охин Кон Сү-Жиндоо заалгуулах хүсэлтэй байгааг олж мэдээд бид баяртай байв. Бид тэдний шинэ зочид учраас Пак Ми-Жүн хичээлүүдэд суухыг хүсэв. Мэдээж хэрэг, бид сонсохыг хүссэн хүн бүрд заахдаа баяртай байлаа.

Тэд биднийг хөнгөн зуушаар дайлсны дараа бид

хамтдаа сууж, ярилцаж эхлэв. Биднийг хичээлээ эхлэхээс өмнө Пак Ми-Жүн бидэнтэй илүү сайн танилцаж, бас гэр бүлийнхээ нөхцөл байдлын талаар бидэнд хэлэхийг хүссэн юм. Тэрээр саяхнаас хүү нь хорт хавдартай болж, хүнд сорилт бэрхшээлүүд тулгарсан тухай бидэнд ярих. Түүний туяа эмчилгээ амжилттай болсон бөгөөд хорт хавдар нь одоогоор багассан ч эмч нар үүнийг хэзээ ч сэдэрч магадгүй гэж анхааруулсан байлаа. Энэ нь тэр гэр бүлд хүнд тусаж байв. Тэд ажилчин гэр бүл байсан бөгөөд аав нь тэднийг зөвхөн хоргодох гэр оронтой, ширээн дээр нь хоолтой байлгахын тулд маш шаргуу ажиллах ёстой байдаг байв.

Тэдний амьдрал дахь хүнд сорилтуудыг сонсоод би цочирдсон бөгөөд харамсаж байлаа. Амьдрал тэдний хувьд амаргүй байсан ч тэр гэр бүл дэх нэгдмэл байдал нь Солонгост миний уулзаж байсан ямар ч гэр бүлээс илүү байсан нь тодорхой байв. Энэ нь гэр бүлд чиглэсэн Солонгос шиг нийгэмд ихийг өгүүлдэг. Бид тэр орой энэ онцгой гэр бүлийн тухай илүү сайн мэдэж аван, тэдэнтэй сайн мэдээний захиасуудыг хуваалцах боломжтой байсан билээ.

Хамтрагч бид хоёр тэр долоо хоног хэд хэдэн удаа тэдэнд заахаар буцаж очсон юм. Очих бүрдээ анх очихдоо мэдэрсэн шиг халуун дулааныг мэдэрдэг байв. Биднийг баптисмын тухай ярилцахад хүүхдүүд хоёулаа



Сүмд нэгдэх хүсэлтэй байлаа. Гэсэн хэдий ч ээж нь адил сэтгэгдэлтэй байгаагүй юм. Бидний заасан зүйлс түүнд хүрч, тэр үүнийг үнэн гэж найдаж байсан ч тэр Сүмд нэгдсэнээр хийх шаардлагатай амлалтуудыг хийж, бас дагаж чадна гэж бодохгүй байв. Тэр бас нөхөргүйгээр ганцаараа баптисм хүртэх нь түүний хувьд зохистой зүйл гэж бодохгүй байв. Бид нөхөртэй нь хараахан уулзаж амжаагүй байсан юм. Гэвч тэр бидэнтэй үргэлжлүүлэн уулзаж, хүүхдүүдээ Сүмд явуулахыг хүсэж байлаа.

Хоёр дахь долоо хоногийн төгсгөлд бид түүний гэрт үргэлжлүүлэн зааж байх үедээ түүний нөхөр болох даруухан, эелдэг, сайхан сэтгэлтэй Кон Күк Вонтой танилцав. Сүүлийн хэдэн ярилцлагын үеэр тэр бидэнтэй нэгдсэн бөгөөд бидний заасан бүх зүйлд, тэр тусмаа бусад хүний хэцүү гэж хүлээж авдаг аравны нэг болон мэргэн ухааны үг гэх мэт сургаалуудад хүртэл маш хурдан итгэж байв. Тэд санхүүгийн хүнд нөхцөлд орсон байсан ч аравны нэгээ төлж эхэлсэн юм. Аавынх нь цорын ганц бэрхшээл бол ням гарагт ажиллах ёстой явдал байв. Тэр Сөүлийн олон улсын нисэх онгоцны буудалд ням гараг бүр ажилладаг байсан учир гэр бүлийнхэнтэйгээ хамт Сүмд явах боломжгүй байв. Тэрээр ажлынхаа хуваариас үл хамааран эхнэртэйгээ дараагийн ням гарагт хүүхдүүдийнхээ баптисмд ирэхээр төлөвлөсөн байв.

Хүүхдүүдийнх нь баптисмын дараа ч бид энэ гэр бүлтэй тогтмол уулзаж байлаа. Бид гэр бүлийн үдэш хийж, судруудыг болон урам өгөхүйц туршлагаудаа хуваалцан, тэднийг тойргийн гишүүдтэй танилцуулсан юм. Эцэг эх нь сайн мэдээний талаар сонссоор байсан ч баптисм хүртэх болоогүй л байв.

Хамтрагч маань солигдож, Номлогчийг бэлтгэх төвөөс дөнгөж ирсэн ахлагч миний шинэ хамтрагч болсон юм. Тэр итгэл, эрч хүч, баяр хөөрөөр дүүрэн байсан бөгөөд үнэндээ түүнийг гүйцэж ажиллахад надад хэцүү байлаа. Кон Күк Вон, Пак Ми Жүн хоёртой хэд хэд уулзсаны дараа хамтрагч маань надаас, өмнөх хамтрагчтайгаа тэдний төлөө мацаг барьсан эсэхийг асуув. Бид мацаг бариагүй байсан юм. Үнэндээ, ийм бодол надад огт орж ирээгүй байв. Тиймээс бид тэр гэр бүлтэй уулзаж, мацаг барихыг санал болгов. Тэд өмнө нь хүүгийнхээ эрүүл мэндийн төлөө болон Кон Күк Воныг Сүмд явах боломжтой болгохын тулд ажлынх нь



**Биднийг сүүлийн бадгийг дуулж дуусахад өрөөнд Сүнс маш хүчтэй мэдрэгдэж байв. Тэр миний нүд рүү эгцэлж хараад, “Би баптисм хүртэх хэрэгтэй” гэж хэлэв.**

хуваарь өөрчлөгдөхийн төлөө өөрсдөө мацаг барьсан тухай сонсоод, би гайхаж билээ. Хамтрагч бид хоёрыг тэдэнтэй хамт мацаг барьсны дараа бидний залбирлууд хариулагдаж, Кон Күк Воны ажлын хуваарь өөрчлөгдсөн юм. Гэвч Пак Ми Жүний баптисм хүртэхгүй байх бодол нь хэвээр байв.

### **Сүнслэгээр өдөөгдсөн санаа**

Хамтрагчид маань дараа нь өөр нэгэн гайхалтай санаа төрөв. Тэр жижигхэн дууллын номоо гаргаж ирээд, тэдэнтэй хамт дуулал дуулж болох уу гэж асуув.



Бид өмнө нь хааяа хамт дуулдаг байсан ч, би хэзээ ч Пак Ми Жүнг дуулж байгааг хараагүй бөгөөд дуу нь түүний хувьд шинэ учраас түүнийг дуулах дургүй эсвэл эвгүй байдаг байх гэж таамагладаг байсан юм. Хамтрагч маань түүнээс дуртай дуу байгаа эсэхийг асуухад хамгийн гайхалтай нь тэрээр хоолойгоо засан, жаахан охин байхаас нь л түүний дуртай дуулал нь “Та надад үргэлж хэрэгтэй” (*Hutns*, дугаар 98) байсан гэж хариулав. Бид дөрвөн өнгөөр дуулж эхлэв. Аав нь дууг аялан, ээж нь альтаар, хамтрагч маань тенор хоолойгоор, би бассаар дуулав.

Өрөөнд Сүнс маш хүчтэй мэдрэгдэж байв. Биднийг гуравдугаар бадгийг дуулж эхлэхэд түүний сэтгэл хөдлөн дуулах үедээ хоолой нь тасалдаж байв.

*“Та надад үргэлж хэрэгтэй”*

*Баяр хөөрт гунигт үед*

*Хурдан оршихоор ирээч,*

*Эсвээс бүгд утгагүй*

*Тийм надад хэрэгтэй та,*

*Үргэлж хэрэгтэй та*

*Хайрт Аврагч минь намайг та*

*Байнга адислаач!*

Биднийг 4 дэх буюу сүүлийн бадгийг дуулж дуусахад тэрээр уйлж байлаа. Нөхөр нь түүнийг тайвшруулахаар хичээж байсан ч, тэрээр эцэст нь өөрөө тайвширсан юм. Тэр миний нүд рүү эгцлэн хараад, “Би баптисм хүртэх хэрэгтэй” гэж хэлэв.

Тэр ням гаргийн үдээс хойш болсон, Кон Күк Вон, Пак Ми Жүн хоёрын баптисмын үйл ажиллагаа миний номлолын хамгийн сүнслэг явдлуудын нэг байсан билээ. Тэдний хүүхдүүд баптисмын хөтөлбөрт оролцсон бөгөөд орон нутгийн олон гишүүн тойргийнхоо шинэхэн хөрвөгч гэр бүлд дэмжлэг үзүүлэхээр ирсэн байлаа. Хамтрагч бид хоёр “Та надад үргэлж хэрэгтэй” дууг онцгойлон дуулсан юм.

Эцэст нь миний номлол дуусаж, би гэртээ харив. Коллежид нэг жил суралцсанахаа дараа би зуны дадлагаар Солонгост эргэж ирсэн бөгөөд номлолдоо байхдаа долоо хоног бүр уулзаж байсан онцгой найзууд болон гэр бүлүүд дээр очих цаг гаргалаа. Балсанд буцаж очоод, хэдхэн долоо хоног болсны дараа би энэ онцгой гэр бүлтэй дахин уулзсан юм. Тэдний гэрт эргэж ирээд, би тэнд хэн нэгнийг—тэдний хүүг байхгүй байгааг анзаарав. Пак Ми Жүн нүдэндээ нулимстайгаар тэр мэдээг надтай хуваалцсан юм. Хүүгийнх нь хорт хавдар сэдэрч, 14 настайдаа тэр нас барсан байна.

Намайг эмгэнэл илэрхийлж, мэдэрч байгаа уй гашуугаа дарахаар хичээх үед Кон Күк-Вон зүгээр ээ гэж намайг тайвшруулав. Тэд Сүмдээ итгэлтэйгээр явж, сургаалыг хайрлан, Солонгосын Сөүлийн ариун сүмд гэр бүлээрээ мөнхөд лацдан холбогдох тэр өдрийг харж амьдарсан юм. Тэд зүрхэндээ уй гашууг мэдэрч байсан ч гэр бүл нь Конг Сүн-Гянтай дахин уулзах бөгөөд гэр бүл нь дахин нэгдэнэ гэдгийг мэдэж байлаа. Бас Пак Ми-Жүн өдөр бүр Сүмийн дуулал дуулах нь түүнд даван туулах хүч чадлыг олоход, мөн Ариун Сүнсний авчирдаг тэрхүү амар амгаланг мэдрэхэд тусалж байгааг надад хэлсэн юм.

Тэр орой тэдний гэрээс гарч явахдаа би Пак Ми Жүний дуртай дууллын үгсийг дахин тунгаан бодож билээ. Гон Сүн-Гяныг нас барсны дараа Тэнгэрлэг Эцэг энэ гэр бүлийг амар амгалангаар адисалсанд би талархаж байна. Ялангуяа энэ гэр бүлийг ариун сүмийн мөнхийн адислалуудыг хүлээн авахуйц зохистой болгосон, мөн Пак Ми-Жүний хөрвөлтөд нөлөөлсөн Сүнсний нөлөөнд би талархаж байна. ■

*Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.*

## ДУУЛЛУУД НЬ ГАСУУДСАН ХҮМҮҮСИЙГ ТАЙВШРУУЛДАГ

“Зарим агуу номлолыг Сүмийн дуулал тунхагладаг. Сүмийн дуулал нь биднийг наманчлал ба сайн үйлс рүү хөтөлж, гэрчлэл болон итгэлийг хөгжүүлэн, сул дорой болон гашуудаж буй хүмүүсийг тайвшруулж, биднийг эцсээ хүртэл тэвчихэд урамшуулдаг”.

*“Тэргүүн Зөвлөлийн өмнөх үг,” Дуулал, ix.*



Арванхоёр  
Төлөөлөгчийн  
Чуулгын  
ерөнхийлөгч  
Бойд К.Пакэр

# Аврагчийн аминч бус хийгээд ариун ЗОЛИОСЛЮЛ

*Их Эзэн үргэлж бидний дэргэд бай-  
даг. Хэрэв та Түүнийг Гэтэлгэг-  
чээ гэж хүлээн зөвшөөрөх болбол  
Тэр таны төлөө зовж шаналан,  
шийтгэлийг нөхөн төлсөн.*

**Б**ид бүгд сүнслэг байдлын хувьд зээлийн нөхцөлд амьдардаг. Өр чинь ямар нэгэн байдлаар нэмэгдсээр байх болно. Хэрэв та зээлээ хугацаанаас нь өмнө төлбөл санаа зовох шаардлагагүй. Удалгүй та сахилга баттай байхад суралцаж эхлэн, зээлээ төлөх өдөр нисэх мэт хурдан ирснийг анзаарна. Зээлийн хүү нэмэгдэж, торгууль ноогдуултал хүлээхийн оронд сүнслэг өр зээлээ өдөр тутам байнга төл.


Та нар сорилтод ордог учраас заримдаа алдаа гаргадаг. Та нар амьдралдаа харамсах зүйлсийг хийж, уучлалт гуйгаад ч нэмэргүй нөхцөл байдалд



орон, үүнээсээ болж шаналж байсан байх. Амархан арилдаггүй бэхээр бичихтэй адил *гэм буруутай* гэх үгийг хэрэглэх цаг болжээ. Гэм буруутай холбоотой мэдрэмж нь уйтгар, гутрал мөн алдсан адислал, боломжуудынхаа төлөө харамсах харамсал юм.

Хэрэв та гэм буруутайгаа тэмцэж байгаа бол Мормоны Номонд бошиглогчийн зэмлэсэн хүмүүстэй адилгүй гэсэн үг. Тэрээр хэлэхдээ “Тэдний алдсын учир сүм бошиглолын суу билэг, илчлэлтийн суу билэгт итгэхгүй болж эхлэв; мөн Бурханы шүүлтүүд нүүрэн дээр нь тулж иржээ” (Хиламан 4:23) гэжээ.







Бид ихэвчлэн гэм нүглийнхээ төлөөх шаналлыг хөнгөвчилж, өөрсдийгөө тайвшруулахын тулд өрөөл бусдад болон өөрсдөдөө энэ надад огтхон ч хамаагүй гэж хэлдэг. Харин бид зүрх сэтгэл дотроо энэ үгсэд итгэдэггүй. Бид энэ үгийг хэлэхдээ бүр өөрсдөдөө ч хүртэл итгэдэггүй. Учир нь бид энэ нь бидэнд хамаатай гэдгийг мэддэг!

Бошиглогчид үргэлж наманчлалын талаар заасаар ирсэн билээ. Алма “Болгоогтун, тэрээр түүний нэрэнд итгэлтэйн дагуу наманчлалд баптисм хүртэх тэднийг гэтэлгэхээр ирэх болно” хэмээн хэлсэн (Алма 9:27).

Алма өөрийн дуулгаваргүй хүүд шударгаар ийн хэлсэн байдаг. “Эдүгээ, түүнчлэн сүнсний амьдралын адил мөнхийн байх аз жаргалын төлөвлөгөөний эсрэг тавигдсан, сүнсний амьдралын адил мөнхийн байх шийтгэлгүй аваас наманчлал ирж чадахгүй” (Алма 42:16).

Мөнх бус амьдралд зориулсан хоёр чухал зорилго байдаг. Нэгдүгээрт, Хэрэв бид үйлдвэл ариусгагдан, өргөмжлөгдөж, мөн үүрд амьдрах боломжтой бие махбодыг хүлээн авна. Хоёр дахь зорилго нь соригдох юм. Бид соригдохдоо алдаа гаргах нь зайлшгүй. Хэрэв бид хүсвэл алдаанаасаа суралцаж чадна. Судар бидэнд “Хэрэв бид нүгэл үйлдээгүй гэж хэлбэл, бид Түүнийг худалч болгож байгаа хэрэг бөгөөд бидний дотор Түүний үг алга” хэмээн хэлдэг (1 Иохан 1:10).

Та магадгүй “хугацаа өнгөрсөн” гэж тэмдэглэгдсэн сүнслэг өр зээлнийхээ ачаа дарамтаас болж зовж, зүрх сэтгэл, оюун бодолдоо шаналж байгаа байх. Та (бидний ихэнх нь зайлсхийдэг) өөртөйгөө нүүр тулж, чимээгүйхэн өөрийнхөө бодит байдлын талаар тунгаан бодохдоо

танд ямар нэгэн садаа болж байгаа шийдвэрлээгүй зүйл байгаа эсэхийг анзаарсан уу? Танд ямар нэгэн санаа зовох зүйл байна уу? Та хүнд эсвэл хөнгөн ямар нэгэн гэм буруутай мэдрэмжийг мэдэрсээр л байна уу?

Ноцтой гэм нүгэл үйлдэж, ачаа дарамтандаа гудайсан олон хүнээс бидэнд ойр ойрхон захиа ирдэг. Тэд “Би уучлагдах уу? Би өөрчлөгдөж чадах болов уу?” гэж асуудаг. Би тийм гэж хариулдаг!

Паул коринтчуудад заахдаа “Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл юм. Бурхан итгэмжит билээ. Тэр та нарыг хэрээс чинь хэтэрсэн хүчээр соригдохыг зөвшөөрдөггүй, харин сорилтыг тэсвэрлэж чадахын тулд сорилттой хамт мөн гарах замыг ч өгдөг юм” (1 Коринт 10:13) гэжээ.

Сайн мэдээ бидэнд гэм буруугийн төлөө шаналах зовлон шаналлаас гарах арга зам нь наманчлал гэдгийг заадаг. Бүрэн дүүрэн мэдлэгтэй мөртлөө мөхлийн замыг сонгосон цөөхөн хэдэн хүнээс бусад нь их бага ямар ч зуршил, донтолтод автагдаж; зөрчилдөөн, доромжлолыг үйлдсэн байлаа ч бүрэн уучлагдах болно гэсэн амлалт байдаг. Та нарын амьдралд юу ч тохиолдсон байсан хамаагүй, хэрэв Ариун Сүнсний өдөөлтийг дагах юм бол Их Эзэн эргэж ирэх замыг бэлдсэн байдаг.

Зарим хүний оюун санаа уруу таталтын бузар муутаар дүүрсэн байдаг. Энэ нь яваандаа үйлдэл, тэгээд донтолт болдог. Бид зарим гэм нүгэл, буруу зүйлст амархан уруу татагддаг бөгөөд зарим үед бид угаасаа ийм төрсөн болохоор бидэнд буруу байхгүй гэж боддог. Бид мухардалд орж, зөвхөн Аврагч л эдгээж чадах зүрх сэтгэлийн өвдөлт, өвчинд нэрвэгддэг. Танд үүнийг зогсоож, гэтэлгэгдэх хүч чадал бий.



## Сатан гэр бүлүүд рүү дайрдаг

Нэгэн удаа ерөнхийлөгч Марион Ж.Ромни надад хэлэхдээ “Та нарт ойлгуулахын тулд би хэлж байна гэж битгий хэлээрэй; харин та нар буруугаар ойлгохгүй байж болохын тулд би хэлж байна гэж хэлээрэй” гэсэн юм.

Нифай “Учир нь тодорхой байдалд бодгаль минь баяснам; өөрөөр хэлбэл энэ маягаар Их Эзэн Бурхан хүмүүний дунд ажил хийдэг болой” хэмээн хэлжээ (2 Нифай 31:3).

Иймээс анхааралтай сонсоорой! Би үүнийг ярихаар дуудагдаж, үүрэг авсан мэт тодорхой ярих болно.

Та нар дайсан байдаг гэдгийг мэддэг. Судар түүнийг: “Чөтгөр болох, худал бүгдийн эцэг болох тэр, бүр хөгшин могой” мэтээр дүрсэлсэн байдаг (2 Нифай 2:18). Тэр эхлэлээс хөөгдсөн (С ба Г 29:36–38) бөгөөд мөнх бус бие хүлээн авах боломжоо алдсан юм. Тэрээр “аз жаргалын агуу төлөвлөгөөнд” (Алма 42:8) саад болохоор амласан бөгөөд бүх зөв шударгын дайсан болсон билээ. Тэрээр гэр бүлүүд рүү хамгийн их дайрч, давшилдаг.

Та нар порнограф дэлхий даяар газар авч байгаа үед амьдарч байна. Үүнээс зугтахад хэцүү. Амьдралыг бий болгогч та нарын тэрхүү хүчинд порнограф анхаарлаа хандуулж байна.

Порнографыг үзэх нь асуудал бэрхшээл, гэр бүл салаалт, өвчин зовлонд болон бусад олон хор уршиг руу хөтөлдөг. Порнографт ямар ч сайн зүйл байдаггүй. Үүнийг үзэх, цуглуулах, авч явах нь хорт могойг үүргэвчиндээ хийгээд авч яваатай адил юм. Энэ нь чамайг хорт могойн үхлийн хатгалт адил, зугтах аргагүй сүнслэг доройтолд оруулдаг. Дэлхийн хаа сайгүй порнографтай холбоотой хэвлэл мэдээлэл байгаа учраас та нар үүний аймшигт хор уршгийг сайн ойлгохгүйгээр үзэж, уншсан байж болно. Хэрэв



*Бүх цаг үеийн  
хүн төрөлхт-  
ний түүхэнд  
бүх хүн тө-  
рөлхтний  
нүглийг ца-  
гаатгаж,  
тэдний өвчин  
зовлонг тэв-  
чих ганц л гэм  
нүгэлгүй хүн  
байсан юм.*

тэгсэн бол би таныг зогсохыг анхааруулж байна. Яг одоо боль!

Мормоны Ном “хүмүүн нь тэд сайныг муугаас ялгаж мэдэхээр хангалттай зааварлагдсан буюу” хэмээн заадаг (2 Нифай 2:5). Энэ хүмүүсийн тоонд та ч мөн орж байгаа. Та юу буруу, юу зөвийг мэдэж байгаа. Буруу гэж бодож байгаа зүйлээ хийхгүйн тулд бол-гоомжтой байгаарай.

Ихэнх алдааг Их Эзэнд хувиараа хүлээж болдог ч гэсэн зарим гэм нүглээс уучлагдахын тулд илүү их зүйлийг хийх шаардлагатай байдаг. Хэрэв та ноцтой гэм нүгэл үйлдсэн бол бишоптойгоо уулзах ёстой. Хэрэв энэ нь ноцтой бус бол чимээгүй хийгээд хувийн гэмшил, наманчлал хангалттай. Өршөөлийн агуу өглөө нь нэг дор ирдэггүйг сана. Хэрэв эхний удаад бүдэрсэн бол битгий бууж өгөөрэй. Сэтгэл гутралыг даван туулах нь сорилтын нэг хэсэг юм. Бүү шантар. Би та нарт урьд нь хэлсэнчлэн, хэрэв та гэм нүглээ хүлээж, орхисон бол битгий эргэж хараарай.

## Аврагч бидний гэм нүглийн төлөө зовж шаналсан

Их Эзэн үргэлж бидний дэргэд байдаг. Хэрэв та Түүнийг Гэтэлгэгчээ гэж хүлээн зөвшөөрөх болбол Тэр таны төлөө зовж шаналан, шийтгэлийг нөхөн төлсөн.

Мөнх бус хүмүүний хувьд бид Тэр цагаатгагч золиослолыг *хэрхэн* хийснийг бүрэн дүүрэн ойлгохгүй. Гэхдээ одоохондоо Түүний *хэрхэн* зовж шаналсан нь Түүний *яагаад* зовж шаналсантай адил чухал биш байна. Яагаад Тэр таны төлөө, миний төлөө мөн бүх хүн төрөлхтний төлөө үүнийг хийсэн юм бол? Тэр үүнийг Бурхан Эцэг болон бүх хүн төрөлхтнийг хайрлах хайрын төлөө хийсэн. Нөхдийнхөө төлөө амиа зориулахаас өөр агуу хайр байхгүй” (Иохан 15:13).

Христ Гетсеманид залбирахаар төлөөлөгчдөө орхин явдаг. Гетсеманид юу ч

болсон байлаа гэсэн, энэ нь бидний ойголтоос хэтэрсэн зүйл юм! Гэхдээ бид Түүнийг Цагаатгал хийсэн гэдгийг мэддэг. Тэрээр бүх дэлхийн алдаа, нүгэл, гэм буруу, эргэлзээ, айдсыг Өөр дээрээ авахад бэлэн байсан. Биднийг зовж шаналахгүй байхын тулд Тэрээр бидний өмнөөс зовж шаналсан юм. Маш олон хүн зовлон шаналлыг амсаж, аймшигт үхлээр үхсэн байдаг ч Түүний зовлон шаналаалтай харьцуулшгүй юм.

Би амьдралдаа бие өвдөх гэж юу болохыг амссан бөгөөд энэ нь тийм ч амар зүйл биш! Хэн ч зовлон шаналлыг туулалгүйгээр энэ дэлхийгээс халин оддоггүй. Гэвч миний тэвчиж чаддаггүй ганцхан зовлон бол би хэн нэгний зовох шалтгаан боллоо гэдгээ мэдэх тэр үе байдаг юм. Ийнхүү би Аврагчийн Гетсеманий цэцэрлэгт амссан зовлонгоос өчүүхэн ч гэсэн мэдэрдэг.

Түүний туулсан зовлон шаналаал хүн төрөлхтний зовлон шаналаас өөр юм. Учир нь Тэрээр хүн төрөлхтний бүхий л шийтгэл, үр дагаврыг өөр дээрээ авсан билээ. Төсөөлөөд үз дээ! Түүнд төлөх ёстой өр байгаагүй. Тэрээр ямар ч буруу зүйл үйлдээгүй. Гэсэн хэдий ч Тэр бидний мэдэх бүх гэм нүгэл, гуниг харуусал, өвчин зовлон, ичгүүр, биеийн болон оюун ухааны бүх зовлонг туулсан. Бүх цаг үеийн хүн төрөлхтний түүхэнд бүх хүмүүний нүглийг цагаатгаж, тэдний өвчин зовлонг тэвчих ганц л гэм нүгэлгүй хүн байсан юм.

Тэр Өөрийнхөө амьдралыг золиослоход бэлэн байсан бөгөөд “Дэлхийн нүглийг өөр дээрээ авагч нь би билээ” хэмээн хэлсэн билээ (Мозая 26:23). Тэр цовдлогдож, нас барсан. Тэд Түүний амийг авч чадахгүй байв. Тэр өөрөө үхэхийг сонгосон юм.

### **Бид бүрэн уучлагдах боломжтой**

Хэрэв та унаж, алдагдсан бол, хэрэв та боолчлолд орсноо ухаарсан бол итгэлтэй урагшилж, дэлхийд битгий дахин хэрэн тэнүүчлээрэй. Таныг амар амгалан, аюулгүй газар руу хөтлөх хүмүүс үргэлж байдаг юм шүү. Сударт амласанчлан, Бурханы ач ивээл “хийж чадах бүхнээ” хийсний дараа л ирдэг юм (2 Нифай 25:23). Энэ нь боломжтой гэдгийг мэдэх нь хамгийн үнэ цэнэтэй үнэн билээ.

Өршөөлийн цэлмэг өглөө ирнэ гэдгийг би амлаж байна. Тэгээд “бүх оюун ухаанаас дээгүүрх Бурханы амар тайван” (Филиппой 4:7) таны амьдралд дахин нэг удаа яг л нарны цацраг мэт ирж, Тэрээр “та нарын нүглийг дахин санахгүй” (Иеремиа 31:34). Харин та хэрхэн мэдэж болох вэ? Та мэдэх болно! (Мозая 4:1–3-ыг үзнэ үү.)

Хүнд нөхцөл байдалд байгаа та нарт заахаар ирсэн нь миний зорилго юм. Тэрээр ирж, таны шийдвэрлэж чадахгүй байгаа асуудлыг шийдэх болно. Харин та төлбөрийг нь төлөх ёстой. Та төлбөрийг төлөхгүйгээр энэ нь улиран тохиохгүй. Тэр шаардлагатай бүх төлбөрийг төлдөг үнэхээр эелдэг захирагч юм. Гэвч Тэрээр та нарыг энэ нь бүр хэцүү байсан ч хийх ёстой зүйлсээ хийгээсэй гэж хүсдэг.

Би Их Эзэнд хайртай, мөн Түүнийг илгээсэн Эцэгт хайртай. Бидний гуниг гутрал, нүгэл, гэм буруу Түүний өмнө авчрагдаж, Түүний гайхамшигт нөхцөлийн дагуу бүх өр зээл “бүрэн төлөгдсөн” гэж тэмдэглэгдэх боломжтой.

“Нааш ир, Хамт хэлэлцье гэж Их Эзэн айлдаж байна: Та нарын нүглүүд час улаан мэт боловч цас шиг цагаан болно; Тэдгээр нь хүрэн улаан боловч ноос шиг болох болно.” Исаиа үргэлжлүүлэн “хэрэв та нар зөвшөөрч, дуулгавартай дагавал” (Исаиа 1:18–19) хэмээн хэлсэн.



## Түүнд ирэгтүн

“Насны залууд мэргэн ухаанд суралц; тийм ээ, насны залууд Бурханы зарлигуудыг дагаж сурагтун” (Алма 37:35) гэх судар нь амар амгаланг, мөн дайснаас хамгаалах хүчийг амладаг урилга билээ. “Хэн ч чамайг залуу хүн хэмээн дорд бүү үзэг. Харин чи итгэгч хүмүүст үг, зан байдал, хайр, итгэл хийгээд цэвэр ариун байдлаараа үлгэр дуурайл бол” (1 Тимот 4:12).

Амьдралд чинь бүх зүйл санаснаар чинь болно гэж бүү бодоорой. Бүр хийх ёстой зүйлээ хийж байхад хүртэл амьдрал хэцүү байх үе тохиолдоно. Амьдралын сорилт шалгуур бүртэй өөдрөгөөр, мөн итгэлтэйгээр нүүр тул, тэгвэл та амар амгалан, өнөөдөр болон ирээдүйд таныг дэмжих итгэлтэй байх болно.

Хүсэн хүлээсэн адислалуудаа хараахан авч амжаагүй байгаа, мөн амьдралд нь хоосон орон зай эзэгнэж, хэрэгтэй бүхнээ хүлээж аваагүй хүмүүст хандаж, би итгэлтэй тэдэнд аврал, гэтэлгэлд шаардлагатай бүх туршлага, боломжууд ирэх болно гэж баттай хэлмээр байна. Зөв зохистой хэвээр бай; итгэл найдвартай, тэвчээртэй, залбиралтай бай. Бүх зүйлд гарах арга зам байдаг. Ариун Сүнсний бэлэг таныг удирдаж, үйлдлийг чинь чиглүүлэх болно.

Хэрэв та хийсэн алдааныхаа үр уршгаас болж гэм буруу, гуниг зовлон эсвэл хүлээж авч чадаагүй адислалаасаа болж шаналж байгаа бол “Come unto Jesus” дуулалд гарах зааврыг уншаарай.

*Хүнд дарамт үүрсэн*

*Нүгэлд дарлагдан ядарч, туйлдсан та нар Есүст ирэгтүн*

*Тэр та нарыг хоргодох газар руу аюулгүй удирдана.*

*Түүнд итгэдэг бүхэн амралтыг олох болно.*



*Бидний гуниг  
гутрал, нү-  
гэл, гэм буруу  
Түүний өмнө  
авчрагдаж,  
Түүний гайхам-  
шигт нөхцө-  
лийн дагуу бүх  
өр зээл “бүрэн  
төлөгдсөн” гэж  
тэмдэглэгдэх  
боломжтой.*

*Есүст ирэгтүн, Тэр та нарт анхаарал хандуулна.*

*Та нар төөрөн одож, харанхуйд бэдрэвч  
Түүний хайр та нарыг олж, алгуур  
удирдах болно.*

*Гүн харанхуйгаас өдрийн гэгээ рүү*

*Есүст ирэгтүн, Тэр та нарыг сонсох  
нь лавтай.*

*Хэрэв та нар даруу байж, түүний  
хайрыг гуйх аваас*

*Тэнгэр элчүүд дээр орших гэрэлт  
цамхгаас*

*Та нарын ойр байдгийг та нар мэдэхгүй  
гээж үү?<sup>1</sup>*

Би төлөөлөгч ах нарынхаа хамт Их Эзэн Есүс Христийн онцгой гэрчүүд билээ. Би Түүний ариун нандин золиослолын цэвэршүүлэгч үр нөлөөг бодох бүрд энэхүү гэрчлэл дахин батлагддаг юм. Миний гэрчлэл, мөн миний ах нарын гэрчлэл үнэн юм. Бид Их Эзэнийг мэднэ. Тэрээр Өөрийн бошиглогч, үзмэрч, илчлэгчдэд харь хүн биш.

Та нар төгс биш ч, тэр замаа даган явж байгааг би ойлгож байна. Зоригтой байгаарай. Бие махбодтай ямар ч хүн бие махбодгүй тэдгээрийг давах хүчтэй гэдгийг мэд.<sup>2</sup> Сатан бие махбодоос татгалзсан юм; хэрэв та хэзээ нэгэн цагт уруу таталттай нүүр тулах бол, хэрэв та Адам, Ева хоёрт Едений цэцэрлэгт өгөгдсөн, өнөөг хүртэл үе уламжлан ирсэн сонгох эрхийг ашиглах аваас уруу таталтыг ялах болно.

Хэрэв та найдвараар урагш харж, Их Эзэний хийгээсэй гэж хүсэж байгаа зүйлийг хийх хүсэлтэй байвал танаас хүсэн хүлээж байгаа бүх зүйл тэр билээ. ■

2011 оны 11-р сарын 6-нд Бригам Янгийн Их Сургууль дээр болсон онцгой цугларалтад хэлсэн үг, “Truths Most Worth Knowing”-ээс авав. Англи хэл дээрх бүрэн эхийг үзэх бол [speeches.byu.edu](http://speeches.byu.edu) хаягаар орно уу.

## ЭШЛЭЛҮҮД

1. “Come unto Jesus,” *Hymns*, дугаар 117.

2. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Йосеф Смит* (2007), 211-ийг үзнэ үү.

## ДУРТАЙ ДУУЛЛАА ДУУЛ

**Б**и Ребека охиноо дөнгөж төрүүлээд байв. Төрөлт маань хүнд байсан бөгөөд би маш их ядарсан байлаа.

Ребекаг надад тэврүүлэхэд, миний хамгийн дуртай “Би Бурханы хүүхэд” (*Хүүхдийн дуу*, 58) дууллыг дуулах хэрэгтэй гэсэн хүчтэй мэдрэмж надад төрсөн юм. Би эхлээд “Үгүй ээ, би маш их ядарч байна. Би түүнд дараа дуулж өгч болно шүү дээ” гэж бодов. Гэвч тэр бодол дахин орж ирэв. Тиймээс, би маш их ядарсан байсан ч эхний бадгийг дуулж эхэллээ. Нөхөр, ээж хоёр маань надтай хамт дуулж эхлэв.

Биднийг дуулж дуусахад өрөөн дотор нэгэн онцгой зүйл мэдрэгдэв. Тэр хормыг хүртэл ажлаа хийгээд, ганцаараа цаана зогсож байсан эмчийн нулимс ч бас урссан байв. Тэр ийм гайхалтай дуу дуулж өгсөнд талархал илэрхийлэв. Тэрээр хүүхэд эх барьж авсан энэ олон жилийн хугацаандаа саяын мэдэрсэн шиг ийм

зүйлийг хэзээ ч мэдэрч байгаагүй гэдгээ хэлж билээ.

Би энэ явдлыг бодож байхдаа энэ дууллын бичлэгийг түүнд олж өгч чадах эсэхээ бодож байлаа. Харамсалтай нь би удалгүй завгүй болж, энэ талаар мартсан байв.

Тэгж байтал төрсний дараах үзлэг хийлгэх өдөр болов. Эмчийг өрөөнд орж ирэх үед түүний царай гэрэлтэж байсан бөгөөд тэр намайг тэврэв. Тэр дуут мартаж чадахгүй байгаагаа, бүр гэр бүлийнхэндээ дуулж өгөхөөр интернэтээс хайж үзсэнээ хүртэл надад хэлсэн юм. Ариун Сүнс надад сануулах үед би тэр дууны нэг хувийг түүнд өгөхөөр авах хэрэгтэй байлаа. Би түүнд тэр долоо хоногтоо багтаагаад дуут олж, авчирч өгнө гэж амлав.

Би тэр орой түүнд хамгийн сайн тохирох дууны хувилбарыг олоход

туслахыг гуйн залбирсан юм. Маргааш нь би

тэр дуутай CD-г захиалав. Хэдэн өдрийн дараа шуудангаар CD ирэхэд би түүнд өгөхөөр сэтгэл догдолж байлаа.

Тэр үүнийг хүлээн авахдаа сэтгэл нь хөдөлж, бэлэг авч байгаадаа надад талархсан юм. Тэр яагаад гэдгээ мэдэхгүй байсан ч, энэ дуут гэр бүлийнхэнтэйгээ хуваалцах нь түүний хувьд маш чухал гэдгийг надад хэлэв. Бид үргэлжлүүлэн ярилцаж байхдаа би энэ дуунд хайртайгаа түүнд хэлээд зогсохгүй, бас энэ дуун дээр гардаг энгийн үнэнүүдийн талаарх гэрчлэлээ хуваалцсан юм.

Тэр өдөр би машинаараа гэр рүүгээ явж байхдаа Тэнгэрлэг Эцэгийн охидын нэг болох эмчийг маань хайрлах Түүний хайрыг мэдэрсэн. Тэр түүнийг мэддэг бөгөөд хайрладаг. Тэр түүнийг Өөртэй нь хамт амьдрахаар эргэн ирж чадна гэдгээ мэдээсэй гэж хүсдэг. ■

Анжэла Олсэн Сэнтэр, АНУ, Охайо

**Т**эр хормыг хүртэл ажлаа хийгээд, ганцаараа цаана зогсож байсан эмчийн нулимс ч бас урссан байв.





Тэнгэрлэг Эцэг  
яагаад биднийг  
“үргэлж” харж хан-  
дан, бас сэрэмж-  
лүүлдэггүй юм бол?



## ТҮҮНИЙ ҮРГЭЛЖ ХЭМЭЭХ АМЛАЛТ

Ариун ёслолын цуглаан дээр талхны залбирлыг тунгаан бодож суух үед “Ариун Сүнс тэдэнтэй үргэлж хамт байж болохын тулд” (Моронай 4:3; С ба Г 20:77) гэсэн хэсэг нь оюун санаанд минь дахин дахин сонсогдоно.

Тодорхой цагуудад биш, харин “үргэлж” хэмээн бодолд минь хэлж байв. Тэгвэл яагаад хэдэн сарын өмнө дугуй авто машинтай осолдож, 11 настай хүүгээ алдахаас өмнө түүнийг хэрхэн хамгаалах талаар нөхөр бид хоёр илчлэлт аваагүй юм бол? Тэнгэрлэг Эцэг яагаад биднийг “үргэлж” харж хандан, бас сэрэмжлүүлдэггүй юм бол?

Би Хүүхдийн хэсэгт байхаасаа л Ариун Сүнс биднийг хамгаалах болно гэж заалгаж, үүнд итгэдэг байсан. Тэр биднийг анхаарч, удирдаж, аюулаас сэрэмжлүүлэхдээ зөөлөн, намуун дуу хоолойгоо ашиглаж болох байсан шүү дээ. Бэнийг нас барснаас хойш энэ бодол миний оюун санаанд эргэлдсээр байв. Би түүнийг маш их санаж байсан бөгөөд үүнийг ойлгож, амар амгаланг

олж авахын тулд зүрх сэтгэл минь шаналж байлаа.

Надад сэрэмжлүүлэх дуу хоолой хаана байсан юм бэ? Ариун Сүнс хаана байсан юм бэ? Бид зөв зохистой байхын тулд хамгийн сайнаараа хичээж байсан гэж бодож байв. Бид аравны нэгээ төлж, цуглаанууддаа оролцож, дуудагдах бүрдээ үйлчилдэг байсан. Бид төгс болох өдий байсан ч гэр бүлийн үдшээ хийж, судраас уншдаг байсан. Бид хичээдэг байлаа.

Намайг нэг удаа Халамжийн Нийгэмлэгийн хичээлд сууж байх үед багш ойрын хамаатныхаа талаар нэг түүх ярих. Хамаатных нь хүн улаан гэрэл дээр зогсоод, хүлээж байхад нь ногоон гэрэл астал байгаа газраа зогсож бай гэсэн хүчтэй мэдрэмж мэдэрчээ. Тэрээр сүнслэг өдөөлтийг анхаарсан бөгөөд бараг тэр даруй том ачааны машин улаан гэрлээр уулзварыг маш хурдан дайрч өнгөрөв. Хэрэв тэр эмэгтэй тэр дуу хоолойг сонсож, дуулгавартай дагаагүй байсан бол тэр хүүхдүүдтэйгээ хамт гэмтэж, бүр үхэж ч болох байж.

Энэ түүх надад маш хүчтэй

нөлөөлсөн юм. Босож, ангиас гарахаар бэлдэн, сандал дээрээ уйлан суух үед агуу их тайвшрал намайг нөмрөн авав. Үнэндээ Ариун Сүнс надтай үргэлж хамт байсныг би ойлгож, амар амгаланг мэдэрсэн юм. Миний энэ нөхцөл байдалд Тэрээр сэрэмжлүүлгийн дуу хоолой биш, харин тайтгаруулагчийн үүрэг гүйцэтгэсэн.

Бэнийн ослоос хойш, би өөрөөсөө давсан хүч чадлыг мэдэрсэн бөгөөд Тэнгэрлэг Эцгийн хайраар тайвширсан юм. Тодорхой зүйлүүд болдог учир шалтгааныг ойлгоход ойлголт маань дутдаг ч, би түүний хайранд хэзээ ч эргэлзэж байгаагүй билээ.

Бурхан бүх зүйлийг ойлгодог бөгөөд Тэр хэзээ ч намайг тайтгаруулалгүйгээр орхихгүй гэдгийг би мэднэ. Ариун Сүнс миний амьдралд маш олон үүрэг гүйцэтгэдэг. Тэр биднийг хамгаалж, удирдан, тайтгаруулж, бидэнд зааж, биднийг ойлголт болон бусад адислалаар хангаж чадна.

Тэнгэрлэг Эцэг амлалтуудаа биелүүлдэг гэдгийг би мэдэж авсан. Тэр “үргэлж” надтай хамт байсан. ■  
Робэн Каспер, АНУ, Юта



Дэлгүүрийн машины зогсоол руу уйлаад гүйж өнгөрөх тав, долоо орчим насны хоёр хүүг ажиглахаар би эргэж харав.

## СҮНС НАДАД ШИВНЭСЭН

“Хүүе, хөвгүүд ээ! Буцаад ир!”  
Гэх нэг сандарсан дуу хоолой сонсогдов.

Дэлгүүрийн машины зогсоол руу уйлаад гүйж өнгөрөх тав, долоо орчим насны хоёр хүүг ажиглахаар би эргэж харлаа. Худалдагч тэднийг дуудаж байхдаа санаа нь зовсон харагдаж байсан юм.

Намайг машин руугаа эргэтэл “Энд чиний тусламж хэрэгтэй байна” гэж Сүнс шивнэв. Шивнээ намуухан байсан ч маш тодорхой байсан учир би тэр даруй хөвгүүд дээр очихоор зогсоол руу гүйлээ.

Том нь бор өнгөтэй жижиг бүхээгт тэрэгний хажууд зогсож байгааг би харав. Би түүнд дөхөж очоод өвдөглөн,

“Сайн уу? Намайг Кристина гэдэг. Чи зүгээр үү?” гэлээ.

Намайг үг хэлэхэд тэр улам чанга уйлж, шуугаараа нүүрээ нууж байв. Худалдагч, дүүтэй нь хамт бидэн дээр ирэв.

“Тэд францаар л ярьдаг юм шиг байна” гэж худалдагч надад хэллээ. “Бид тэднийг төөрөөд, дэлгүүр дотор

гүйж байхад нь сая л олж харсан юм.”

Би хүүхдүүдэд өөрийгөө францаар дахин танилцуулав. Хэдийгээр франц хэл миний төрөлх хэл ч гэсэн бага байхдаа англиар ярьдаг гэр бүлд үрчлүүлснээс хойш францаар огт яриагүй байв. Ерөнхийдөө миний франц хэл муу байлаа. Гэсэн хэдий ч тэр мөчид би маш чөлөөтэй ярьж байв. Хөвгүүдийг тайвшруулах үед үгс оюун санаанд маань маш тодхон орж ирэн, хэлэхэд ч тодорхой байлаа.

Том хүү уйлж байхдаа дүүтэйгээ хамт дэлгүүрийн хаанаас ч аав, ээжийгээ олж чадахгүй байгаагаа, бас тэднийг хайж гадуур гүйснээ хурдан гэгч тайлбарлаж хэлэв. Сонсож байхдаа би францаар чөлөөтэй яриад зогсохгүй, айсан хоёр хөвгүүнийг ч бас амархан ойлгож, тайвшруулж байгаа нь хэчнээн гайхалтай зүйл болохыг бүдэг бадаг мэдсэн юм.

“Тэднийг эцэг эхээсээ төөрснийг, мөн машиндаа тэднийг хүлээхийг хүсэж байгааг” би худалдагчид хэлэв. Бага дүү нь эцэг эхийнхээ нэрийг хэлэхэд, би тэднийг хайлгахаар

худалдагчид өглөө. Хэдхэн минутын дараа хүү дэлгүүрээс гарч ирж байгаа аавыгаа олж харан, түүнтэй уулзахаар гүйв.

Би түүнийг аав руу нь дагаж явахдаа францаар баяртай ч гэж хэлж чадахаа больсноо мэдэж билээ. Би хөвгүүдийн ойлгож чадах зүйлсийг хэлэхээр хичээсэн ч хэдэн үгнээс өөр юут ч олигтой хэлж чадахгүй байв. Эцэст нь би нэг хүүд нь баяртай, уулзахад сайхан байлаа гэж англиар хэлэв.

Би хөвгүүдийг эцэг эхтэй нь хамт орхихдоо талархлаар дүүрэн байсан юм. Тэнгэрлэг Эцэг бяцхан хоёр хүүхдээ тайвшруулахын тулд надаар дамжуулан ажилласан байв. Их Эзэн зорилгуудаа гүйцэлдүүлэхийн тулд миний хязгаарлагдмал чадварыг хүчирхэгжүүлж чадсанд би дарууссан билээ. Дуудагдсан үедээ, бараг боломжгүй санагдах нөхцөлд ч Түүнд өөрсдийгөө зориулах үед тохиолдож болох зүйлийг гэрчлэхдээ би баяртай байсан юм. ■

Кристина Албрэхт Эрхарт, АНУ, Вашингтон



# БИД ОДОО Л АРИУН СҮМ РҮҮ ЯВАХ ЁСТОЙ!

Нэгэн ням гаргийн өглөө баптисм хүртсэн шинэ гишүүнийг тойргийнхонд танилцуулав. Түүний нэрийг Лидиа гэдэг байв. Тэр шууд л бидний хайрыг татсан юм.

Лидиа нас өндөр болсон бөгөөд чихрийн шижинтэй олон жил тэмцсэний эцэст хараагүй болжээ. Тэр тойргийн гишүүдийг дуу хоолой ба хөлийн чимээгээр нь маш хурдан таньдаг болов. Тэр бидний нэрийг хэлж, бидэнтэй гар барьдаг байсан бөгөөд бид түүнийг сохор гэж боддоггүй байлаа.

Шаардлагатай нэг жилээ хүлээсний эцэст Лидиа ариун сүмийн эрхийн бичиг авахаар бишоптой болон гадасны ерөнхийлөгчтэй уулзав. Нэг ням гаргийн өдөр Халамжийн Нийгэмлэгийн ангид би түүний хажууд сууж байв. Тэр намайг татаад, “гадасны ерөнхийлөгч намайг аль болох хурдан ариун сүм рүү явах хэрэгтэй гэсэн. Чи намайг авч явах уу?” гэв.

Арванхоёрдугаар сарын эхний долоо хоног байсан бөгөөд бид бүгд завгүй байлаа. Би шалтаг

гаргахыг хичээн, “нэг сар хүртэл хүлээж болохгүй юу?” гэж хэлэв.

“Үгүй ээ, бид одоо л явах ёстой!”

Тойргоос эгч нарын групп сар бүр ариун сүм рүү явдаг байсан учраас би Лидиатай хамт аялал хийхийг тэднээс гуйв. Тэд ч бас завгүй байлаа. Гэвч Лидиа нүдэндээ нулимстайгаар, гадасны ерөнхийлөгч намайг аль болох хурдан яваарай гэж хэлсэн гэж бидэнд дахин хэлэв.

Тэгэхэд бид бүгдээрээ 241 км-ийн аяллыг дараагийн долоо хоногт хийхээр зөвшөөрсөн юм. Найман эгч бүхээгт машиндаа нөхөрлөн, хөгжидсөөр замдаа гарав. Лидиа ариун сүмд очиж, хувийн хишгээ хүлээн авснаар ирсэн адислалдаа хөл нь газар хүрэхгүй баяртай байсан билээ.

Нэгдүгээр сарын эхний долоо

хоногт Лидиагийн биеийн байдал муудаж, эмнэлэгт яаралтай хэвтэв. Долоо хоногийн дараа тэр нас барсан. Лидиа хэдхэн долоо хоногийн өмнө ариун сүмд хүлээн авсан мөнхийн адислалуудтайгаа хамт явсан юм.

Дараа нь би гадасны ерөнхийлөгчид аяллын талаарх түүхийг дурдаж, Лидиад ариун сүм рүү даруйхан явах ёстой гэж хэлэх сүнслэг өдөөлт мэдэрсэнд нь хэчнээн их талархалтай байгаагаа түүнд хэлж билээ.

“Би түүнийг яг одоо яв гэсэн утгаар хэлээгүй” хэмээн тэр хариулав. “Би шинээр ариун сүмийн эрхийн бичгээ авч байгаа хүн бүрд удахгүй ариун сүм рүү яваарай гэж хэлдэг. Би биш, харин Сүнс Лидиад хэлсэн байна!” хэмээн тэр хариулсан юм.

Лидиа бид бүгдэд Сүнсийг сонсохыг, мөн үүний дагуу даруй үйлдэх хэрэгтэйг заасан. Намуухан, зөө-

лөн дуу хоолойг сонсохыг сануулсан түүнд би талархалтай байдаг. ■

Мари Холмэс Эвэн,  
АНУ, Калифорни

“Гадасны ерөнхийлөгч намайг ариун сүм рүү аль болох хурдан явах хэрэгтэй гэж хэлсэн. “Чи намайг авч явах уу” гэж Лидиа хэлэв.





Далын  
ахлагч  
Антони Д.Перкинс

# Итгэлтэй УРАГШИЛ

Залуучууд та нар одоо “Шийдвэр гаргах эрин” хэмээн нэрлэгддэг тийм нийгэмд амьдарч байна. Та нар “ариун сүм явах, номлолд үйлчлэх, боловсролтой болох, мэргэжлээ сонгох, ханиа сонгох, энэ амьдрал болон үүрд мөнхөд ариун сүмд холбогдох гэх мэт” амьдралынхаа хамгийн чухал олон сонголтыг хийж байна.<sup>1</sup>

Би эдгээр чухал шийдвэрийн аль нэгтэй, эсвэл түүнээс ч олон шийдвэр гаргахаар тэмцэж буй хүмүүст хандан яримаар байна. Зарим нь буруу шийдвэр гаргасан айдсаасаа болж, эсвэл өмнө нь гаргасан шийдвэртээ итгэлтэй үлдэхэд нэмэлт хүч хэрэгтэй байгаагаасаа болж ямар ч сонголт хийж чадахгүй байж болох юм.

Нифайн гаргасан дөрвөн сүнс-лэг шийдвэрийг хэрэгжүүлбэл энэ нь та нарын айдсыг багасгаж, урагшлах итгэлийг тань нэмэгдүүлэх болно.

## 1. Зарлигуудыг дуулгавартай дага

Нифайн ариун цэдгийн хамгийн сүүлийн шүлэг нь түүний амьдралыг товчоор илэрхийлдэг: “Учир нь Их Эзэн надад тийн зарлигласан, мөн би дагах ёстой” (2 Нифай 33:15).

Нифайн итгэл ба Аврагчийг хайрлах хайр нь түүний Бурханы зарлигуудад дуулгавартай байснаар харагддаг. Тэр залбирдаг байв (1 Нифай 2:16-г үзнэ үү). Тэр судруудыг уншдаг байсан (1 Нифай 22:1-ийг үзнэ үү). Тэр амьд бошиглогчийн удирдамжийг эрэлхийлж, дагасан юм. (1 Нифай 16:23–24-ийг үзнэ үү). Энэ дуулгавартай байдал нь Ариун Сүнс Нифайг амьдралынх нь турш хүчирхгээр дагаж, хувийн илчлэлтүүд авах боломжийг олгосон.

Та нар бас Бурханы зарлигуудыг дагаснаар Их Эзэнтэй ойр байх ёстой. Судар унших, өдөр бүр залбирах, Сүмийн цуглаануудад оролцох, амьд бошиглогчдын зөвлөгөөнд анхаарал хандуулах,

**Нифайн гаргасан дөрвөн сүнс-лэг шийдвэр та нарын айдсыг багасгаж, урагшлах итгэлийг тань нэмэгдүүлэх болно.**

мөн бусдад үйлчлэх гэх мэт жижиг зүйлүүдэд тууштай, дуулгавартай байснаар энэ нь та нарыг Ариун Сүнсийг болон үүнээс ирдэг энэ илчлэлтүүдийг хүлээн авахуйц зохистой болгох болно гэдгийг би гэрчилж байна.





Нифайн итгэл болон  
Аврагчийг хайрлах  
хайр нь түүнийг  
Бурханы зарлигуу-  
дад дуулгавартай  
байсныг харуулдаг.



Төгс байдал нь хувийн илчлэлт авах урьдчилсан нөхцөл биш юм. Өдөр бүр наманчлах нь урьдчилсан нөхцөл болдог (Ром 3:23-ыг үзнэ үү). Хэрэв та нарын наманчлал чин сэтгэлийнх бөгөөд жинхнээсээ байвал (С ба Г 58:42–43-ыг үзнэ үү) Цагаатгалын цэвэршүүлэгч хүч нь амьдралын хүнд шийдвэрүүд гаргахад та нарыг удирдах тэрхүү Сүнснийг авчрах болно.

## 2. Итгэлтэй урагшил

Өөрийгөө Нифайн оронд байгаагаар төсөөл. Аав чинь Их Эзэн эд хөрөнгөө орхиж, аглаг буйд руу явахыг гэр бүлд чинь зарлигласан хэмээн чамд хэлэв. Чи аяллынхаа талаар болон хүрэх газраа мэдмээргүй байна гэж үү?

Хэрэв Их Эзэн түүний ирээдүйг тодорхой илчилсэн бол Нифай маш их догдох байсан гэж би бодож байна. Гэвч энэ нь Бурханы Нифайтай ажилласан арга зам байсангүй. Бас Тэр та нартай ийм арга замаар ажиллахгүй.

Нифайн гэр бүлийг аглаг буйдаа аялах үед зааврууд түүнд зөвхөн “цагаас цагт” (1 Нифай 16:29; 18:1) ирж байв. Амьдралынхаа аяллыг эхлээд тодорхой мэдэх нь Христтэй илүү адил болоход түүнд тусалж,

түүнийг хүчирхэгжүүлж, итгэлийг нь бий болгосон тэрхүү туршлагуудыг түүнд олгохгүй байх байсан.

Хэрэв та нар ямар мэргэжлээр сурах, хэнтэй гэрлэх, ямар ажил хийх, хаана амьдрах, сургуулиа хаана төгсөхийг болон хэдэн хүүхэдтэй болохыг тань Бурхан илчилнэ гэж хүлээж байгаа бол та нар бараг хэзээ ч тохилог сууцаа орхихгүй. Хувийн илчлэлт зөвхөн “цагаас цагт” ирэх болно гэдгийг би гэрчилж байна.

Тэнгэрлэг Эцэг маань биднээс өсөж хөгжихийг хүсдэг бөгөөд энэ нь нөхцөл байдлыг үнэлж, дүгнэн, шийдвэр гаргахыг хэлдэг. Гэвч Тэр бас биднийг залбирч, шийдвэрүүдээ гаргахад урьдаг (С ба Г 9:7–9-ийг үзнэ үү). Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скотт залбирлын хариултууд нь “*гурван* арга замын нэгээр нь” ирдэг гэж заажээ.<sup>2</sup>

### Баттай нотолгоо

Ахлагч Скотт хэлэхдээ, “Нэгдүгээрт, таны шийдвэр зөв гэдгийг баталсан амар амгалан, тайтгарал болон баталгааг та мэдэрч болно”<sup>3</sup> гэжээ. Миний эхнэр, Кристи бид хоёр амьдралд нөлөөлөх чухал шийдвэрүүдэд зориулсан баталгаа нь ариун сүмд залбирсны дараа судруудаар дамжин ирж болдгийг олж мэдсэн юм.

Жишээ нь, бид маш их тунгаан бодож, залбирсны дараа Техас дахь мөрөөдлийн шинэ байшингаа орхиж, өөр ажлын санал хүлээн аваад, зургаан хүүхэдтэйгээ Хятадын Бээжин рүү нүүхээр шийдэв. Гэвч бид нүүх ийм чухал шийдвэртээ сүнслэг баталгаа хүссэн юм. Биднийг ариун сүмд Сургаал ба Гэрээн дээрх эдгээр үгийг унших үед дараах тэнгэрлэг баталгаа ирсэн билээ: “. . . Энэ газарт олон өдрөөр бүү үлд; . . . өмч

## АЙДСАА БАГАСГАЖ, ИТГЭЛЭЭ НЭМЭГДҮҮЛЭ- ХИЙН ТУЛД

1. Зарлигуудыг дуулгавартай дага.
2. Итгэлтэй урагшил.
3. Одоо цагтаа амьдар.
4. Бусдын хүч чадалд найд.







**Хэрэв Их Эзэн түүний ирээдүйг тодорхой илчилсэн бол Нифай маш их догдлох байсан. Гэвч энэ нь Бурханы Нифайтай ажилласан арга зам байсангүй. Бас Тэр та нартай ийм арга замаар ажиллахгүй.**

“Мөн би хийвэл зохих зүйлүүдийг урьдаас мэдэхгүй байсны учир бибээр Сүнсэнд хөтлөгдөн байлаа.

“Тэсэн хэдий ч би урагшлан явсан” (1 Нифай 4:6–7).

Та нар дахин нэгээхэн ч удаа хойшлуулж болохгүй, үйлдэх ёстой үед олон шийдвэр гаргах мөчүүд ирэх болно. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс “Бид хийх зүйлдээ удирдамж хүсэн, сүүдэрт залбирч сууснаас илүүтэй гадаа гарч, үйлдэл хийх юм бол, мөн бид чадах бүхнээ хийсэн үед Сүнсний өдөөлтүүдийг олж авах болно”<sup>6</sup> хэмээн заасан юм.

Нифайн адил, Сүнс та нарын сонгосон замыг баталж, эсвэл сэрэмжлүүлэх болно.

### 3. Одоо цагтаа амьдар

Амлагдсан нутаг руу аялах Нифайн амлалт нь ах Лемен, Лемүел нарынх нь эсрэг байв. Тэд явах шийдвэр гаргасан ч зүрх сэтгэл нь хэзээ ч Иерусалимыг орхиогүй юм. Ах нар нь майханд амарч байгаа мэт байхад, Нифай хоолоо олохын тулд эвдэрсэн нумаа засаж, завь барихын тулд хүдэр олборлож байв.

Өнөө үед дэлхий дээр олон Лемен, Лемүел байна. Гэвч Их Эзэнд Нифай шиг бүхнээ зориулсан эрэгтэй, эмэгтэйчүүд хэрэгтэй байна. Та нар ирээдүйнхээ төлөвлөгөөг гаргасан хэдий ч одоогийнхоо нөхцөл байдлуудад гаргасан шийдвэрүүддээ өөрсдийгөө бүрэн зориулж, тэдгээрийг даван туулахаар хичээх үед агуу ихээр өсөж хөгжих болно.

Нифайн үлгэр жишээ ерөнхийлөгч Томас С.Монсоны ухаалаг зөвлөгөөг харуулсан юм. “Өнгөрснөө санагалзаж, ирээдүйдээ тэмүүлэх нь тайвшрал өгч болох ч одоогийн

хөрөнгөнийхөө талаар бүү бод . . . энэ нь миний таалал юм.” Дорнод нутгууд уруу явагтун” (С ба Г 66:5–7).

Ариун Сүнсний хүчирхэг мэдрэмжүүдийн хамт судрууд дээрх Есүс Христийн дуу хоолой нь бидний Хятад руу явах шийдвэр зөв байсныг батлав.

#### Тогтворгүй мэдрэмж

Тэнгэрлэг Эцгийн залбирлуудад хариулдаг хоёр дахь арга зам нь “чиний сонголт буруу гэдгийг илтгэх тогтворгүй мэдрэмж, дүйнгэ бодол санаагаар дамжин ирж болно.”<sup>4</sup>

Би Тайваньд номлолд үйлчилснийхээ дараа олон улсын хуулиар сурвал ажил олоход сайн сонголт болох байх гэж бодож байв. Кристи, бид хоёр ирээдүйнхээ талаар бодож байхдаа ирэх таван жил гаруйн хугацаанд өндөр төлбөртэй боловсрол эзэмших болно гэдгээ ойлгосон юм.

Нэгдсэн Улсын эдийн засаг гүн хямралд орсон байсан бөгөөд бидний санхүүгийн байдал сайнгүй байв. Тиймээс бид Агаарын Хүчний НОБК (Нөөцийн офицер бэлтгэх коллеж)-д орох нь сургуулийнхаа төлбөрийг төлөх ухаалаг сонголт гэж үзэж байлаа. Гэвч намайг шаардлагатай шалгалтуудыг өгч, бичиг баримтуудаа бүрдүүлж байх үед

бид тэр шийдвэрийнхээ талаар амар амгаланг мэдэрч чадахгүй байв. Дүйнгэ бодол болон харанхуй мэдрэмжүүд төрөөгүй ч амар амгалан мэдрэгдээгүй юм.

Зарим талаараа би аймшигтай хуульч болж болох байсан учраас огт авцалдаагүй санхүүгийн шийдвэр сүнслэгээр ирсэн байх гэж санагддаг.

#### Тэнгэрлэг итгэл

Бурханы бидний залбиралд хариулдаг гурав дахь арга зам нь: хариулт ирэхгүй байх явдал юм. “Та нар зохистой амьдарч, сонголт тань Аврагчийн сургаалуудтай нийцэж байвал үүнийг хийх хэрэгтэй бөгөөд итгэлтэй урагшил”<sup>5</sup> гэж ахлагч Скотт заасан.

Гуулин ялтсуудыг олж авах Нифайн сүүлчийн оролдлого нь биднийг тэнгэрлэг итгэлээр хэрхэн урагшилж болохыг харуулдаг. Тэрээр бичихдээ:

амьдралыг урагшлуулахгүй. Энэ нь бидэнд боломж олгож буй өдөр юм. Тиймээс бид үүнийг шүүрч авах ёстой.”<sup>7</sup>

#### 4. Бусдын хүч чадалд найд

Бид Сүнснийг эрэлхийлэн, шийдвэртэй урагшилж, үүндээ бүхнээ зориулсан ч эргэлзэж болох бөгөөд биднийг шийдвэртээ эргэлзэхэд ч хүргэж болох юм. Ийм үед итгэл хүлээсэн гэр бүлийн гишүүн эсвэл найзууд маань биднийг зам дээрээ үлдэх зөвлөгөө, хүч чадлаар хангаж чадна. Нифайг аялах үед эхнэр нь түүний итгэлийг хүлээсэн хүн байсныг би сануулмаар байна.

Намайг Сүмийн түүхийн музейд



**Итгэл хүлээсэн гэр бүлийн гишүүн эсвэл найзууд маань биднийг зам дээрээ үлдэх зөвлөгөө ба хүч чадлаар хангаж чадна.**



айлчилж байх үеэр Нифайн эхнэрт талархах сэтгэл надад төрж билээ. Хөлөг онгоцны шурагтай хүлэгдэж, хүчит шуурганд арьс нь норсон Нифайн зургийг хараад би биширсэн.<sup>8</sup>

Нифайн хажууд түүний эхнэр болон хүүхдүүдийнх нь нэг байв. Эхнэр нь Нифайн адил тэр шуурга, сорилтуудыг даван туулж байсан ч үл тоон, хүчит гараараа түүний мөрийг хамгаалан тэвэрч байв. Тэр мөчид би ч бас сорилт бэрхшээлтэй үед хүч чадал өгдөг үнэнч эхнэрээр адислагдсанаа ухаарч билээ. Би бас эхнэрийнхээ хувьд үүнтэй адилхан хүч болдог гэдэгтээ найдаж байлаа.

Ах нар аа, номлогч байхдаа юм уу өөр зөв шударга үйлчлэлээр дамжуулан олж авсан (эсвэл олж авах) сүнслэг хүч чадлаа хадгалан, хөгжүүлэх нь сайн нөхөр, аав болоход тань туслах хамгийн сайн хөрөнгө оруулалт юм. Эгч нар аа, сүнслэг мэдрэмж, итгэл, Есүс Христийг дагах

зориг нь эхнэр болон эх хүний танд байх хамгийн сайн зан чанарууд юм.

Би та бүхнийг одоо эсвэл ирээдүйд ухаалаг зөвлөгөө болон хүч чадалд тань найдаж болох тийм эхнэрүүд эсвэл нөхрүүд болоход урьж байна. Ариун сүмд энэ амьдралд болон үүрд мөнхөд холбогдсон ариун журамт эрэгтэй ба зөв зохистой эмэгтэй нь адил тэгш үүрэг хариуцлагатайгаар хүнд хэцүү зүйлүүдийг хийж чадна.

Хэрэв та нар шийдвэр гаргах талаар Нифайгаас болон өнөө үеийн бошиглогчдоос сурсан зүйлүүдээ хэрэгжүүлэх юм бол та нар “цагаас цагт” хувийн илчлэлтүүдээр удирдагдах болно гэдгийг би амлаж байна. Та нар олон шийдвэрээрээ дамжуулан өсөж хөгжих үед Нифайн адил ийн хэлэх итгэлтэй байх болтугай:

“Мөн би хийвэл зохих зүйлүүдийг урьдаас мэдэхгүй байсны учир бибээр Сүнсэнд хөтлөгдөн байлаа.

“Тэсэн хэдий ч би урагшлан явав” (1 Нифай 4:6–7). ■

2014 оны 2-р сарын 4-нд Бригам Янгийн Их сургуулийн онцгой цугларалт дээр хэлсэн “Тэсэн хэдий ч би урагш явсан” хэмээх үгээс. Англи хэл дээрх бүрэн эхийг үзэх бол [speeches.byu.edu](http://speeches.byu.edu) хаягаар орж үзнэ үү.

#### ЭШЛЭЛҮҮД

1. Робэрт Д.Хэйлс “To the Aaronic Priesthood: Preparing for the Decade of Decision,” *Лиахона*, 2007 оны 5 сар, 48.
2. Ричард Г.Скотт, “Using the Supernal Gift of Prayer,” *Лиахона*, 2007 оны 5-р сар, 10; тодруулга эх хувь дээр байгаа.
3. Ричард Г.Скотт, “Using the Supernal Gift of Prayer,” *Лиахона*, 2007 оны 5-р сар, 10.
4. Ричард Г.Скотт, “Using the Supernal Gift of Prayer,” *Лиахона*, 2007 оны 5-р сар, 10.
5. Ричард Г.Скотт, “Using the Supernal Gift of Prayer,” *Лиахона*, 2007 оны 5-р сар, 10.
6. Даллин Х.Өүкс, “In His Own Time, in His Own Way” *Лиахона*, 2013 оны 8-р сар, 26.
7. Томас С.Монсон, “In Search of Treasure,” *Лиахона*, 2003 оны 5-р сар, 20.
8. *Helpmeet*, К.Сийн Сулливан, “The Book of Mormon: A Worldwide View,” *Лиахона*, 2000 оны 12-р сар, 37.



# ТҮҮНИЙГ ЭРЭЛХИЙЛ

“Та нар юунд үхэгсдийн дунд амьд Нэгнийг хайна вэ?  
Тэр энд байхгүй, харин Тэр амилсан.”

(Лук 24:5-6)



# ИОСЕФИЙН АЧААР

*Бошиглогч Иосеф Смитийн ачаар таны  
амьдрал өөр байгаа (эсвэл өөр байж болох)  
6 арга замыг олж тогдорхойл.*

## Тэд Барнэс

Санваарын алба

**И**осеф Смит 170 гаруй жилийн өмнө нас барсан. Тэрээр, магадгүй та нар олж ч чадахааргүй, хамгийн нарийвчлалтай газрын зураг дээрээс л олох боломжтой тийм үл анзаарагдам газруудад амьдралынхаа ихэнх хэсгийг өнгөрөөн, ердөө 38 жил амьдарсан юм. Харин та нар түүний амьдралдаа хийсэн олон зүйлийг аль хэдийн мэддэг болсон байх. Гэвч тэдгээр нь таны хувийн амьдралд хэрхэн нөлөөлдөг талаар та бодож байсан уу? Эдгээр арга зам нь тоо томшгүй олон учраас энэ зургаан зүйлээр та эхэлж болох юм.

Иосеф Смитийн ачаар:

# 1.


**Та Бурхан болон Есүс Христ гэж үнэхээр хэн болохыг мэддэг болсон.**

Иосеф Смит байхгүй байлаа ч та Бурхан Эцэгт болон Есүс Христэд итгэх итгэлтэй байж болох байсан. Та Библийн талаарх гэрчлэлүүдтэй байж болох байсан. Гэвч Иосеф Смитийн сэргээсэн зүйлүүд—Мормоны Ном, Сургаал ба Гэрээ болон Агуу Үнэт Сувдын зоригтой, баттай гэрчүүдийн ачаар таны ойлголт хэчнээн гүн, баялаг байгаа талаар бодож үзээрэй. Жишээ нь, Тэр Израилийн Бурхан төдийгүй [бас] бүх дэлхийн Бурхан (3 Нифай 11:14-ийг үзнэ үү) гэсэн Өөрийн үгийг баталж, амилсан Аврагч Америкт үзэгдсэнийг дэлхий гэрчилдэггүйг та нар мэднэ.

“Тэр амьд бөлгөө! Учир нь бид түүнийг бүр Бурханы баруун гар талд харсан билээ” хэмээн тунхагласан Иосеф Смитээс гадна Нифай, Алма, Моронай гэх мэт бошиглогчдын хүчирхэг гэрчлэлээр дамжуулан Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христийн талаарх гэрчлэл тань хэрхэн хүчирхэгжсэн талаар бодож үз. (С ба Г 76:22–23). Бурханд болон Есүс Христэд итгэх итгэл маань соригдож мөн үгүйсгэгдэж байгаа өнөө үед энэ нэмэлт гэрлийг хүлээн авах нь хэчнээн их адислал билээ!







### 3. Гэр бүл тань мөнхөд байж чадна.

Яагаад ийм олон хүн гэрлэлт ба гэр бүлийн ач холбогдлын талаар будилж байна вэ? Тэд гэрлэлт болон гэр бүл нь Бурханаас томилогдсон бөгөөд мөнхөд байх болно хэмээх Иосеф Смитээр сэргээгдсэн сургаалыг мэдэхгүй байж болох юм (С ба Г 49:15; 132:7-г үзнэ үү). Эдгээр нь зөвхөн нийгэмд хэрэггүй болсон, мөн хүмүүсийн бий болгосон уламжлалууд биш, тэнгэрийн мөнхийн дэг жаягийн нэг хэсэг юм. Иосеф Смитээр сэргээгдсэн санваарын түлхүүрүүдээр болон ариун сүмийн ёслолуудын ачаар та нарын мөнхийн гэр бүл энэ дэлхий дээр бий болж чадна.



### 2. Та нар болон хүн бүр Бурханы хүүхэд гэдгийг та мэднэ.

Иосеф Смитийн сэргээсэн хамгийн чухал үнэн нь бидний Бурхантай харилцах харилцааны талаарх үнэн байж болох юм.<sup>1</sup> Тэр үнэхээр бидний Эцэг. Та өмнө нь энэ баримтаас урган гарах зүйлүүдийн талаар бодохгүй байж үзсэн үү? Энэ нь таны өөрийгөө харах арга замыг өөрчилдөг. Дэлхий таны талаар юу гэж бодож байгаагаас үл хамааран та Бурханы шинж чанарыг өвлөн авсан Бурханы хайртай хүүхэд гэдгээ мэддэг. Энэ нь таны бусдыг харах арга замыг өөрчилдөг: гэнэт л хүн бүр—*хүн болгон*—таны ах, эгч болдог. Энэ нь таны амьдралыг үзэх үзлийг өөрчилдөг: Амьдралын бүхий л баяр баясгалан болон сорилт бэрхшээлүүд нь Тэнгэрлэг Эцэгтэйгээ адилхан болоход танд туслах Түүний төлөвлөгөөнүүдийн нэг хэсэг байдаг. Хүүхдийн хэсэгт дуулдаг зүйл гэхэд л муугүй байгаа биз!<sup>2</sup>

### 4. Та санваар болон санваарын адислалуудыг хүлээн авах боломжтой.

Бурхан Өөрийн санваарыг Иосеф Смитээр дамжуулан сэргээсэн учраас та баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах боломжтой. Та санваарын эдгээх, тайтгаруулах болон удирдамжийн адислалуудыг эрэлхийлж чадна. Таныг Бурхантай холбох ариун нандин гэрээнүүдийг хийж чадна. Та ариун ёслолоос хүртсэнээр долоо хоног бүр гэрээнүүдээ шинэчилж чадна. Санваарын ёслолуудаар дамжуулан Бурханы хүч таны амьдралд ирдэг (С ба Г 84:20–21-ийг үзнэ үү). Иосеф Смитийн гүйцэлдүүлсэн тэдгээр зүйлгүйгээр эдгээрийн нэгээхэн нь ч боломжгүй байх байсан.



## 5. Та хорт бодисуудад донтох донтолтоос чөлөөлөгдсөн билээ.

Тамхи уушигны хавдар үүсэх шалтгаан болж, мөн архи элэгний өвчлөлтэй холбоотой болох нь клиникээр батлагдахаас нэлээд өмнө 1833 онд Иосефийн хүлээж авсан илчлэлтэд дуулгавартай байснаар бид донтолтоос ангид байж чадна. Та нар Бурханы мэргэн ухааныг илчилж буй бошиглогчтой атлаа дэлхийн мэргэн ухаан үүнийг ойлгохыг яагаад хүлээнэ вэ? Мэргэн ухааны үг нь Бурхан бидний сүнсэнд санаа тавиад зогсохгүй бас бидний бие махбодод санаа тавьдгийг харуулдаг (С ба Г 89-ийг үзнэ үү). Эцэст нь, Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлтүүдийн дагуу бол, бие махбодтой байх нь биднийг мах хийгээд ясан биетэй Тэнгэр дэх Эцэгээс маань дутахааргүй, харин илүү адил болгодог (С ба Г 130:22-ыг үзнэ үү).

## ХАМТДАА ЯРИЛЦ

### НЯМ ГАРАГТ ТУНГААН БОДОХ ЗҮЙЛС

- Би бошиглогч Иосеф Смитийн талаарх гэрчлэлээ хэрхэн хүчирхэгжүүлж чадах вэ?
- Би үг яриа болон үйлдлээрээ амьд бошиглогчид талархах талархлаа хэрхэн илэрхийлж чадах вэ?

### ТАНЫ ХИЙЖ БОЛОХ ЗҮЙЛС

- Сүм дээр болон гэр бүл, найз нөхөдтэйгөө, эсвэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр бошиглогч Иосеф Смит таны амьдралд хэрхэн нөлөөлсөн талаар хуваалц.
- Иосеф Смитийн адил Тэнгэрлэг Эцэгээс асуултуудаа асуу. Өвдөг сөгдөн залбирч, Түүнээс удирдамж хүсэх цаг гарга. Дараа нь санаанууд юм уу, мэдрэмжүүд ирэхийг хүлээж мөн сонс. Өөрт төрсөн бодлуудаа тэмдэглэл дээрээ бич.
- 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэний хэлсэн үг “Иосеф Смит”-ийг унш. Иосеф Смитийн талаарх гэрчлэлээ хөгжүүлж мөн хуваалцах талаар түүний өгсөн хоёр санааг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарга.



## 6. Ариун Сүнсээр дамжуулан та нар өөрсдөө үнэнийг мэдэж авч чадна.

1820 онд залуу Иосефийг Ариун ойн цоорхойд очих үед олон сүм илчлэлт бол өнгөрсөн үед болж өнгөрсөн зүйл гэдэгт итгэдэг байжээ. Иосефийн анхны үзэгдэл үүнийг буруу байсныг баталсан юм. Тэнгэр зөвхөн бошиглогчдоод биш, бүгдэд нээлттэй билээ. Асуулттай

тэр нь даруухнаар, хичээнгүйлэн эрэлхийлснээр хариултаа хүлээн авч чадна (С ба Г 42:61; 88:63-ыг үзнэ үү). Жишээ нь, та Иосеф Смит Бурханы бошиглогч байсныг Иосеф Смитийн мэдэж авсан тэрхүү арга замаар, өөрөө Бурханаас асууснаар мэдэж авч болно.

Энэ жагсаалт бол зөвхөн эхлэл юм. Та юу нэммээр байна вэ? Таны амьдрал Иосеф Смитийн ачаар хэрхэн өөр байна вэ? ■

### ЭШЛЭЛҮҮД

1. Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалууд: Иосеф Смит (2007), 37–44-ийг үзнэ үү.
2. “Би Бурханы хүүхэд” Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, 58.



# “Амьд бошиглогч” нь бидэнд нас барсан бошиглогчдоос илүү чухал юм....

“... Бурханы Адамд өгсөн илчлэлт нь Ноад хөвөгч авдар хэрхэн барихыг зааварчлаагүй юм. Ноад өөрийн гэсэн илчлэлт хэрэгтэй байсан. Тиймээс та бидний хувьд хамгийн чухал бошиглогч бол Их Эзэн бидний төлөөх Өөрийн хүслийг өнөө үед илчилдэг манай эрин үед амьдарч байгаа тэр хүн юм. Тиймээс бидний уншиж чадах хамгийн чухал зүйл нь ... сар бүрийн Сүмийн сэтгүүл дээр гардаг аль нэг бошиглогчийн үгс юм. Зургаан сар тутам бидэнд өгөгддөг заавруудыг [Лиахона] сэтгүүл дээр хэвлэгдэн гардаг Ерөнхий чуулганы хэлсэн үгсээс олж авч болно...”

“Амьд бошиглогчид үргэлж давуу эрхтэй” байдаг учир амьд бошиглогчдын эсрэг нас барсан бошиглогчдын үгсийг турхирч байгаа тэдгээрээс болгоомжил.” ■

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994),  
“Fourteen Fundamentals in Following the Prophet”  
(Бригам Янгийн Их Сургууль дээрх онцгой цугларалт, 1980 оны 2-р сарын 26), 2, [speeches.byu.edu](http://speeches.byu.edu).

## Турилагаа хуваалцана уу

Амьд бошиглогчдыг дэмжин батлах нь та нарын хувьд ямар утга учиртай вэ? Гэр бүл, найз нөхөдтэйгөө эсвэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санаа бодлоо хуваалц.





# АВРАГЧИЙН дуулгавартай байдлын үлгэр жишээ


Түүний үлгэр жишээнүүд бид бүхний дагах ёстой тэрхүү загварыг бий болгодог.

**2014** оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Робэрт Д.Хэйлс “Аврагчийн амьдралаас авдаг сургамжууд дотроос хамгийн яруу тод бөгөөд хүчтэй нь дуулгавартай байдлын үлгэр жишээ юм” хэмээн заасан. Аврагчийн үлгэр жишээ нь Тэнгэрлэг Эцэгтээ дуулгавартай байх нь *яагаад* чухал болохыг заагаад зогсохгүй бас бид *хэрхэн* дуулгавартай байж чадах талаар бидэнд заадаг. Түүний номлолын дараах жишээнүүдийг авч үзэхдээ эдгээр нь таны амьдралд дагаж болох замыг хэрхэн бий болгож чадах талаар бодож үзээрэй.

“БИ ӨӨРИЙНХӨӨ  
ХҮСЛИЙГ БУС, ХАРИН  
НАМАЙГ ИЛГЭЭСЭН  
ЭЦГИЙНХЭЭ  
ХҮСЛИЙГ  
ХАЙДАГ.”

(Иохан 5:30; мөн Иохан 6:38; 8:28-29;  
14:31-ийг үзнэ үү)







## ТА ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

“Есүс ‘Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь” [Иохан 14:15], мөн “Ирээд, Намайг дага” [Лук 18:22] хэмээн бидэнд ойлгоход хялбар үгсээр дуулгавартай байхыг заасан билээ” хэмээн ахлагч Хэйлс хэлсэн.

**Бид илүү дуулгавартай байхын тулд өнөөдөр юу хийж болох вэ?**



2

1. Есүс нүгэлгүй байсан ч “бүхий л зөв шударгыг гүйцэлдүүлэхээр” баптисм хүртсэн (Матай 3:13-17; мөн 2 Нифай 31:4-7; Иохан 3:5-ыг үзнэ үү).

2. 12 настай байхад нь Иосеф, Мариа хоёр Есүсийг ариун сүмд зааж байгааг олж харахад Тэр “тэдэнд дуулгавартай байсан” бөгөөд тэднийг дуулгавартай даган гэртээ ирэв (Лук 2:42-51-ийг үзнэ үү).

3. Тэр Өөрөөс нь аягыг өнгөрүүлэхийг гуйсан ч Гетсеманий цэцэрлэгт зовж шаналахыг тэвчсэн юм (Матай 26:36-44; Лук 22:39-54-ийг үзнэ үү).

4. Тэр хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахиж, синагог дахь үйлчлэлүүдэд оролцдог байв (Лук 4:16-44-ийг үзнэ үү).

5. Эцгийн ажил ба алдар сууг тохиолгохын тулд Есүс хүмүүсийн шүүлтийг хүлцэн тэвчсэн (Исаиа 53:7; Матай 26:53; Мосе 1:39-ийг үзнэ үү).

6. Өөрийгөө цовдлохыг ёсон бус хүмүүст зөвшөөрснөөр тэр ажлаа гүйцэлдүүлсэн (Матай 27:35; Иохан 10:17-18; Галат 1:3-5-ыг үзнэ үү).



3



## АВРАГЧ ДУУЛГАВАРТАЙ БАЙСАН УЧРААС

“Аврагч дуулгавартай байсан учраас бидний нүглийг цагаатган, бидний амилуулалтыг боломжтой болгосон бөгөөд бид мөнх бүс амьдралд дуулгавартай байхад суралцах үед биднийг алдаа дутагдал гаргана гэдгийг мэдэж байсан Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очих замыг бидэнд бэлтгэсэн юм. Бид дуулгавартай байснаараа Түүнийг хуулиуд, ёслолуудад мөн сайн мэдээнд өгөгдсөн зарлигуудад дуулгавартай байснаар бүх хүн төрөлхтөн аврагдана гэдэгт бид итгэдэг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Робэрт Д.Хэйлс, “Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь” Лиана, 2014 оны 5-р сар, 35





1



6



7

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

8  
“[ХРИСТ] ТОХИНУУЛЛЫНХАА  
ҮЕЭР, ‘ТЭРЭЭР **УРУУ**  
**ТАТАЛТУУДАД**  
**ОРСОН**  
ХЭДИЙ Ч [ТЭДГЭЭРТ]  
**АНХААРАЛ**  
**ТАВЬСАН НЬ ҮГҮЙ**

[С БА Г 20:22].”

—Ахлагч Робэрт Д.Хэйлс



9



4



5



7. Есүс Эцэгтээ үргэлж дуулгавартай байж, сүнсний дэлхий рүү явж, номлолын ажлыг зохион байгуулсан (1 Петр 3:18-20; 4:6-г үзнэ үү).

8. Есүс Сатанд соригдсон ч уруу татагддаггүй юм (Матай 4:1-11; С ба Г 20:22-ыг үзнэ үү).

9. Тэрээр үргэлжлүүлэн Эцгийн хүслийг гүйцэлдүүлж, мөн Сүмийг удирдаж байна (Иосеф Смит—Түүх 1:16-17; С ба Г 19:2, 24-ийг үзнэ үү).



# БИДНИЙ ОРОН ЗАЙ



## ГАЛ СӨНӨӨГЧИД БА БУРХАНЫ ХУЯГ ДУУЛГА

**С**айн дурын гал сөнөөгчөөр ажиллаж байсан тэр нэг өдөр ажил дээр тайван байсан учир би Мормоны Номоо уншихаар шийдэв. Хамт ажиллагсдын маань нэг нь миний уншиж байгааг хараад, өнөө үед бид хэрхэн Бурханы хуяг дуулгыг өмсөж чадах талаар мэддэг эсэхийг минь асуусан юм. Биднийг ярилцаж байтал дохиолол дуугарав.

Ойролцоох дэлгүүрт гал гарсан байлаа.

Бид галын өмсгөлүүдээ шалавхан өмсөж, шууд тийшээ явсан юм. Гал маш том хэмжээтэй байсан бөгөөд биднийг дэлгүүрт ойртон очих үед зам дээр маань нэгэн зүйл дэлбэрч, гал биднийг хүрээлэн авав. Тэр дэлбэрэлт хамтрагч бид хоёрыг хэдэн секунд тун сандаргаж билээ. Төхөөрөмж ба хамгаалалтын хувцасныхаа ачаар бид ямар ч гэмтэл авсангүй.

Бид тэр галыг унтраагаад, хэсэг дээрээ ирсний дараа Бурханы хуяг дуулгын талаар асуусан асуултаа санаж байгаа эсэхийг нь би түүнээс асуусан юм. Тэр санаж байна гэв. Бурханы хуяг дуулга нь бидний галын өмсгөлтэй адилхан гэж би түүнд тайлбарлаж хэлэв. Бид үүнийг үргэлж өмсөх хэрэгтэй бөгөөд ингэснээр дайсны хүчирхэг дайралтуудыг сөрөн зогсож чадна. Бид зарлигуудыг дагавал Бурханы хуягийн хамгаалалтын хүчээр адислагдаж, Ариун Сүнс бидний хөтөч байх болно. ■  
Фэрнандо Дэ Ла Роса Маррон, Мексик





## МИНИЙ ДУРТАЙ СУДАР

**1 Самуел 16:7.** “БУРХАН ХҮНТЭЙ АДИЛ ХАРДАГҮҮЙ; ХҮН ГАДНАХ ТӨРХИЙГ ХАРДАГ БОЛ ЭЗЭН ЗҮРХИЙГ НЬ ХАРДАГ.”

Би Сүмд орохоосоо өмнө өөрийгөө байдаг л нэг жирийн хүн гэж үргэлж боддог байв. Надад санал болгох үнэ цэнэтэй юу ч байхгүй юм шиг санагддаг байлаа. Хүмүүс намайг үл ойшоож, гомдоох вий гэсэн айдсаасаа болоод өөрийгөө бусдад таниулахаас айдаг байв. Миний эргэн тойрны бүх хүн надаас илүү хүчтэй, илүү ухаантай, илүү сайн гэж би боддог байв.

Гэвч энэ бүх ойлголт нь намайг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болох үед өөрчлөгдсөн юм. Бид бүгд Бурханы хүүхдүүд бөгөөд тэнгэрлэг шинж чанаруудыг өвлөн авсан гэдгийг би мэдэж авсан. Хэн нь илүү ухаантай, баян эсвэл сайхан харагдаж байгааг шалгаруулах өрсөлдөөн байдаггүйг би ойлгосон юм. Их Эзэний нүдэнд бид бүгд адил тэгш бөгөөд Тэр бидний гадаад үзэмжээс үл хамааран, бидний дуулгавартай байдал ба Түүний тогтоосон замыг дагах хүслийн маань дагуу биднийг шүүх Цорын ганц хүн юм. ■

**Жөүн Азүкэнэ, Филиппин**

## ЧИ НЯМ ГАРАГТ АЖИЛЛАХ УУ?

**Б**и 15 настай байхдаа Есүс Христийн сайн мэдээний талаар хүчирхэг гэрчлэлтэй болсон бөгөөд Сүмд нэгдэхдээ маш их баяртай байв. Би тэр үед гэр бүлээ тэжээхийн тулд ажиллаж байлаа. Гэсэн хэдий ч, би баптисм хүртсэнийхээ дараа удалгүй ажилгүй болсон юм.

Тэр бүл маань надаас шалтгаалж байсан учраас би шинэ ажил хурдан олох хэрэгтэй байв. Гэвч миний өргөдөл гаргасан ажил бүр нь намайг ням гарагт ажиллахыг шаардаж байлаа. Би ням гарагт Сүм дээр байх хэрэгтэй гэдгээ мэдэж байсан учраас олон ажлын саналаас татгалзаж билээ (С ба Г 59:9–10-ыг үзнэ үү).

Хоёр сар хайсан ч би ажил олж чадаагүй л байв. Ээж маань Сүмийн гишүүн биш байв. Тэр Бурханд итгэдэг байсан ч намайг ийм олон ажлаас татгалзсанд тун их ууртай байсан юм.

Тэр нэг орой нулимстай нүдээр над руу харж, “Чамайг зөвийг хийж, ийм итгэлтэй байхад Бурхан яагаад бидэнд ийм зүйл тохиолдохыг зөвшөөрч байгаа юм бэ?” гэж асуув.

“Ээж ээ, яагаад ийм зүйл тохиолдож байгааг би мэдэхгүй ч би зөв зүйл хийж байгаагаа

мэднэ, бас үүний төлөө Бурхан биднийг адислах болно гэдгийг би мэднэ” гэж хариулсан юм.

Маргааш өглөө нь нэг хүн надад нэлээн их мөнгөөр нэг байшингаас нөгөө рүү хүнд ачаа зөөх 2 хоногийн ажил санал болгов. Тэр нь хүч шаардсан ажил байсан ч, би мөнгөө авангуутаа гэртээ шууд харьж, талархлаа илэрхийлэн залбирав. Удалгүй би ням гарагт амрах боломжтой нэг сайн ажил олсон бөгөөд түүнээс хойш ажилгүй байж үзээгүй.

Би хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихыг сонгосондоо баяртай байдаг. Амьдралд олон сорилт бэрхшээл байдаг ч, эдгээр сорилт бэрхшээлээс үл хамааран бид хүчтэй байхаар хичээх юм бол Их Эзэн биднийг адислах болно. ■

Сахил Шарма, Энэтхэг





Арванхоёр  
Төлөөлөгчийн Чуулгын  
ахлагч  
Нийл Л.Андэрсэн

# ХЭРХЭН МЭРГЭН УХААНТАЙ БАЙХ ВЭ?

Энэхүү мэдээллийн асар том давалгаан дунд бидэнд мэргэн ухаан—сурч мэдсэн зүйлээ амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэхийг **олж мэдэн, таних** мэргэн ухаан бидэнд агаар ус шиг хэрэгтэй байна.

Эдгээрийг санацгаая:

1. Бид мэргэн ухааныг эрэлхийлэх ёстой.
2. Мэргэн ухаан олон талтай, олон хувилбартай юм.
3. Насны залууд эзэмшсэн мэргэн ухаан үй олон адислалыг авчирна.
4. Аль нэг салбарт эзэмшсэн мэргэн ухааныг өөр салбарт ашиглаж болдоггүй.
5. Дэлхийн мэргэн ухаан олон тохиолдолд их үнэ цэнэтэй ч, энэ нь Бурханы мэргэн ухааныг хүлээн зөвшөөрсөн үед үнэ цэнэ нь үлэмж ихэсдэг.

Судруудад хоёр төрлийн мэргэн ухаан болох дэлхийн болон Бурханы мэргэн ухааны тухай дүрслэн өгүүлсэн байдаг. Дэлхийн мэргэн ухаан эерэг, сөрөг хоёр талтай.

Сөрөг талаас нь авч үзвэл, дэлхийн мэргэн ухааныг аминч үзэл ба хилэнцэт зорилгын улмаас оюун билэг хийгээд зальжин өнгөлөн далдлалттай холилдсон, хагас үнэн хэмээн дүрсэлж болно.

Тийм ч чөтгөрийн сэдэлтэй бус, дэлхийн мэргэн ухааны өөр нэгэн төрөл бий. Хэрэг дээрээ энэхүү мэргэн ухаан сайн талтай юм. Энэхүү мэргэн ухааныг **сургалт, судалгаа, тунгаан бодох, ажиглалт болоод шаргуу хөдөлмөрийн** үр дүнд ухамсартайгаар олж авдаг. Бидний хийдэг зүйлүүдээр энэ нь маш үнэ цэнэтэй бөгөөд ач тустай юм. Биднийг мөнх бус амьдралынхаа аяныг үргэлжлүүлэх үед энэ нь сайн бөгөөд зохистой хүмүүст ирдэг.

Хамгийн чухал нь, дэлхийд амжилт авчирч байгаа мэргэн ухаан нь өөрийгөө Бурханы мэргэн ухаанаас илүү гэж бодох биш, харин түүнд захирагдах хүсэлтэй байх ёстой.

Бүх мэргэн ухаан адил тэгшээр бүтээгдээгүй. Дэлхийн мэргэн ухаан, Бурханы мэргэн ухаан хоёр хоорондоо зөрчилдөж байгаа үед бид өөрсдийн хүслийг **Бурханы мэргэн ухаанд захируулах ёстойг** мэдэж авах хэрэгтэй.

Өөртөө тулгарч байгаа асуудлуудыг анхааралтай авч үзэхийг би та бүхэнд санал болгож байна. Цаасны голд босоо шугам зур. Шугамны зүүн талд дэлхийн мэргэн ухааныг, баруун талд нь Бурханы мэргэн ухааныг жагсаан бич. Нэг нэгэнтэйгээ зөрчилддөг асуудлуудыг ялган бич.

**Та ямар ямар сонголт хийж байна вэ?**

Аврагчийн Хоёр дахь ирэлт рүү хөтөлж буй үйл явдлуудын тухай өгүүлдэг Сургаал ба Гэрээний 45-р хэсэгт Их Эзэн арван онгон охины тухай түүхийг дахин ярьж, дараах үгсийг бидэнд захиж үлдээсэн юм: “Учир нь мэргэн хийгээд үнэнийг хүлээн авсан, мөн Ариун Сүнсийг

зам заагчаа болгон авсан бөгөөд мэхлэгдээгүй хүмүүс—үнэнээр би та нарт хэлнэ, тэд тас цавчигдаж, галд хаягдахгүй, харин тэр өдрийг тэсэн гарах болно” (С ба Г 45:57-г үзнэ үү).

**Бурханы мэргэн ухааныг** эрэлхийлцгээе. Мэргэн ухаанд одооноос суралцахын тулд бидэнд хийх зүйл маш их байна. Та мэргэн ухааныг—Бурханы мэргэн ухааныг эрэлхийлэх үед Их Эзэн адислалуудыг өгнө гэдгийг би та нарт амлаж байна. Тэр бидэнд Өөрийн мэргэн ухааныг өгөх үнэхээр их хүсэлтэй байдаг. Хэрэв бид дуулгавартай, залбиралтай байж, мэргэн ухааныг эрэлхийлэх аваас энэ нь ирэх болно. ■

2009 оны 4-р сарын 10-нд Айдахо дахь Бригам Янгийн Их Сургууль дээр болсон онцгой цугларалт дээр хэлсэн үгээс.

## ТА ҮҮНИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН БЭ?

“Сонгох хоёр төрлийн боломж үргэлж байдаг. Та нар хүссэнээ сонгож болно. Гэвч та нар ухаалаг шийдвэр гаргах хэрэгтэй. Их Эзэнийг сонгох нь өдөр бүр та нарт тусалж чадах бөгөөд Ариун Сүнсийг дэргэдээ байхыг сонгосноор нөхцөл бүрд тань тусалж чадна гэдгийг би хэлж чадна. Буруу талыг сонгосноор хэсэгхэн зуур аз жаргалтай мэт санагдах аз жаргалгүй мэдрэмж рүү удирдагдаж болох бөгөөд та нар дараа нь үр дагавруудыг нь харж, гаргасан шийдвэртээ гашуудан харамсах болно. Их Эзэний талд бай! Энэ нь үргэлж амархан байдаггүй ч хийх нь зүйтэй!”

Сэмүел Ж., Австри



# НҮДЭЭ ОЛСОН ХАРИУЛТ



## Зохисгүй зүйл болж байгаа гэдгийг мэдсээр байж, **сайн** **үлгэр жишээ** үзүүлэхийн тулд **бүжиг** эсвэл **үдэшлэгт** явах нь зөв үү?

**И**йм нөхцөлд ямар сайн үлгэр жишээ үзүүлж чадна гэж бодож байгаагаа” өөрөөсөө асуу. Та мансууруулах бодистой, эсвэл архитай, даруу бус хувцасласан, эрээ цээргүй үг бүхий хөгжимтэй, эсвэл зохисгүй бүжигтэй хаа нэгтээ очих гэж байгаа бол ийм зүйлүүдгүйгээр хүмүүс баяр баясгалантай байж болохыг хэрхэн харуулж чадах вэ? Таны эргэн тойронд байгаа хүмүүс “Энэ чинь итгэл болоод жишгүүдийн агуу жишээ биш үү?” эсвэл “Энэ хүн ер нь яах гэж ирсэн юм бол?” мэтээр юу ч гэж бодож болох юм. Ихэнх нөхцөлд та нар өөрсдийгөө санаатайгаар, мэдсээр байж уруу татагдуулахгүйн тулд тэр газрууд руу явахгүй байвал илүү сайн үлгэр жишээ үзүүлж чадна. ■

## Сатан миний бодлуудад хэр их нөлөөлдөг вэ?

**Т**энгэрлэг Эцэг бидэнд сайныг эсвэл мууг сонгох боломж бүхий ёс суртахууны сонгох эрхийг олгодог. Тэр биднийг сайныг хийхэд хүчилдэггүй бөгөөд чөтгөр ч биднийг муу зүйл хийхэд хүчилж чадахгүй (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалууд*:

*Иосеф Смит*-ийг үзнэ үү [2007], 214).

Тиймээс энэ нь та нарын бодол санаанд орж ирэх үед та нарын зөвшөөрсний дагуу л чөтгөрт нөлөөнүүд өгөгддөг. Бошиглогч Иосеф Смит хэлэхдээ: “Бид өөрсдөө л зүрх сэтгэлдээ хүлээн

зөвшөөрч, бууж өгөхгүй бол Сатан биднийг уруу таталтуудаараа уруу татаж чадахгүй” гэжээ (*Иосеф Смитийн сургаалууд*, 213). Тэр цааш нь “Бид түүнд боломж олгохгүй л бол чөтгөр бидний дээр ямар ч хүчгүй байх болно” хэмээн хэлсэн (214).

Үүнээс гадна, судрууд бидэнд “Бурханаас өөр чиний санаа бодол хийгээд зүрх сэтгэлийн тань хүсэл эрмэлзлэлийг мэдэх хэн ч үгүй” (С ба Г 6:16)

хэмээн заадаг. Сатан үнэндээ та нарын юу бодож байгааг мэддэггүй. Тэр бидэнд зөвхөн уруу таталтуудыг болон дур татах зүйлсийг санал болгож л чадна. Гэвч та нар тэднийг дагахаар сонгох үед тэр та нарын дээр улам их хүчээ авч, уруу таталтууд илүү хүчтэй болдог. Үүнтэй адилаар, хэрэв та нар муут эсэргүүцэж, сайныг сонговол та нар хүчирхэгжиж, мөн адислагдах болно. ■

# Хоньчин ба ХОНИН СҮРЭГ

Хонин сүргийн хороо нь Аврагч Өөрийн хүмүүст санаа тавьдаг талаар бидэнд заадаг.



## Эртний хонин сүрэг

**Энэ юу вэ:** Энгийн нэг малын хашаа, ханаар босгосон хороо

**Зорилго:** Хонин сүргийг ялангуяа шөнийн цагаар араатан амьтнаас болон хулгайчаас хамгаалах

**Материал ба байгууламж:** Чулуунуудыг, ихэвчлэн өргөстэй бутыг хана болгон байрлуулдаг байжээ. Зузаан өргөстэй бут сөөгийг хонины түр хороо хийхдээ ашигладаг байв. Агуйнуудыг заримдаа хонины хороо болгон ашигладаг байсан ба жижигхэн чулуу эсвэл хожуулуудыг хашлага болгон өмнө нь байрлуулдаг байсан.



## БИБЛИЙН ТҮҮХЭН БАРИМТУУД

- Хонины мах, сүү, өөх тос, ноос, арьс болон эвэр нь маш үнэ цэнэтэй байсан бөгөөд гол тахилын амьтан болгон ашигладаг байв.
- Израильд хоньдыг барьдаг араатан амьтдын дотор чоно, дэлт чоно, ирвэс болон цөөвөр чононууд байдаг. Эрт цагт арслан, баавгай ч бас тэр нутагт оршин амьдардаг байв (1 Самуел 17:33-37).
- Хоньчид хоньдыг таягаар удирдаж, саваа ба дүүгүүрээр хамгаалдаг байв.
- Хоньчин өдрийн турш хоньдоо бэлчээрлүүлж, ус руу дагуулж яван, (Дуулал 23:1-2-ыг үзнэ үү) шөнийн цагаар сүрэгтээ буцаан авчирдаг байв. Хоньчин хоньдоо эргэж ирэхэд нь тоолж, хэрэв алдагдсан бол эрж хайдаг байлаа. Тэгээд тэр тэднийг хамгаалахаар сүргийн хорооны үүдэнд хэвтдэг байв.
- Есүс Христ бидний төлөө амиа зориулсан учраас Тэр Өөрийгөө Сайн Хоньчин хэмээн нэрлэдэг байв (Иохан 10:11-15-ыг үзнэ үү.) Бид Түүгээр дамжуулан сүнслэг тэжээл, амралт, амар амгалан, аврал ба өргөмжлөлийг хүлээн авдаг учраас Тэр Өөрийгөө хонин сүргийн хаалгатай адилтгасан (Иохан 10:1-9-ийг үзнэ үү) байдаг.
- Төлөөлөгч Паул хонин сүргийг Сүмтэй харьцуулсан (Үйлс 20:28-ыг үзнэ үү).



## БУСАД ХОНЬ

Аврагч “Энэ ... хонин сүргээс өөр хонин сүрэг надад бий” (Иохан 10:16) хэмээн хэлэхдээ Израилийн угсаанаас удирдагдан гарсан нифайчууд болон леменчүүдийг хэлсэн (3 Нифай 15:14-24-ийг үзнэ үү). Мөн тэр Израилийн алдагдсан овгууд дээр айлчилж очсон талаар ярих (3 Нифай 15:20; 16:1-3).

## Бид юу сурч чадах вэ

Хонины хороо нь:

**Хонин сүргийг цуглуулдаг газар.** Сүмийн гишүүдийн хувьд бид өөрсдийн итгэл болон гэрээнүүдээр дамжуулан, мөн хамтдаа цугларснаар эв нэгдэлтэй байдаг. Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг заахдаа: “[Тэнгэрлэг Эцэг]-ийн бидэнд өгөхийг маш их хүсдэг эв нэгдлийн баяр баясгалан нь энгийн зүйл биш юм.” Бид үүнийг эрэлхийлж, бусадтай хамт бэлтгэх ёстой. Бурхан биднийг адислахын тулд цуглуулахаар шавдуулж буй нь гайхах зүйл биш юм. Тэрээр биднийг гэр бүлдээ цуглараасай хэмээн хүсэж байгаа. Тэрээр анги, тойрог, салбаруудыг байгуулж, биднийг байн байн уулзаж байхыг зарлигласан. Бид эдгээр цуглалт дээр . . . бидэнд баяр баясгалан авчирч, үйлчлэх хүч чадлыг маань өсгөх эв нэгдлийн төлөө залбирч, мөн ажилааж болно” гэжээ (“Бидний зүрх сэтгэл нэгдмэл байг,” *Лиахона*, 2008 оны 11-р сар, 69).

**Аюулгүй бөгөөд амралтын газар.** Есүс Христээр дамжуулан бид “сэтгэлдээ амралтыг олох болно” (Матай 11:29). Түүний Сүм бол “хамгаалалтын мөн . . . хоргодох газар” юм (С ба Г 115:6). Арванхоёр Төлөөлөгчдийн Чуулгын ерөнхийлөгч Боид К.Пакэр заахдаа “Бид бүхэн байгуулсан гэрээгээ хүндэтгэн, Христийн дагалдагчдын хувьд шаардлагатай тэрхүү дуулгавартай байдлын энгийн үйлсийг үйлдэж амьдарснаар өөрсдийн болон үр хүүхдүүдийнхээ хамгаалалт болон аюулгүй байдлыг хангаж чадах юм” (“Миний мэддэг зүйлс,” *Лиахона*, 2013 оны 5-р сар, 7) гэжээ.

**Хоньчноор хамгаалуулсан.** Есүс Христ бол биднийг авардаг Сайн Хоньчин юм. Бид гэм нүгэл ба үхлийг ялан дийлж, Тэнгэрлэг Эцэгтээ эргэн ирж болохын тулд Тэр зовж шаналан, нас барсан билээ. Бид Христэд ирж, Түүний зарлигуудад дуулгавартай байснаар Тэр биднийг хувь хүний хувьд болон Түүний гэрээт хүмүүсийн хувьд аль алиныг нь адисалж, удирдаж бас хамгаалдаг. ■

# “Би өөртөө тохиолдсон асуудал, санаа зовоосон зүйлийнхээ талаар бишоптойгоо ярилцахын тулд хэрхэн тайван байж болох вэ?”

**Ч**и өөрт тулгамдсан асуудлынхаа талаар бишоптойгоо ярихдаа сандарч болох бөгөөд энэ нь хэвийн зүйл юм. Бид ихэнхдээ ямар нэгэн шинэ зүйл болохоос өмнө, эсвэл насанд хүрсэн хүнтэй ярихаасаа өмнө сандардаг шүү дээ.

Гэвч бишоп нь Бурханаас дуудагддаг. Тэрээр Есүс Христийн бүхнээ зориулсан шавь учраас дуудагдсан юм. Тэр эелдэг байж, бас ойлгохын тулд чадах бүхнээ хийх болно. Чамд амар амгаланг олж, Аврагчид ирэхэд туслах нь түүний зорилго юм. Өөрийнхөө асуултууд эсвэл нүглүүдийнхээ талаар түүнтэй ярилцахад эхэндээ ичмээр байж болох ч тэр чамайг муугаар бодохгүй. Үнэндээ, тэр чамайг сайжрах хүсэлтэй байгаад баяртай байх болно. Мөн тэр чиний хэлсэн зүйлсийг нууцлах болно.

Чи ачаагаа ганцаараа үүрэх шаардлагагүй юм. Бишоп чинь хариултуудаа олоход чамд туслаад зогсохгүй, шаардлагатай бол Христийн Цагаатгалаар дамжуулан гэм буруу, цөхрөл эсвэл зохисгүй байдлаа наманчилж, даван туулахад чамд туслах болно.

Чи бишоптойгоо ярилцах үедээ түүний хайрыг мэдрэх болно. Тэр тойрог эсвэл салбараа бүхэлд нь хариуцдаг ч, түүний анхаарлаа хандуулах гол зүйл нь залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн сайн сайхан байдал юм. Түүнээс тусламж хүссэнээр чи түүнд саад болж буй хэрэг биш юм.

Бишоптойгоо ярилцах хүч чадал, зоригийн төлөө чи Тэнгэрлэг Эцэгтээ залбирч болно. Тэрээр чамд туслах эрх мэдлийг бишопт чинь өгсөн бөгөөд бишоп чинь үүнийг хийх хүсэлтэй байх болно. Хэрэв чи зүрх сэтгэлээ нээлттэй байлгаж, мөн өөрчлөгдөх хүсэлтэй очих юм бол өмнө нь байснаас ч илүү сайхан мэдрэмжтэйгээр түүний өрөөнөөс гарч яваагаа мэдэх болно.

## Тэр чамайг муугаар бодохгүй

Танай тойргийн бишопт наманчлалын үе шатуудаар дамжуулан чамайг удирдах эрх мэдэл өгөгдсөн билээ. Заримдаа бишоп дээрээ очих нь чиний хувьд Аврагчаар дамжуулан бүрэн наманчилж болох цорын ганц арга зам байдаг. Намайг бишоптойгоо ярилцах үед тэр Аврагчийг олоход, бас амьдралдаа тохиолдсон хамгийн гүн шархыг даван туулахад надад тусалсан юм. Бишоп тань чамд туслахыг хүсдэг. Түүний дуудлага бол та нарт санаа тавих бөгөөд түүнтэй уулзах шаардлагатай болсон шалтгаанаас тань болж тэр чамайг муугаар бодохгүй.

*Мадисон Д., нас 18, АНУ, Юта*

## Бишоп чинь туслахад бэлэн байдаг

Ярилцахад надад эвгүй байдаг байсан ч асуудлуудаа шийдвэрлэхэд минь бишоп туслахад үргэлж бэлэн байдгийг би сүүлд ойлгосон юм. Бишопдоо итгэ; Тэр хоньчин бөгөөд тойрог бол түүний хонин сүрэг юм.

*Жэйм Р., 19 настай, Боливи, Кочабамба*



## Тэр чиний итгэлийг хөсөрдүүлэхгүй

Бишоп бол өсвөр үеийнхний тусламж хүсэж болох хамгийн итгэл даахуйц насанд

хүрсэн хүн юм гэдгийг би мэдэж авсан. Тэр та нарын итгэлийг хэзээ ч хөсөрдүүлэхгүй бөгөөд түүнтэй хуваалцсан бүх зүйл тань түүний өрөөнд үлдэх болно. Заримдаа асуудлуудынхаа талаар ярихад үнэхээр хэцүү байж болох ч та нарыг хайрлаж, санаа тавьж, та нарт хамгийн сайн сайхныг хүсдэг хэн нэгэнтэй нүүр тулан ярилцах нь үүнийг илүү амархан болгодог.

*Никол С., нас 18, АНУ, Айдахо*





### Та нар түүнд найдаж болно

Бишоп эсвэл салбарын ерөнхийлөгч тань Их Эзэний үнэнч үйлчлэгч мөн. Та нар

Ариун Сүнснээс болон судруудаас илчлэлт эрэлхийлэх үедээ түүний удирдамжинд найдаж болно. Бишоп нь та нарт туслахын тулд байдаг бөгөөд тэрээр Бурханаар удирдагддаг гэдгийг та нар ойлгох ёстой.

*Станислав Р., 19 настай, Украин, Донэцк*



### Тэр чамд хайртайг сана

Бишоптойгоо үнэхээр ярилцахыг хүсэж байгаа ямар нэг зүйл чамд байгаа бол эхлээд

сургуулийнхаа талаар, бас бусад ерөнхий зүйлийн талаар түүнтэй ярилцах нь илүү хялбар байж болох юм. Түүнтэй наманчлалын асуудлаар ярилцах хэрэгтэй байгаа учраас сандарч байгаа бол зүгээр л тэр чамд хайртай гэдгийг сана. Тэр чиний талаар юу гэж бодох бол гэж санаа зовох хэрэггүй. Учир нь Христтэй илүү ойр байхыг хүсдэг атлаа тэр чамайг яагаад дорд үзэх билээ?

*Ашли Д., 17 настай, АНУ, Аризона*



### Мэдэхийн тулд залбир

Бишоптойгоо ярилцахад чамд яагаад эвгүй санагдаж байгааг өөрөөсөө асуу.

Асуудлуудаа шийдвэрлэхэд чинь тэр чамд туслах боломжгүй гэж чи бодож байна уу? Бишоп чинь чамд хайртай бөгөөд тэр чамд туслахын тулд дуудагдсан гэдгийг мэдэхийн тулд залбир.

*Адам Х., 13 настай, АНУ, Калифорни*

### Чамайг алдаа гаргасан ч

Бишоптоо нүглээ хүлээх нь хэцүү бөгөөд ичмээр байж болох ч, түүний өрөөнөөс гарч явах үед чи тайвширснаа, мөн Тэнгэрлэг Эцэг чамд хайртайг мэдэх болно. Чи алдаа гаргасан ч, Тэр чамайг жаргалтай байгаасай гэж хүсдэг.

*Аманда В., нас 16, АНУ, Юта*

### Тэр энд туслахын тулд байдаг

Бишоп нь танай тойргийн хоньчин юм. Тэр та нарт туслахын тулд чадах бүхнээ хийх бөгөөд Бурханы хүч түүний талд байгаа гэдгийг сана. Хэрэв чи айж байвал бишоптойгоо ярилцах боломжтой болох хүч чадлын төлөө залбирч болно. Эцэст нь чи түүнтэй уулзахаар явсандаа баяртай байх болно. Мөн энэ нь үнэ цэнэтэй зүйл байх болно.

*Самуэл Х., нас 14, АНУ, Айдахо*

*Энэ сэдвээр дэлгэрэнгүй судлах бол С.Скотт Грөүгийн "Би яагаад бишоптоо гэмээ хүлээх хэрэгтэй вэ, гэмээ хүлээхийн тулд юу хийх хэрэгтэй вэ?" хэлсэн үгийг үзнэ үү. Лианоха, 2013 оны 11-р сар, 59*



### ТҮҮНД НАЙД

"Санваарын удирдагчдаас, ялангуяа бишопосоо зөвлөгөө эрэлхийл. Тэр

жишгүүдийг мэддэг бөгөөд чамд юу заахаа мэддэг. Түүнтэй хамт байхын тулд боломжуудыг эрэлхийл. Та нар мэдэхийг хүсэж буй асуултуудаа илэн далангүй асуухдаа түүнд найдаж болно. Түүнд итгэ. Түүнд найд. Их Эзэн чамаас юу хүсэн хүлээж байгааг ойлгоход туслахыг түүнээс хүс. Сүмийн ёс суртахууны жишгүүдийн дагуу амьдрахаар амла. Насанд хүрсэн удирдагчтай утга учир бүхий харилцаатай байх нь ёс суртахууны хувьд цэвэр, зохистой байхад та нарт туслах болно."

**Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М.Рассэлл Баллард, "Purity Precedes Power," Ensign, 1990 оны 11-р сар, 37**

## ДАРААГИЙН АСУУЛТ

**"Хожмын үеийн гэгээнтэн гэдгээсээ болж би сургууль дээрээ шоолуулдаг. Итгэдэг зүйлийнхээ төлөө зогсох хэрэгтэйг би мэддэг ч энэ нь үнэхээр хэцүү байдаг! Би тэдэнд хэрхэн боль гэж хэлэх хангалттай зоригтой болох вэ?"**

Хариултаа, хүсвэл өндөр нягтралтай зургийн хамт [liahona.lds.org](mailto:liahona.lds.org) хаягаар, э-мэйл бичих бол [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org) хаягаар эсвэл шуудангаар илгээх бол 3-р хуудсан дээрх хаягаар 2015 оны 5-р сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Э-мэйл эсвэл захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) овог нэр, (2) төрсөн огноо, (3) тойрог эсвэл салбар, (4) гадас эсвэл дүүрэг, (5) таны хариулт ба гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн бичгээр хийсэн өөрийн тань зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой болгохын тулд хянан засварлаж магадгүй.

Элли өөрийнх нь баатар хэн  
болохыг мэдэж байсан ч үүнийг  
хэлэхээс их айж байлаа.

# ЧИННИЙ

Чарлотт Мэй Шэппард

Бодит түүхээс сэдэвлэв

“Мөс чанартай, нэр төртэй, итгэлтэй зогс;  
баатар шиг зогс” Children’s Songbook, 158).

Элли сандарсандаа эрхий хурууныхаа  
хумсыг мэргэж байв. Хатагтай Фиц ши-  
рээний эгнээнүүдээр явж, нэг асуултыг  
сурагч бүрээс асууж байлаа.

“Чиний баатар хэн бэ?” гэж хатаг-  
тай Фиц Жэрэмигээс асуув.

Жэрэми хормын төдийд  
л хариулав. “Миний аав” гэж  
тэр бахархалтай хэлэв.

Хатагтай Фиц инээмсэглэв.  
“Сара, харин чинийх?”





# баатар хэн бэ?

Тэр бас хурдан гэгч нь “Абрахам Линкольн” гэж хариулав.

Хатагтай Фицийг ойртох тусам Эллигийн зүрх хурдан хурдан цохилж байв. Тэд баатруудын талаар өдөржин ярилцсан байсан бөгөөд одоо хүн бүр ангийнхныхаа өмнө өөрсдийнхөө баатрыг хэлэх цаг болоод байв!

Амбэр, Жастин хоёр ээжүүд нь тэдний баатар гэж хэлэв. Волтэр өвөөгөө түүний баатар гэж хэлэв. Цөөн хэдэн сурагч л тэдний баатрууд бол хаан эсвэл ерөнхийлөгч гэж хэлж байлаа.

Хатагтай Фицийг Эллид хүрэхэд ердөө хэдхэн сурагч үлдээд байв. Тэр нэг баатрыг маш хурдан бодож олох хэрэгтэй байв.

Элли ичсэндээ, доошоо гутал руугаа харж байлаа.

Баатар бодож олох нь жинхэнэ асуудал биш байв. Тэр өөрийнх нь баатар хэн бэ гэдгийг аль хэдийн мэдэж байлаа. Энэ бол

Есүс Христ байв. Тэр өвчтэй хүмүүсийг эдгээж, үхэгсдийг амилуулж, хүн бүрийн гэм нүглийн төлөө төлөөс төлсөн. Тэр өмнө нь амьдарч байсан баатруудаас хамгийн агуу нь байв! Тэр зүгээр л үүнийг хэлэхээс айж байлаа.

Элли Есүс Христ түүний баатар гэж ангийнхандаа хэлбэл яах бол гэж бодон, эрхий хурууны хумсаа дахин мэрэв. Жэрэми түүнийг шоолбол яах вэ? Завсарлагаанаар Сара, Амбэр хоёр түүний талаар шивнэлдвэл яах вэ?

Мэдээж, тэр Есүс Христ түүний баатар гэдгийг мэдэж байв. Гэвч энэ нь хүн бүр үүнийг мэдэх ёстой гэсэн үг биш шүү дээ.

Хатагтай Фиц Эллигийн ширээний өмнө

зогсоод, инээмсэглэв. “Харин чиний баатар хэн бэ, Элли?”

Элли хажуугийн эгнээнийхээ сурагчдыг болон хатагтай Фицийг харав. “Абрахам Линкольн” гэж тэр шивнэн хэлэв.

Хатагтай Фиц инээмсэглэв. Тэр дараагийн сурагч руу алхангаа “Сайн байна” гэж хэлэв.

Түүнийг цааш явмагц, Элли тайвшрав. Ашгүй бүх зүйл өнгөрлөө. Ангид байсан хүн бүрд түүний мэдүүлэх хэрэгтэй байсан хамгийн сүүлийн зүйл бол түүний баатар—

“Есүс Христ” гэж өөр нэгэн дуу хоолой хэлэв.

Элли удаанаар өнгийн харахдаа нүдээ бүлгийлгэн харлаа. Тэр эгнээнээс бага зэрэг цааш явахад, өрвийсөн үстэй нэгэн жижиг биетэй хүү суудаг байв. Тэр туранхай, бас ичимхий байсан бөгөөд үргэлж ангийн хойно суудаг байсан. Элли түүний нэрийг нь ч мэддэггүй байв. Тэр одоо хүртэл түүнийг ямар нэгэн үг хэлж байсныг огт санадаггүй.

Хэдэн сурагч түүн рүү харахаар эргэж харсан ч, тэр тэднийг анхаарсангүй. Тэр зөвхөн хатагтай Фиц рүү хараад, “Миний баатар бол Есүс Христ” гэж дагтан хэлэв.

Хатагтай Фиц сайхан гэгч инээмсэглэн, эгнээгээр цааш явав. Гэвч Элли тэр хүү рүү гайхан харлаа. Тэр өөрийнхөө баатрын талаар хүн бүрд хэлэхээс айж байсан байхад, тэр хүү айсангүй. Тэр хүү Эллигийн явдаг сүмд явдаггүй шүү дээ! Энэ нь хэдийгээр хэцүү ч гэсэн Есүс Христийн үлгэр жишээ болж зогсох нь хэчнээн чухал болохыг тэр хүү мэддэг байв.

Элли тэр хүү рүү харан инээмсэглэлээ. Тэр өөрийнхөө баатрыг хэлэхдээ дахин хэзээ ч айгаагүй юм. Түүнд одоогоор хоёр удаа ийм туршлага тохиолдоод байна. ■

*Энэ өгүүллийг бичигч АНУ-ын Калифорнид амьдардаг.*



# Залбирал ба дуган сүм

Маккэллэ Жорж

Бодит түүхээс сэдэвлэв

*“Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол, миний шавь нар мөн” (Иохан 13:35).*

Дани охин дээшээ харсан ч үзэсгэлэнтэй дуган сүмийн оройг харж чадсангүй. Өөр сүмд явдаг хүмүүс энд ирдэг байв. Дани гэр бүлийнхэн нь яагаад энэ сүм рүү баасан гарагт явж байгааг ойлгоогүй юм. Харин аав нь оройн залбиралд оролцохоор явж байгаагаа хэлсэн юм.

“Тэр чинь юу юм бэ?” гэж Дани асуув.

“Энэ бол хүмүүсийн дуулж, судар уншиж, хамтдаа залбирдаг цуглаан юм.” “Орой бүх гэр бүлээрээ цугладаг шиг” гэж аав нь хэлэв.

Дани үүнийг сонсоод баяртай байв. Тэр гэр бүлийнхэнтэйгээ Англи руу аялж байжээ. Өнгөрсөн ням гарагт тэд Иорк хэмээх нэртэй хотын нэг тойрогт очив. Хүүхдийн хэсэгт байсан бүх хүүхэд Данигийн мэддэг судар ба дуунуудыг мэдэж байлаа. Түүний очсон энэ тойрог нь тэдний явдаг тойрогтой адил Есүсийн үнэн Сүмийн нэг хэсэг байсныг тэр мэдэж байв.

Гэвч энэ дуган сүм түүний явдаг сүмээс маш өөр байлаа. Тэр дүүрэн лаатай нэг жижиг ширээг олж харав. Дани нэг хүүг лаа асааж байхыг ажиглав.

“Чи яагаад лаанууд асааж байгаа юм бэ?” гэж Даниг асуухад нөгөөх хүү инээмсэглэн, “Би онцгой зүйлүүдийн төлөө залбирахдаа лаа асаадаг. Дөл нь дүрэлзэхийн хэрээр Бурхан миний залбирлыг сонссоор байгаа гэдэгт би итгэдэг” гэлээ.







"Бид бүх хүнийг хайрлан, сайн сонсогч нь байж, чин сэтгэлээсээ шүтэж байгаа сүсэг бишрэлийг нь үнэн сэтгэлээсээ сонирхож байгаагаа харуулах ёстой" гэсэн билээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс, "Бусдыг хайрлаж, өөр үзэл бодол бүхий хүмүүстэй зэрэгцэн амьдрах нь," *Лиакона*, 2014 оны 11-р сар, 27

Данид эдгээр лаа нь энгийн лаанууд шиг л харагдаж байлаа. Тэр бага зэрэг гайхсан боловч эелдэг байхыг хүсэв. Тэр хүү рүү хараад инээмсэглэсэн юм.

Даниг гэр бүлийнхэнтэйгээ хамт суухад оройн залбирал эхэллээ. Тэр хэдэн эгнээний ард тэр хөвгүүнтэй адилхан нэг эрэгтэй хүүхэд байгааг олж харав. Тэгээд тэрээр хүмүүсийн дуулж байсан дуунуудаас алийг нь ч мэдэхгүй байгаагаа ойлгожээ. Тэд залбирахдаа нэг жижиг номноос уншиж байв. Бүх зүйл түүний мэддэгээс өөр байлаа.

Танил биш байсан ч хөгжим сайхан сонсогдож байв. Дараа нь нэг эрэгтэй хүн судраас уншихаар босож зогслоо. Тэр бишоп шиг нь костюм өмсөж, зангиа зүүхийн оронд өмсгөл өмссөн байв. Түүнийг уншиж эхлэхэд Дани энэ түүхийг мэддэгээ ойлгосон юм! Тэр Есүс 10 уяман өвчтэй хүнийг эдгээсэн талаар уншиж байлаа.

"Аав аа, Би энэ түүхэнд дуртай" гэж Дани шивнэв.

Аав нь инээмсэглэн, "Би ч гэсэн" гэлээ.

Дараа нь өмсгөл өмссөн тэр хүн залбирал хэлэв. Тэр өвчтэй болон гачигдсан хүмүүсийг адислахыг Бурханаас гуйв. Данийн залбирдаг шиг! Тэр бас сүмийн удирдагчдаа онцгойлон адислахыг гуйв. Дани гэр бүл нь үргэлж ерөнхийлөгч Томас С.Монсонг болон түүний зөвлөхүүдийг адислахыг Тэнгэрлэг

Эцэгээс гуйж залбирдаг талаар саналаа.

Данийн зүрх сэтгэлд халуун дулаан мэдэрэмж төрөв. Хэдийгээр тэд өөр сүмд явж, тэдэнд сайн мэдээний бүрэн байдал байхгүй ч Тэнгэрлэг Эцэг *бүх* хүүхдэдээ хайртай бөгөөд тэдний *бүх* залбирлыг сонсдог гэж хэлж, Тэнгэрлэг Эцэг түүнд ч бас байгааг тэр мэдсэн юм.

Тэднийг явахаар босоход аав нь утсаа шалгалаа. Тэр мессэжээ уншиж байхдаа гунигтай байгаа нь харагдав. "Монсон эгч нас барсан байна" гэж тэр хэллээ.

"Үгүй байлгүй дээ!" Дани ерөнхийлөгч Монсоны төлөө зүрх сэтгэлдээ хурдхан залбирав.

Хэн нэгэн "Чи зүгээр үү" гэж асуулаа. Энэ бол түүний урд сууж байсан хүү байв. Тэр Даниг сонсоод, санаа нь зовсон байдалтай байв.

"Монсон эгч нас барсан байна. "Тэр манай бошиглогч, ерөнхийлөгч Монсоны эхнэр байсан юм" гэж Дани хэлжээ.

"Би харамсаж байна". "Би түүний төлөө лаа асаах болно" гэж тэр эелдгээр хэллээ.

Дани инээмсэглээд, түүнд талархлаа илэрхийлэв. Ерөнхийлөгч Монсоны төлөө онцгойлон залбирах болно гэж хэлсэн нь түүний сайхан сэтгэлийн илрэл гэж тэр бодов. Тэнгэрлэг Эцэг түүний зүрх сэтгэлдээ хэлсэн залбирлыг болон тэр хүүгийн залбирлыг ч бас сонсох болно гэдгийг Дани мэдэж байлаа. ■

*Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.*







Арванхоёр  
Төлөөлөгчийн  
Чуулгын  
ахлагч  
Рассэлл М.Нэлсон


Арванхоёр Төлөө-  
лөгчийн Чуулгын  
 гишүүд бол Есүс  
Христийн онцгой  
гэрчүүд юм.

# ДУУЛГАВАРТАЙ БАЙХ НЬ


яагаад тийм чухал байдаг вэ?



Зарлигуудыг сахих нь  
адислалуудыг үргэлж авчирдаг!



Зарлигуудыг зөрчих нь адислалуудыг  
үргэлж алдаж байдаг!



Хэдийгээр "хүн бүр үүнийг  
хийж байгаа ч гэсэн" буруу  
зүйл хэзээ ч зөв болдоггүй.



Та нар Бурханд дуулгавартай  
байснаар итгэлээ харуулж байдаг.



“Энэ бол  
ЭЗЭНий бүтээсэн  
өдөр юм. Үүнд  
хөгжилдөн  
баярлацгаая.”

—Дуулал 118:24





# Есүс уяман ӨВЧТЭЙ ХҮНИЙГ ЭДГЭЭВ



Эрин Сандерсон

Өвчтэй байсан үеийнхээ тухай бод. Хэн нэгэн таныг эдгэрэхэд туслахын тулд ямар нэг сайн зүйл хийсэн үү?

Бид Шинэ Гэрээнээс Есүс өвчтэй байсан хүмүүст хэрхэн сайхан сэтгэлээр ханддаг байсан талаар уншдаг. Нэг өдөр уяман өвчин гэгддэг арьсны өвчтэй нэгэн хүн Есүс дээр ирэв. Есүст өвчтэй хүн бүрийг эдгээх хүч байгаа гэдгийг тэр мэдэж байв. Есүс түүнийг эдгээж чадна гэдэгт тэр итгэж байлаа. Есүс уяман өвчтэй хүнд хүрч, “Цэвэрш” (Марк 1:41) гэлээ. Есүс ингэж хэлмэгц тэр эдгэрэв.

Бид өвчтэй эсвэл гунигтай байгаа бусдад сайхан сэтгэлээр хандаж, бас хайрласнаар Есүсийн жишээг дагаж чадна. ■

*Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.*

## ГЭР БҮЛЭЭРЭЭ ЯРИЛЦАХ САНААНУУД

Та Марк 1:40–42 дахь түүхийг ярихдаа 74-р хуудсан дээрх судрын зургийг ашиглаж болно. Дараа нь та Иуда 1:22-ыг уншиж, хэн нэгний амьдралыг өөрчлөхийн тулд гэр бүлээрээ ямар нэгэн зүйлийг хийх төлөвлөгөө гаргаж болох юм. Магадгүй та нар хэн нэгэнд нууцаар үйлчлэл хийж болох шүү дээ!

**Дуу:** “Tell Me the Stories of Jesus,” (*Children’s Songbook*, 57).

**Судрууд:** Марк 1:40–42

**Видео бичлэгүүд:** “Есүс хүндэтгэлийн өдөр уяман өвчтөнг эдгээв” мөн “Есүс төрөлхийн сохор хүнийг эдгээв” зэргийг үзэх бол [Biblevideos.org](http://Biblevideos.org) хаягаар орж үзнэ үү.





## ЕСҮСИЙН МӨРӨӨР АЛХАХ НЬ

Гэр бүлээрээ ийм нөхцөлд  
байгаа хүмүүст хайраа хэрхэн үзүүлж  
болохыг жүжиглэн тогло. Заримыг  
өөрсдийнхөө нөхцөл байдлаар  
зохиож болно!



Нэгэн шинэ гэр бүл танай хөрш болж, шилжиж ирэв.

Зарим хүүхэд сургууль дээрээ бусдад муу ханддаг.

Сүм дээр хэнийг ч таньдаггүй нэг хүүхэд Хүүхдийн хэсэгт ирэв.

Та нарын эрэгтэй эсвэл эмэгтэй дүүтэй чинь тоглох хүн алга.

Нялх дүү чинь уйлж, ээж чинь оройн хоолоо хийхээр хичээж байна.

Тойрог эсвэл салбарын тань нэгэн хүн өвчтэй байгаа учраас гэрээсээ гарч чадахгүй байна.

## САЙН МЭДЭЭНҮҮДЭЭС ИЛҮҮ ДЭЛГЭРЭНГҮЙ СУРАЛЦ.


Есүсийн зарим дагалдагчийн бичсэн, Сайн мэдээнүүд хэмээн нэрлэгддэг дөрвөн онцгой ном Шинэ Гэрээн дээр байдаг. Сайн мэдээнүүд нь Есүс Христийн дэлхий дээр амьдарч байсан үеийн талаар өгүүлдэг. Уяман өвчтэй хүнийг эдгээж буй энэ түүх нь Сайн мэдээнүүдийн гуравт нь бичигдсэн байдаг. Энэ нь Марк 1:40–42, Матай 8:2–4 болон Лук 5:12–14 дээр байдаг.

## СУДРЫН ЗӨВЛӨГӨӨ: ҮГ ХАЙЛТ

Марк 1:41 дээр *өрөвдөх* гэдэг үгийг ашигладаг. Заримдаа Библи дээр та нарын ойлгохгүй хэцүү үг хэллэгүүд байдаг. Та нар мэдэхгүй үгтэй таарвал та нарт туслах Судруудын удирдамжийг ашиглаж болно. Жишээ нь, “Өрөвдөх” гэдэг нь юу гэсэн утгатай болохыг олж мэдэхийн тулд, бас энэ үгийг ашигласан бусад судрыг олохын тулд та энэ үгийг харж болно. Есүс уяман өвчтэй хүнийг эдгээж байгаа энэ түүхэн дэх өөр ямар үгийг та нар харж болох вэ?

# Есүс өвчтэй хүмүүсийг эдгээв

Марк 1:40–42; Лук 4:38–40



Цугларсан олон

Энэ хуудсыг зузаан эсвэл картон цаасан дээр цавууд. Дараа нь зургуудаа хайчилж, тэдгээрийг гараар урла, эсвэл цаасан хайрцгандаа хий. Шинэ Гэрээний түүхүүдийг жүжигчлэн тоглохдоо тэдгээрийг ашигла. *Ta liahona.lds.org* хаягаар орж, илүү олон хувийг хэвлэн авч болно.



Есүс Христ



Уяман өвчтэй хүн



Петрийн хадам ээж





Далын  
ахлагч  
Клаудио Д.Зивик

# ЗӨВ зам



*“Та нарыг бий болгосон Бурханы үгийг сонс”  
(С ба Г 43:23).*

Олон жилийн өмнө би гэр бүлийнхэнтэйгээ хамт АНУ-ын Юта дахь Арчэс үндэсний хүрээлэн рүү явсан юм. Цэцэрлэгт хүрээлэн дэх хамгийн үзэсгэлэнтэй, алдартай аркуудын нэгийг Дэликэйт арк гэдэг бөгөөд бид аркад хүрэхийн тулд уул руу авирахаар шийдлээ.

Бид аяллаа их л урам зоригтой эхэлсэн боловч хэсэгхэн зуур яваад л нөгөө хэд маань амрах хэрэгтэй болов. Би тэнд хүрэх хүсэлдээ хөтлөгдөн, цааш ганцаараа явахаар шийдлээ. Алхаж яваа замаа анхаарахын оронд урд минь маш итгэлтэй урагшилж яваа мэт санагдсан нэгэн залуут би дагав.

Зам улам бүр хэцүү болж байлаа. Гэр бүлийнхнээ аркад хэзээ ч хүрч чадахгүй юм байна гэдэгт би итгэсэн байв. Гэнэт би Дэликэйт аркыг олж харсан ч,

миний хувьд хүршгүй газарт байгааг үзээд, алмайрч орхилоо. Явсан зам маань арк руу хөтөлсөнгүй.

Урам минь ихэд хугарч, буцахаар шийдлээ. Би буцадтайгаа уулзахыг тэсэж ядан хүлээж байв. Гэтэл тэд зам заасан тэмдгүүдийг анхааралтай, хичээнгүйлэн даган явсаар Дэликэйт аркад очсон гэдгээ надад хэллээ. Харамсалтай нь, би буруу замаар явсан байжээ. Би ямар гайхалтай сургамж авсан гээч!

Тэнгэрлэг Эцэгт эргэн очих мөнх амьдрал руу хөтлөх замаасаа бүү гаж. Өөрсдийнхөө суралцсан сайн мэдээний зарчмууд ба зарлигуудыг дага. Тэгвэл та нар Түүнтэй үүрд хамт амьдрах зөв зам дээрээ үлдэх болно. ■

*“Буруу замаар эс явцгаая,” хэлсэн үгээс, Лиакхона, 2014 оны 5-р сар, 39–41-р хуудас*



# Есүс надад хайртайг би мэднэ

Жэйн Макбрайд Чөүт

Бодит түүхээс сэдэвлэв





Лэни сүм дээр  
хүндэтгэлтэй байхын  
тулд маш их хичээж  
байлаа. Гэвч тэр  
ядарч, босож  
явахыг хүсэж  
байв.




Ариун ёслолоос хүртэж дууссаны  
дараа Лэни Есүсийн тухай номоо  
нээлээ. Тэр бяцхан хүүхдүүдтэй  
хамт байгаа Есүсийн зургийг олов.  
Энэ нь түүнийг тайвшруулж, аз  
жаргалтай болгожээ.

*Үргэлжлэл нь 79-р хуудсанд байгаа.*





1-Хайчлах



8

Аврагч маань надад хайртайг би мэднэ  
Үгийг Тами Жэптсон Кримэр, аяыг Дэрена Бэлл

1

5

Би Есүст хүрч, Түүний өвөр дээр суугагүй ч,  
Тэр миний хувьд бодит билээ.

4

Бяцхан хүүхдүүдийг хайрладаг хайраараа  
Тэр намайг хайрлагийг би мэднэ.

4-Хайчлах



3-Нугалах

2-Нугалах




Олон жилийн тэртээ нэгэн үзэсгэлэнтэй газарт хүүхдүүд Есүсийг тойрон цуглав.

2



Би зүрх сэтгэлээ Түүнд өгнө. Аврагч маань надад хайртайг би мэднэ.

7



Тэрээр хүүхдүүдэд зааж, тэднийг адислах үед хүүхдүүд түүний хайрыг мэдэж байлаа. Бүгд Түүний нулимсыг харав.

3



Түүнийг амьд гэдгийг би мэднэ! Би Түүнийг итгэлтэй дагана.

6





Ариун ёслолын цуглаан дууссаны дараа Лени ээжээсээ “Есүсийн тухай номоо үзэх нь яагаад надад хүндэтгэлтэй байхыг минь амархан болгодог юм бол?” гэж асуув.

“Энэ нь Есүс чамд хэр их хайртайг сануулдаг учраас амархан болгодог байх гэж би бодож байна” гэж ээж хэлэв.

Лени толгой дохилоо. “Би бас Өөрт нь хайртайг Есүс мэддэг гэж та бодож байна уу?” гэж тэр асуув.

Ээж нь Лениг тэврээд, “Тийм ээ, тэгэлгүй яахав” гэлээ. ■



*Зохиогч нь АНУ-ын Колорадод амьдардаг.*

Энэ сард Тэргүүн Зөвлөл гишүүдээ гэр бүлийн үдэш хийхэд урамшуулан дэмжсэний 100 жилийн ой тохиож байна. Гэр бүлийн үдшийн талаар танилцуулсан Тэргүүн Зөвлөлийн захидлаас авав. Энэ нь 1915 оны 4-р сард гарсан бөгөөд 1915 оны 6-р сард Improvement Era (733–734-р хуудас) дээр хэвлэгдсэн. Том үсэг ба цэг тэмдгийг орчин үеийн дүрмээр өөрчлөв.

**Х**үндэт ах, эгч нар аа:  
Бид хожмын үеийн гэгээнтнүүдэд Сургаал ба Гэрээний 68 дахь хэсэгт өгөгдсөн Их Эзэний зарлигийг илүү чанд дагахыг зөвлөж байна:

*“Мөн дахин, Сионд . . . эцэг эхчүүд хүүхдүүдтэй байхын хэрээр, тэдэнд наманчлалын сургаал, амьд Бурханы Хүү Христэд итгэх итгэл хийгээд баптисм хүртээхийг, мөн гар тавилтаар ирдэг Ариун Сүнсний бэлгийг ойлгохыг тэд заадаггүй бол, тэднийг найман нас хүрэхэд уг нүгэл эцэг эхчүүдийнх нь тэргүүн дээр байх болно; . . .*

*“Мөн тэд тэрчлэн залбирахыг, мөн Их Эзэний өмнө цэх шулуун алхахыг хүүхдүүдээ заах ёстой” [С ба Г 68:25–28-ыг үзнэ үү].*

Сионы хүүхдүүд нь эртний израильчуудад өгөгдөж, мөн хожмын үеийн гэгээнтнүүдэд дахин өгөгдсөн Их Эзэний зарлигуудыг бүрэн дүүрэн дагаж мөрдөх ёстой:

*“Их Эзэн Бурхан тань чамд өгсөн тэр нутаг дээр чиний өдрүүд урт байж болохын тулд Эцэг, эхээ хүндэл” [Египетээс гарсан нь 20:12].*

Эдгээр илчлэлт хожмын үеийн гэгээнтнүүд рүү илүүтэй чиглэж, эдгээр зарлиг гэр оронд тань заагдаж, мөн хэрэгжиж болохын тулд Сүм дэх эцэг эхчүүдээс үүнийг шаарддаг болой.

Энэхүү зорилгын тул бид Сүм даяар эцэг эхчүүд охид, хөвгүүдээ гэр орондоо цуглуулж, мөн тэдэнд Их Эзэний үгийг зааж болохын тулд “гэр бүлийн үдшийг” эхлүүлэхийг зөвлөмж болгож, мөн уриалж байна. Тэд мөн гэр бүлүүдийнхээ хэрэгцээ, шаардлагуудыг илүү бүрэн дүүрэн олж мэдэхийн зэрэгцээ өөрсдийгөө болон хүүхдүүдээ Есүс Христийн сайн мэдээний зарчмуудтай илүү

## Гэр бүлийн үдшийн 100 жилийн ой



сайн танилцуулах болно. Энэхүү гэр бүлийн үдэш нь залбирал, дуулал болон дуунууд дуулах, хөгжим тоглох, судар унших, гэр бүлийн сэдвүүд болон сайн мэдээний зарчмууд, мөн амьдралын ёс зүйн асуудал дээрх тодорхой зааварт, түүнчлэн эцэг эх, гэр орон, Сүм, нийгэм, улс үндэстэндээ хүлээх үүрэг, хариуцлага дээр төвлөрөх ёстой. Бага насны хүүхдүүдэд тэдний

насанд тохирсон уншлага, дуу, түүх болон тоглоомыг танилцуулж болох юм. Ихэнхдээ гэртээ бэлтгэсэн хөнгөн зуушаар үйлчилж болно.

Албархаг болон хөшүүн байдлаас аль болох зайлсхийх хэрэгтэй бөгөөд гэр бүлийн гишүүн бүр эдгээр үйл ажиллагаанд оролцох хэрэгтэй.

Эдгээр цугларалт нь эцэг эх, хүүхдүүдийн хооронд, мөн ах, эгч, дүү нарын хооронд харилцан итгэх

боломжийг олгож, эцэг эх нь охид, хөвгүүдээ сэрэмжлүүлэг, зөвлөгөө, зөвлөмжийн үгсээр хангах боломж бүрдэнэ. Тэдгээр нь тэдэнд хандсан Их Эзэний амлалт үгчлэн биелэгдэж, тэдний өдрүүд урт, аз жаргалтай байж болохын тулд эцэг эхээ хүндэлж, гэр орондоо байгаа адислалуудын төлөө талархах боломжийг охид хөвгүүдэд олгоно. . . .

Бид . . . залуучуудыг гэр бүлийн үдшээр гэртээ үлдэж, үүнийг сургамжтай, ашигтай, сонирхолтой болгоход өөрсдийн хувь нэмрийг оруулахад урамшуулан дэмжиж байна.

Гэгээнтнүүд энэ зөвлөгөөг дуулгавартай дагавал агуу адислалууд ирэх болно гэдгийг бид амлаж байна.

Гэр орон дахь хайр болон эцэг эхдээ дуулгавартай

байх явдал өсөн нэмэгдэх болно. Израилийн өсвөр үеийнхний зүрх сэтгэл дэх итгэл өсөж, тэд тойрон хүрээлэх хилэнцэт нөлөө, уруу таталтуудтай тэмцэх хүч чадлыг олж авах болно.

Хүндэтгэсэн,  
ЖОЗЕФ Ф.СМИТ  
АНТОН Х.ЛАНД  
ЧАРЛЬЗ В.ПЭНРӨҮЗ  
Тэргүүн Зөвлөл ■



# ОЙЛГОЛТ



## Би гэр бүлийн үдшээ хэрхэн эн тэргүүнд тавих вэ?


“Гэр бүлээ хүчирхэгжүүлж, амар амгалангийн үрийг суулгахаар ажиллах үедээ . . . долоо хоног бүрийн гэр бүлийн үдшийг санаарай. Амсхийх ч хором гараагүй ажлын өдрийн дараа гэр бүлийн үдшээ оромдоод өнгөрөхөөс болгоомжил. Гэр бүл тань даваа гараг бүрийн үдэш гэр орондоо хамтдаа цугладаг байхаар хатуу тогт. Ажилтай холбоотой зүйлс, спорт, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, гэрийн даалгавар болон бусад асуудал нь гэр бүлээрээ, гэр орондоо цагийг хамтдаа өнгөрүүлэхээс илүү чухал байж таарахгүй. Гэр бүлийн үдшийн тань бүтэц үүнд зориулсан цаг хугацаанаас илүү чухал биш юм. Сайн мэдээг албан болон албан бус хэлбэрийн аль алинаар нь заах ёстой. Үүнийг гэр бүлийн гишүүн бүрийн хувьд утга учир бүхий туршлага болго.”

# Энэ дугаарт

## ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

### Итгэлтэй УРАГШИЛ

Нифайн амьдралаас авсан эдгээр дөрвөн  
ойлголт нь амьдралдаа шийдвэр гаргахад  
тань итгэл найдвар өгч чадна.



44-р  
хуудас

## ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ



50-р  
хуудас

### ИОСЕФЫН АЧААР

Бошиглогч Иосеф Смитийн ачаар таны  
амьдрал хэрхэн өөр байгаа вэ? Эдгээр  
6 арга замыг бодож үз.

## ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

### ЕСҮС ХРИСТ НАДАД ХАЙРТАЙГ БИ МЭДНЭ

Сүм дээр байхдаа хүндэтгэлтэй  
байхад чинь туслах өөрийн  
товхимлыг бүтээ.



76-р  
хуудас

ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

